

МОДУЛЬ

4

**ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД
ҮЗҮҮЛЭХ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН
ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ**



МОДУЛЬ 4

**ХУЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД
ҮЗҮҮЛЭХ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН
ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ**

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар боловсруулсан: Др. Гэлэнхүүгийн Түмэннаст (PhD)

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй НҮБ-ын “Итгэлцлийн Сан”-гийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулж, хэвлүүлэв.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Модулийг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс 2023 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	7
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	8
НЭГ. ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ ХЭЛБЭР	12
1.1. Үндсэн ойлголт	13
1.2. Онолын үндэслэл	15
1.3. Арга зүй, аргачлал	18
1.4. Практик хэрэглээ, сайн туршлага	21
ХОЁР. ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	24
2.1. Үндсэн ойлголт	25
2.2. Онолын үндэслэл	25
2.3. Арга зүй, аргачлал	30
2.4. Практик хэрэглээ, сайн туршлага	36
ГУРАВ. ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	40
3.1. Үндсэн ойлголт	41
3.2. Арга зүй, аргачлал	46
3.3. Практик хэрэглээ, сайн туршлага	50
ДӨРӨВ. ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ	55
4.1. Үндсэн ойлголт	56
4.2. Арга зүй, аргачлал	59
4.3. Практик хэрэглээ, сайн туршлага	64
ТАВ. ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ НЬ	67
5.1. Үндсэн ойлголт	68
5.2. Арга зүй, аргачлал	69
5.3. Практик хэрэглээ, сайн туршлага	73
НОМ ЗҮЙ.	76

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн эрхийг хүндэтгэн хангах, хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын, бие даасан, хараат бус иргэний нийгмийн байгууллага юм. ХИС-гийн Хүүхэд хамгааллын хөтөлбөр нь НҮБ-ын Итгэлцлийн Сан (UN Trust Fund)-гийн санхүүжилтээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг гурван жилийн (2021-2024) хугацаатай, нийслэлийн Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ, НҮБ-ын хороодын дүгнэлт зөвлөмжүүдэд охин хүүхдийг бэлгийн болон бусад төрлийн мөлжлөгөөс хамгаалж, хүчирхийллийн аливаа хэлбэрээс охидыг хамгаалах, нэр төрийг нь хүндэтгэхийг эрхэмлэх ёстойг онцлон тэмдэглэдэг. Монгол Улсад хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа хэдий ч жендэрт суурилсан хүчирхийлэл, охидын эсрэг хүчирхийллийн тоо буурахгүй хэвээр байгаад зовниж, Хүүхдийг Ивээх Сан охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилго тавин ажиллаж байна.

Төслийн хүрээнд бид хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй арга зүйг нэвтрүүлэх зорилго бүхий 11 модулиас бүрдэх багц гарын авлагыг боловсруулан та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Тус гарын авлага нь хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийн хүүхэд хамгааллын тогтолцоо, салбарын ажилтнуудын оролцоо, үүрэг, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх үндсэн ойлголт, сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй (хохирогч/даван туулагчид ээлтэй) арга зүй, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ, кейс менежмент, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон охидод үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажлаас халшрах хам шинжийн талаарх ойлголтыг өгч, хүүхдэд сэтгэцийн дам гэмтэл учруулахгүйгээр, цаг алдахгүй мэргэжлийн үйлчилгээг чанартай үзүүлэх үр чадварыг өсгөх зорилготой юм.

Олны хүч оломгүй далай гэдэг ээ.

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох, эрхээ ялгаварлалгүй эдэлдэг, хариуцлагатай нийгмийг цогцлоох үйлст хувь нэмрээ оруулж, сургалтын энэхүү багцын “Модуль 4. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ” хэсэгт гэрээлэн ажилласан эрдэмтэн, судлаач Др. Гэлэнхүүгийн Түмэннаст (PhD) болон Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтаа талархал илэрхийлье.

Энэ чиглэлээр бидний нэгэн адил хувь нэмэр оруулж, Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж байгаа зорилго нэгт, хөгжлийн болон хүмүүнлэгийн бүх түншүүддээ талархал илэрхийлье.

Энхбатын Цолмон

ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

Багц гарын авлагын 11 модуль тус бүрийн хоорондын уялдаа холбоо, зорилгыг доорх хүснэгтэд харууллаа.

Модулийн нэр	Зорилго
Модуль 1 Хүүхдийн эрх, хамгаалал ба хүүхэд хамгааллын бодлого	Хүүхдийн эрх, эрхэд суурилсан хандлага, хүүхдийн хамгаалагдах эрх, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга зам, бодлогын талаар онол, практик хэрэглээ, сайн туршлагыг танилцуулах
Модуль 2 Хүүхэд хамгааллын үйлчилгээ ба кейс менежмент	Хүүхэд хамгааллын шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин тус бүрд хамгааллын үйлчилгээ хүргэх, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээг хэрхэн хүргэх
Модуль 3 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ	Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байранд байрлаж буй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нас, сэтгэцийн онцлогт тохирсон үйлчилгээг хэрхэн үзүүлэх, үйлчилгээг стандартын дагуу сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч төвтэй байдлаар үзүүлэхэд анхаарах асуудал, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдэд анхан шатны болон хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх
Модуль 4 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ	Асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ, үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын үнэлгээний талаар үндсэн ойлголттой болж, хувилбарт үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний төлөвлөлт хийхэд баримтлах зарчим, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах
Модуль 5 Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн давуу талд тулгуурлан хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар арга зүйн үндсэн ойлголт, онолын үндэслэлийн талаар мэдлэг нэмэгдүүлэх, мөн хүчирхэг болгох амьдрах ухааны ур чадварыг олгох нийгмийн ажлын арга зүй, хандлага зэрэг талаар мэдээлэл өгөх
Модуль 6 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал	Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, хүүхдэд тохиолдох эрсдэл, үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, кейс менежмент, урьдчилан сэргийлэлтийн талаар ойлголт өгөх.
Модуль 7 Хүн худалдаалах гэмт хэрэг ба жендэрт суурилсан хүчирхийлэл	Жендэрийн үндсэн ойлголт, түүний эрх зүйн зохицуулалт, үндэсний тогтолцоо, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний төрөл хэлбэр, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг илрүүлэх, хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэг нэмэгдүүлэх

Модуль 8

Хүүхэд худалдаалах гэмт хэрэг-илрүүлэлтийн стратеги болон үйл явц

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, зохицуулалтын онцлог, хүүхдийг худалдаалж буй төрөл, хэлбэр, хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулах талаар нэгдсэн ойлголт өгөх.

Модуль 9

Сэтгэцийн гэмтэлд суурилсан, хохирогч/даван туулагч төвтэй арга зүй

Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт, төрөл, илрэх нийтлэг шинж тэмдэг, сэтгэцийн гэмтэл бие махбод, оюун санаа, сэтгэл хөдлөл, нийгмийн харилцаанд нөлөөлөх сөрөг нөлөө, дахин сэтгэцийн гэмтэлд урчлуулахаас урьдчилан сэргийлэхэд анхаарах зүйлс, сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээний зарчмуудын талаар ойлголт өгөх

Модуль 10

Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалах нь

Ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинжийн ойлголт, үүсэх үе шат, нөлөөлөх хүчин зүйл тухай мэдлэг олгоно. Хүүхэд хамгааллын ажилтнууд ажлаас халшрах хам шинжид өртөх шалтгаан, илрэх сөрөг үр дагавар, урьдчилан сэргийлэх сэтгэл зүйн бэлтгэх, ажлаас халшрах хам шинжийг үнэлэх аргачлал, түүнийг даван туулах сэтгэл зүйн заслын тусламжид суралцах болно.

Модуль 11

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагчдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ

Хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй шинжүүд, хохирогч/даван туулагчдад илрэх сэтгэл зүйн болон бие махбодын шинжүүдийг ялган таньж мэдэх, сэтгэцийн гэмтлийн тухай ойлголт, төрөл, нөлөөлөх хүчин зүйлс, хүчтэй стресст өгөх цочмог хариу урвалын тухай ерөнхий ойлголт, гэмтлийн дараах стрессийн эмгэг, түүнд хэрэглэх сэтгэл зүйн зөвлөгөөний арга техникүүдийн талаар анхан шатны мэдээлэл өгөх.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
МУ	Монгол Улс
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБ	Хамтарсан баг
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
ХНХЯ	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ХЭК	Хүүхдийн эрхийн тухай конвенц
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Асралт гэр бүл	Хүүхдийг гэр бүлдээ авч асран халамжлахаар зөвшөөрч, тодорхой шалгуурын дагуу сонгогдсон, эрх бүхий байгууллагатай хүүхэд асран халамжлах гэрээ байгуулж, тэдний удирдлага, дэмжлэг, хяналтын дор хүүхдийг тодорхой хугацаагаар асран халамжилдаг гэр бүлийг хэлнэ.
Асран халамжлах гэрээ	Эрх бүхий байгууллага болон орон нутгийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн байгууллага, төрөл, садан гэр бүл, асралт гэр бүлийн хооронд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, хамгаалах, боловсрол олгох, эрүүл мэндийг хамгаалах зэрэг нөхцөлүүд, эрх, үүрэг, тэтгэмжийн хэмжээ, гэрээ дуусгавар болох үндэслэл, үр дагавар зэргийг заасан тодорхой хугацаанд хийгдэх баримт бичгийг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Бие даан амьдрахад туслах дэмжлэг	Харгалзан дэмжигчийн асрамжид юм уу төвлөрсөн асрамж халамжийн газарт амьдарч байгаа 14-өөс дээш настай хүүхэд залуусыг бие даан амьдрахад нь бэлтгэж, дэмжлэг үзүүлэх халамжийн үйлчилгээг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Бүтэн өнчин хүүхэд	Эцэг эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх (эцэг) нь нас барсан 18 хүртэх насны хүүхдийг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Гэр бүлийн судалгаа	Эрх бүхий байгууллагаас хувь хүн, гэр бүлийн хүүхэд асрах орон байр, орчин нөхцөл, өрхийн орлогын түвшин, гэр бүлийн амьдралын хэв маяг, зан үйл, сэтгэлзүйн байдлыг судалж, үйлчилгээ үзүүлэх шаардлага хангасан тухай дүгнэлт гаргасан цогц судалгааг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Гэр бүлээс тусад нь үйлчлүүлэгчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ, нэг цэгийн үйлчилгээ-түр хамгааллын байрлуулах, төвлөрсөн асрамжийн үйлчилгээ, халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж), гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг хэлнэ (А. Батхишиг 2009; ХНХЯ, 2021).
Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ	Гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдийг өөрийн гэр бүлтэйгээ хамт амьдрах боломжоор хангахын тулд үзүүлж байгаа нийгмийн ажил, халамжийн үйлчилгээг (С.Тунгалагтамир, 2017) хэлнэ.
Кейс менежмент	Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эрсдэлт нөхцөлд байгаа үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн шууд үзүүлэх дэмжлэг, холбон зуучлалаар дамжуулан цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх мэргэжлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх арга замыг хэлнэ.

Нийгмийн ажлын шууд үйлчилгээ	Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай хувь хүн, гэр бүл, бүлэгтэй шууд харилцах, мэргэжлийн үйл ажиллагааг хэлнэ (Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022).
Нийгмийн ажлын шууд бус үйлчилгээ	Нийгэм, хүмүүсийн сайн сайхан байдлыг хангах нийгмийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, шаардлагатай хөрөнгө нөөцийг босгох, чадавх бэхжүүлэх, хууль эрх зүйн тогтолцоонд нөлөөлөх, хамтын ажиллагаа түншлэлийг өргөтгөх, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагааг хэлнэ (Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022).
Нийгмийн ажилтан	Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг хэлнэ (Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022).
Нийгмийн ажлын интервенц	Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэднийг хөгжүүлэхийн тулд нийгмийн ажилтны авч хэрэгжүүлэх үйлчилгээ, арга зүй, техникүүдийг (Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022).
Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат	Үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, тэднийг хөгжүүлэхийн тулд нийгмийн ажилтны авч хэрэгжүүлэх үйлчилгээ, арга зүй, техникүүдийг (Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022).
Нөхцөл байдлын үнэлгээ	Үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг хэлнэ (А.Батхишиг, 2017).
Сэтгэцийн гэмтэл	Хувь хүний сэтгэцийн гэмтэл нь бие махбод, сэтгэл санааны хувьд хор хөнөөлтэй, амь насанд нь заналхийлсэн үйл явдал, цуврал үйл явдал, бүрдэлбэр нөхцөл байдлын улмаас үүдэлтэй бөгөөд хувь хүний үйл ажиллагаа, сэтгэц, бие махбод, нийгэм, сэтгэл хөдлөл, хийгээд оюун санааны сайн сайхан байдалд урт удаан хугацааны хор хөнөөлийг хэлнэ (Huang, 2014).
Төрөл садан хүний асрамж халамж	Асран хамгаалал, харгалзан дэмжлэг шаардлагатай хүүхдийг төрсөн ах, эгч, төрлийн болон садангын хүний гэр бүл өөрийн гэр бүлдээ авч асран хамгаалах үйл ажиллагааг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байршуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг хэлнэ (УИХ, 2013).
Төвлөрсөн асрамж халамжийн байгууллагад түшиглэн асрахуй	Хүүхдийн асрамж халамжийн төвлөрөл бөгөөд төрөлжсөн асрамж халамжийн байгууллагад түшиглэн асрах үйлчилгээг илүү чухалчилж, ийм төрлийн үйлчилгээ аль нэг улс оронд зонхилж ирэх үйл явц юм. Үүнийг хүүхдийн асрамжийн төрөлжсөн байгууллагад төвлөрөх үйл явцыг хэлнэ (Buia, 2012).

Төвлөрсөн асрамж халамжаас хувилбарт үйлчилгээнд түшиглэхүй	Хүүхдийн асрамж халамжийн төвлөрлийг сааруулах буюу төрөлжсөн асрамж халамжийн байгууллагаас бусад хувилбаруудыг илүү чухалчилж, хувилбарт үйлчилгээнүүдийг хөгжүүлэх, өргөжүүлэх үйл явц юм. Үүнийг хүүхдийн асрамж халамжийн төвлөрлийг сааруулах үйл явцыг хэлнэ (Buia, 2012).
Үйлчилгээний аргагүй	Үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэхдээ хэрэглэхээр сонгон авсан мэргэжлийн ерөнхий арга болон тусгай арга зүйг хэлнэ (Galuske, 2015).
Үйлчилгээний төлөвлөлт	Нийгмийн ажлын үйлчилгээний үндсэн үе шатын нэг бөгөөд үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд мэргэжлийн интервенцүүдийг (шууд ба шууд бус үйлчилгээнүүдийг) хэзээ, хэрхэн, яаж хүргэх талаар хийсэн төлөвлөлтийг хэлнэ (Батхишиг А., 2017).
Үйлчилгээг үнэлэх нь	Нийгмийн ажилтан үзүүлж буй үйлчилгээнийхээ үйл явц, хэрэгжилт, үр нөлөөний талаар үйлчлүүлэгч болон бусад талуудаас байнга мэдээлэл цуглуулж, тэдэнтэй хэлэлцэх үйл явцыг хэлнэ.
Үнэлгээ	Үйлчилгээ болон интервенцийн үр дагавар, үр нөлөөний талаар мэдээлэл цуглуулж, ажиглан дүгнэлт хийх, үйлчлүүлэгчийн амьдралын чанар, сайн сайхан байдлыг тогтвортой байлгах үүднээс цаашдын зөвлөмж өгөх үйл ажиллагааг хэлнэ.
Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ	Хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ. Үйлчлүүлэгч, түүний гэр бүлд нөлөөлөх, хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ (А. Батхишиг, 2009, 2011, 2022).
Хүүхдийн халамжийн үйлчилгээ	Хүүхдийн аюулгүй байдал хийгээд гэр бүлүүдэд үр хүүхдээ амжилттай асран халамжлахад нь зайлшгүй тусламж дэмжлэгийг баталгаажуулахад чиглэсэн үйлчилгээнүүд юм. Энэ нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрахаас урьдчилан сэргийлэх үйлчилгээг дэмжих, зохицуулах, хүүхдээ асран хамгаалахад тусламж дэмжлэг шаардлагатай гэр бүлүүдэд үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхралтыг мэдээллийг хүлээн авах, мөрдөн шалгах, хүүхэд гэр бүлийн хэрэгцээ, давуу тал, нөөцийг үнэлэх, гэр бүлд аюулгүй байдал хангагдахгүй хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах, эдгээр хүүхдийн олон талт хэрэгцээг анхаарах, асрамжийг орхиж буй хүүхэд, залуучуудыг гэр бүлд эргэн нэгтгэх, үрчлэх, бусад гэр бүлийн холбоог бий болгоход оролцогч талуудтай хамтран ажиллах зэргийг хамарсан ойлголт юм (Factsheet, 2018). Халамжийн үйлчилгээ нь хүүхдийн хүүхдийн сайн сайхан байдлын төлөө, тэдний эсэн мэнд өсөн торних, хөгжих, төлөвших орчныг хангахад чиглэнэ. Хүүхдийн халамжийн үйлчилгээнд тэтгэмж, асран халамжлах үйлчилгээ, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ (С.Энхтуяа, 2010).

Хүүхэд асрах үйлчилгээ	Хүүхдэд гэр бүл, эцэг эхтэйгээ богино болон урт хугацаагаар хамт амьдрах боломжгүй болсон үед эдгээр хүүхдэд гэр бүл, эцэг эхийг орлох бусад гэр бүлд болон төвлөрсөн асрамжид байрлуулан асран, халамжлах, хамгаалах үйлчилгээг хэлнэ (Батхишиг. А, 2009, Энхтуяа С. 2010).
Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгч	Эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан тусгай зөвшөөрөл, шийдвэртэй байгууллага, хувь хүн, гэр бүлийн гишүүдийг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Хүчирхийлэлд өртсөн хүүхэд	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд гэж бие махбодын шийтгэл, үл хайхрах байдал, мөлжлөг, бэлгийн болон сэтгэл санааны дарамтын хохирогч болсон хүүхдийг хэлнэ (УИХ, 2017).
Хяналт-шинжилгээ	Үйлчилгээ болон интервенцийн орц, үйл ажиллагаа, гарцын талаар мэдээлэл цуглуулж, ажиглаж дүгнэлт хийх, эргээд тэдгээрийг сайжруулах зорилготой үйл ажиллагааг хэлнэ.
Эрх бүхий байгууллага	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих цогц үйл ажиллагааг эрхлэх, гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18-р зүйлд заасан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагыг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).
Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд	Эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ (С.Тунгалагтамир, 2017).

НЭГ

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ ХЭЛБЭР

- 1.1 Үндсэн ойлголт
- 1.2 Онолын үндэслэл
- 1.3 Арга зүй, аргачлал
- 1.4 Практик хэрэглээ, сайн туршлага

1.1

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Энэ сэдвийн хүрээнд хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээ яагаад чухал болох талаар авч үзэх ба уг үйлчилгээний төрлүүдийн талаар, түүнчлэн тус бүрийн онцлогийн талаар дурдах болно. Эдгээр хувилбарт үйлчилгээний талаар нийгмийн ажилтан, бусад холбогдох хүүхэд хамгааллын ажилтнууд сайтар мэдэж байх учиртай.

Халамжийн үйлчилгээ нь хүүхдийн сайн сайхан байдлын төлөө, тэдний эсэн мэнд өсөн торних, хөгжих, төлөвших орчныг хангахад чиглэнэ. Хүүхдийн халамжийн үйлчилгээнд тэтгэмж, асран халамжлах үйлчилгээ, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ, нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө, нөхөн сэргээх үйлчилгээ зэргийг хамаарна (С.Энхтуяа, 2010). Хүүхдийн халамжийн үйлчилгээ нь хүүхдийн аюулгүй байдал хийгээд гэр бүлүүдэд үр хүүхдээ амжилттай асран халамжлахад нь зайлшгүй тусламж дэмжлэгийг баталгаажуулахад чиглэсэн. Хүүхдийн халамжийн үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна. Үүнд:

- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрахаас урьдчилан сэргийлэх үйлчилгээг дэмжих, зохицуулах
- Хүүхдээ асран хамгаалахад тусламж дэмжлэг шаардлагатай гэр бүлүүдэд үйлчилгээ үзүүлэх
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхралтыг мэдээллийг хүлээн авах, мөрдөн шалгах
- Хүүхэд гэр бүлийн хэрэгцээ, давуу тал, нөөцийг үнэлэх, гэр бүлд аюулгүй байдал хангагдахгүй хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулах
- Хүүхдийн олон талт хэрэгцээг анхаарах

Асрамжийг орхиж буй хүүхэд, залуучуудыг гэр бүлд эргэн нэгтгэх, үрчлэх, бусад гэр бүлийн холбоог бий болгоход оролцогч талуудтай хамтран ажиллах зэргийг хамарсан ойлголт юм (Factsheet, 2018).

Хүүхэд асрах үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны нэг хэсэг. Хүүхдэд гэр бүл, эцэг эхтэйгээ богино болон урт хугацаагаар хамт амьдрах боломжгүй болсон үед эдгээр хүүхдэд гэр бүл, эцэг эхийг орлох бусад гэр бүлд болон төвлөрсөн асрамжид байрлуулан асран, халамжлах, хамгаалах үйлчилгээг хүүхэд асрах үйлчилгээ гэж үзнэ (Батхишиг. А, 2009, Энхтуяа С. 2010). Хүүхэд асрах үйлчилгээг асрамж халамжийн төвлөрсөн ба хувилбарт үйлчилгээ гэж хуваадаг.

Хүүхдийн асрамж халамжийн хувилбарт үйлчилгээ нь төвлөрсөн асрамж халамжаас илүү чухалчлагдах болсон юм. Төвлөрсөн асрамж, халамжийн байгууллагад түшиглэх асрахүй гэдэг нь хүүхдийн асрамж халамжийн төвлөрөл бөгөөд төрөлжсөн асрамж халамжийн байгууллагад түшиглэн асрах үйлчилгээг илүү чухалчилж, ийм төрлийн үйлчилгээ аль нэг улс оронд зонхилж ирэх үйл явц юм. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан тусгай зөвшөөрөл, шийдвэртэй байгууллага, хувь хүн, гэр бүлийн гишүүд үзүүлэх тухай Монгол Улсын Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага: MNS 5852:2017-д заасан.

Институцийн асрамж буюу асрамж халамжийн төвлөрсөн байгууллагад хүүхдийг асрах үйлчилгээ нь дараах сул талууд бий болдог талаар эх сурвалжид тэмдэглэжээ (Buia, 2012).

Асрамж халамжийн төвлөрсөн байгууллага нь дийлэнхдээ нүсэр том бөгөөд гэр бүл болон жижиг бүлэгт ойр байх хүүхдийн хэрэгцээнд нийцтэй байдлаар бүтээгддэггүй. (институцийн асрамж халамж ялангуяа зөвлөлт маягийн социалист тогтолцоотой байсан орнуудад ноёрхож байна гэжээ)

Асрамж халамжийн төвлөрсөн байгууллагад хүүхдэд таатай бус нийтлэг шинж чанарууд бий болдог ба эдгээр нь хүүхэд бүрийн хувь хүний онцлог, давтагдашгүй байдлыг үл тоомсорлодог, хатуу хэв жаягийг чухалчилдаг, эмчилгээний хандлага давамгайлдаг, хүмүүс хооронд нийгмийн зай барьдаг, хамааралт байдал, хариуцлага дутмаг байдал зэрэг юм.

Улс орнуудад 0-3 настай нялх балчир хүүхдүүдийг төвлөрсөн асрамжид хамруулах туршлага нийтлэг байсаар ирсэн бөгөөд энэ нь тэдний бие бялдар, танин мэдэхүйн хөгжилд ноцтой нөлөө үзүүлдэг талаар тархи мэдрэлийн шинжлэх ухааны нотолгоо гарсаар байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эцэг эхийн хайр халамжгүй хоцрох, эсвэл эцэг эхчүүд ийм хүүхдээсээ татгалзах эрсдэлтэй үед төвлөрсөн халамж асрамжийн байгууллагад ханддаг, улмаар ийм үйлчилгээнд эмнэлгийн арга хандлага голлох бөгөөд олон нийтэд түшиглэсэн үйлчилгээ хомс байдаг байна.

Үндэсний цөөнх болон хүн амын ядуурал, нийгмийн гадуурхалд орсон хэсгээс ирсэн хүүхдүүд төвлөрсөн асрамжийн газарт байх нь эргээд ялгаварлан гадуурхал болон бусад зүй бус харилцааг дагуулах нь бий гэжээ.

Төвлөрсөн асрамж халамжийн байгууллагад амьдарч буй хүүхдүүдэд хохирол учруулж болзошгүй урт хугацааны нөлөөний талаар судалсаар байна. Эдгээр сөрөг үр дагавар нь олон хүчин зүйлээс шалтгаалж бий болох ба түүний дотор анхан шатны холбоо харилцаа бүхий асран хамгаалагч байхгүй, урам зориг, бүтээлч үйл ажиллагаа дутмаг; суурь үйлчилгээний хүртээмж муу, хүчирхийлэл, гэр бүлээс болон гадаад ертөнцөөс тусгаарлагдмал зэрэг юм. Олон тохиолдолд төвлөрсөн байгууллага буюу институцид суурилсан асрамжтай холбоотой асуудал их байдаг бөгөөд гэр бүлд эргэн нэгтгэх оролдлого хийгддэггүй, асрамжийн байр байдлыг (тогтвортой байдал ба хэрэгцээ) тогтмол хянадаггүй, асрамжийн дараа амьдралд бэлтгэхэд учир дутагдалтай байна (Nigel Cantwell, 2012).



Шигтгээ 1. НҮБ-ын Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний удирдамжийг хэрэгжүүлэх нь

Удирдамжид улс бүр өөрийн тусламж үйлчилгээний тогтолцоогоо аажмаар байгууллагад төвлөрсөн халамжаас шилжих стратеги боловсруулахыг уриалж байна. Үндэсний бодлого нь хүүхдэд зориулсан гэр бүл олон нийтэд түшиглэсэн олон янзын сонголт бүхий хувилбарт асрамжийг цогцлоох ёстой.

Үндэсний бодлого нь институцэд (төвлөрсөн байгууллага) суурилсан халамжаас шилжихэд чиглэх бөгөөд дараах зөвлөмж бий болно. Үүнд:

Хувилбарт тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлж институцийн халамжаас татгалзах үндэсний стратеги төлөвлөгөөг боловсруулна.

Жижиг бүл, асралт гэр бүл (түр зуурын асрамжаас урт хугацааны асрамж хүртэл) зэрэг байгууллагаас өөр асрамжийн олон сонголттой хувилбаруудыг хөгжүүлэх, эцэг эх, өргөжсөн гэр бүлд дэмжлэг үзүүлэх, бие даан амьдарч буй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх.

Институцийн халамжаас шилжих төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй болон бусад тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн хэрэгцээг харгалзан үзэх.

Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд 0-ээс 3 хүртэлх насны балчир хүүхдийг төвлөрсөн асрамжид хамруулахыг шууд хориглох: ах, эгч дүүсийг салгахгүй байх; төлөвлөсөн түр зуурын арга хэмжээ болгон; эсвэл яаралтай тусламжийн үеийн богино хугацааны хариу арга хэмжээ

Төвлөрсөн байгууллагын асрамжаас шилжих төлөвлөгөөнд гэр бүлд үзүүлэх дэмжлэгийг тусгасан байх ба ингэснээр хүүхдийг боломжтой бол гэр бүлд нь дахин нэгтгэх, үгүй бол илүү тохиромжтой асрамжийн хувилбарт хамруулах зэрэг болно (Nigel Cantwell, 2012).

Ер нь асрамж халамжийн төвлөрсөн байгууллагаас бусад хувилбаруудыг чухалчлан үзэх шалтгаанууд хангалттай бий бөгөөд тиймээс хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх, хүүхэд үнэхээр гэр бүлдээ байх боломжгүй нөхцөлд тэдгээр үйлчилгээнд хамруулахыг урьтал болгох нь зүйтэй билээ. Энэхүү сургалтын гарын авлагын хүрээнд ерөнхийдөө гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулах талаар авч үзнэ. Эдгээр хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх асуудал ихээхэн бэрхшээлтэй өөрөөр хэлбэл хүүхдэд эрсдэлтэй нөхцөлд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах юм. Хүүхдийн асрамж халамжийн хувилбарт үйлчилгээний нэг онцлог зорилтот бүлэг бол хүчирхийлэлд өртсөн, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд байдаг.

1.2

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нь гэр бүлийн асрамж халамж үгүй хүүхдийг асран халамжлах үйлчилгээний түүхэн хувьслын үр дүн ололт гэж хэлж болно. Ерөнхийдөө нийгмийн халамжийн түүхээс сонирхвол, хотжиж аж үйлдвэржээгүй, уламжлалт нийгэмд гэр бүлийн хайр халамжгүй хаягдсан хүүхдийг өргөжсөн гэр бүл, төрөл садангийн болон хүй элгэний (овог отог, айл саахалт, гол усныхан) тогтолцооны хүрээнд авч халамжилж ирсэн бол хотжиж, аж үйлдвэржсэнээр эдгээр хүүхдүүдийг төвлөрсөн асрамжийн газар авч асардаг эрин үетэй золгожээ. Үүнийг байгууллага төвтэй хүүхдийн асрамж халамжийн тогтолцооны үе хэмээн үздэг. Мэдээж өрнө болон дорно, түүх соёлын онцлогоос хамаарч дэлхийн өнцөг булан бүрд өвөрмөц өв туршлага бүтээгдсэнээр ирсэн нь дамжиггүй болов ч, байгууллагад төвлөрсөн үе нь өрнөдийн буюу христийн соёлт ертөнцийн халамжийн түүхэнд бичигдсэнээр 16-р зууны үеэс эхлэн үндсэндээ 20-р зууны сүүл хүртэл явсан гэж болно. Гэвч, түрүүлж болон хожуу аж үйлдвэржсэн, хотожсон, хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын хувьд харилцан адилгүй билээ. Монгол Улсын хувьд уламжлалт буюу хүй элгэний асрамж халамжийн үе явсаар 20-р зууны эхний хагастай золгосон бөгөөд хүүхдийн төвлөрсөн асрамж халамж нь социалист тогтолцооны хөгжилтэй холбоотой. Харин 10-аад жилийн өмнөөс хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх үзэл баримтлал, бодлого, тогтолцоо хөгжиж байна. Харин хөгжлийн хожуу шатанд төвлөрсөн халамж асрамжийн тогтолцоог задлах, түүний төвлөрлийг сааруулахын тулд хүүхэд асрах халамжлах бусад хувилбаруудыг зэрэгцүүлэн хөгжүүлэх, өргөжүүлэх талаар шинэчлэл хийх болсон юм.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хүүхдийг хамруулахад хоёр үндсэн зарчим бий болдог (UNO, 2010). Зайлшгүй байдлын зарчим (the principle of necessity) нь гагцхүү зайлшгүй

шаардлага бий болсон тохиолдолд л хүүхдийг хамруулах гэсэн утгатай. Гэхдээ хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэж байх учиртай. Хүүхэд жам ёсны тогтолцоо болох эцэг эхийн гар дээр гэр бүлдээ байх ёстой бөгөөд хэрэв энэ нь боломжгүй болсон тохиолдолд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах асуудал яригдана. Харин зохистой байдлын зарчим (the principle of appropriateness) бол хүүхдийн хувийн хэрэгцээ болон нөхцөл байдалд нийцэж буй үед л асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах учиртай. Дээрх хоёр зарчим нь хүүхдийг асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулах хамгийн чухал үндэслэлүүд болох бөгөөд үүнийг дараах Зураг 1-д илүү тодорхой тусгасныг харж болно (Nigel Cantwell, 2012).

Зураг 1. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах зайлшгүй байдлын зарчмыг авч үзэх нь

Зохистой байдлын зарчим: Албан ёсны хувилбарт халамжийн орчин босго стандартыг хангахуй

- Хүний эрхийн үүрэг хариуцлагыг баримтлах, амлалт өгөх
- Суурь үйлчилгээний, ялангуяа боловсрол, эрүүд мэндийн хүртээмжийг бүрдүүлэх
- Хүний нөөцийг бүрэн хангах (асрагчийн мэргэшил ба сэдэл)
- Эцэг эх, гэр бүлийн бусад гишүүдтэй зохих холбоо харилцааг дэмжих, чиглүүлэх
- Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах
- Шалгуур бүрэн хангаж буй эсэхэд тулгуурлан асрагчдыг бүртгэх, зөвшөөрөл олгох
- Улс төр, эдийн засаг, шашны агуулга бүхий зорилго тээж буй асрагчийг хориглох
- Тогтмол бөгөөд урьдчилан мэдэгдээгүй бие даасан хяналын механизмыг бүрдүүлэх

Зохистой байдлын зарчим: Хувилбарт халамжийн орчин хүүхдийн хэрэгцээг хангахуй

- Халамжийн бүхий л хувилбаруудыг урьдчилан харах
- Асрамжийн орчин хүүхдийн шинж чанар, нөхцөл байдалд хамгийн сайн нийцэж буйг системтэй үнэлдэг мэргэшсэн ажилтнуудад мэдээллийг шүүн тунгаах ажлыг хуваарилах
- Төвлөрсөн асрамж халамж нь гагцхүү хамгийн нарийн олон толт үйлчилгээ хэрэгтэй үед л шаардлагатай гэдгийг баталгаажуулах
- Асрагчаас хүүхэд бүрийн хувьд урт хугацааны зохистой шийдлийг олоход хамтран ажиллахыг шаардах

Зайлшгүй байдлын зарчим: Албан ёсны хувилбарт халамжийн хүлээгдэж буй хэрэгцээг бууруулах

- Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Гэр бүлийн задралд хүргэж буй нийгмийн хүчин зүйлст анхаарах (ялгаварлан гадуурхах, хаяг наах, шоовдорлохуй)
- Гэр бүлийн үйлчилгээ болон гэр бүлийн дэмжлэгийг сайжруулах
- Өдөр өнжүүлэх үйлчилгээг үзүүлж, асрамжаас түдгэлзэх
- Албан бус/уламжлалт даван туулах стратегийг дэмжих
- Эцэг эх, хүүхэд, өргөжсөн гэр бүлтэй боломжит хувилбаруудыг зөвлөлдөх
- Үр хүүхдээсээ татгалзах үзэгдлээс зайлсхийх
- Хүүхдийг эцэг эхийн асрамж халамжаас салгах үндэслэлгүй шийдвэрийг зогсоох

Зайлшгүй байдлын зарчим: Хувилбарт халамжийн нөөцөөс татгалзах

- Мэдээллийг шүүн тунгааж шийдвэр гаргах
- Эцэг эхчүүдэд үр дүнтэй зөвлөгөө, практик нөөцийг хүртээмжтэй болгох
- Хүүхдүүдийг төвлөрсөн асрамжид хамруулахыг хориглох
- Зайлшгүй биш төвлөрсөн асрамжийн санхүүжилтийг зогсоож, хувилбарт асрамжид хамрагдах эрхийг чухалчлах
- Төвлөрсөн асрамж халамж нь одоо хүртэл зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд зохистой байгааг байнга үнэлэх

Ерөнхийдөө хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг албан ба албан бус гэж ангилах нь бий (UNO, 2010). Албан бус хувилбаруудад хүүхдэд анхаарал халамж тавьж буй гэр бүлийн эцэг эхээс бусад гишүүд болон өөр гадны хүмүүсийг хамруулж ойлгох бөгөөд улс орнуудын нийгэм соёл, уламжлал, шашны итгэл үнэмшлийн хүрээнд бүрэлдсэн байдаг. Дэлхий даяар ялангуяа хөгжиж буй орнуудад өргөжсөн гэр бүлийн хэлбэр ихээхэн түгээмэл бөгөөд хэрэв хүүхэд эцэг эхийн хайр халамжид байх боломжгүй болоход энэ нь тэднийг албан бус асран халамжлах хувилбаруудад хамрагдах урьдач нөхцөлийг бий болгодог. Албан бус халамж нь түүнчлэн хүүхэд тэргүүлсэн өрх байж болно гэж үздэг. Энэ тохиолдолд засгийн газар хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байх эрхийг баталгаажуулахыг чухалчлах хэрэгтэй.

Албан ёсны асрамж халамжийн хувилбар нь хүүхдийг засгийн газраас хүлээн зөвшөөрсөн байгууллагад гэр бүлийн гишүүн бус хүмүүсийн анхаарал халамжид байлгахыг хэлдэг. Гэвч энэ нь аль болох хүүхдийг өөрийн төрөлх орон гэртээ байгаа мэт орчинд байлгах зорилгыг эрмэлздэг. Хэрэв суурин байдлаар байршуулан асран халамжлах хэлбэрүүдийг (дамжих байр, хамгаалах байр, асрамжийн газар, өнчдийн асрах газар гэх мэт) зохион байгуулж буй тохиолдолд хүүхэд бүрд тэдний хувь хүний үүднээс хандаж дээд ашиг сонирхолд нь нийцсэн байх зорилго бий болдог.

Монгол улсын стандартад хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ гэж эцэг эхийн хайр халамжаас гадуур байгаа хүүхдэд урт болон богино хугацаагаар асрамж халамжийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг хэлнэ хэмээн тодорхойлсон байна. Хэрэв хүүхэд эцэг эх, гэр бүлийн хайр халамжаас гадуур байгаа бол дараах гурван төрлийн асрамж халамжид хамрагдахаар заасан юм.

Хүснэгт 1. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төрлүүд

Асран халамжлах хувилбарууд	Тодорхойлолт
Төрөл, садан хүний асрамж халамж	Асран хамгаалал, харгалзан дэмжлэг шаардлагатай хүүхдийг төрсөн ах, эгч, төрлийн болон садангийн хүний гэр бүл өөрийн гэр бүлдээ авч асран хамгаалах үйл ажиллагааг хэлнэ.
Асралт гэр бүл	Хүүхдийг гэр бүлдээ авч асран халамжлахаар зөвшөөрч, тодорхой шалгуурын дагуу сонгогдон, эрх бүхий байгууллагатай хүүхэд асран халамжлах гэрээ байгуулж, тэдний удирдлага, дэмжлэг, хяналтын дор хүүхдийг тодорхой хугацаагаар асран халамжилдаг гэр бүлийг хэлнэ.
Төвлөрсөн асрамж халамж	Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувийн болон улсын асрамжийн газар гэр бүлийн орчинд дүйцэхүйц, бүлгийн зохион байгуулалтын хэлбэрээр төвлөрүүлэн асрамжлах үйлчилгээг хэлнэ.

Эх сурвалж: С.Тунгалагтамир, Н. Баярмаа, Ж. Шийлэгнүрэв бусад., 2017.

1.3

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2021 онд ХНХЯ-аас батлан гаргасан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ын 4.3-д Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ нь хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалан нөхөн сэргээх, хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалан нөхөн сэргээх гэсэн хоёр хэлбэртэй байна, мөн журмын 4.5-д Аюулын зэргийн түвшин, эрсдэлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний дүнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал нь гэр бүлийн орчиндоо хангагдахгүй болох нь илэрч хүүхдийг Нэг цэгийн үйлчилгээ, Түр хамгаалах байр, асрамж халамжийн төв, асралт гэр бүл зэрэгт байрлуулан асрамжлах, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ нь хүүхдийг гэр бүлийн орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний түвшний үйлчилгээнд хамаарна хэмээн тус тус заажээ (ХНХЯ, 2021). Энэ сэдвийн хүрээнд бид хүүхдийн урт хугацаанд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах тухай асуудлыг хөндөх болно.


Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд асрах халамжлах үйлчилгээнд хамруулах нь өөрөө бүхэл бүтэн үйл явц бөгөөд мэдээж энэ нь ийм байдлаар асрахаас өөр боломжгүй болсон хүүхэдтэй холбоо тогтоох, түүний эрсдэлийн нөхцөл байдлыг илрүүлэхээс эхлэх болно. Харин хүүхдийг хувилбарт асрамжийн үйлчилгээнд хамруулах хүртэл хэд хэдэн үйл явц, үе шатыг дамжих ба үүнийг дараах байдлаар зураглаж болох юм.

Зураг 2. Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хоёр хэлбэр



Эх сурвалж: ХНХЯ, 2021

Зураг 3. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах үе шат



Аюулын зэргийн болон анхдагч нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхдийн нэгдүгээрт, шууд бие махбодын хамгаалал, эрүүл мэнд, аюулгүй байдал, хоёрдугаарт, хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэгт юуны өмнө анхаарал хандуулдаг. Улмаар хүүхдийн эрсдэлийн түвшинг тодорхойлоход чиглэдэг бөгөөд 1) өндөр эрсдэлтэй буюу хүүхдэд газар дээр нь интервенц үзүүлэх хэрэгтэй, мэргэжлийн удирдлага болон хамтарсан багт шууд мэдэгдэх, 2) дунд зэрэг эрсдэлтэй буюу интервенцийг 72 цагийн дотор үзүүлэх, 3) бага зэргийн эрсдэлтэй буюу интервенцийг нэг долоо хоногийн дотор үзүүлэх гэсэн зэрэглэл бий болно (CPWG, 2014).

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахад хамтарсан багийн үүрэг хамгийн анхдагч бөгөөд чухал байх болно. 2017 онд ХНХЯ, ХЗДХЯ, болон ЭМЯ-ны сайд нарын хамтран баталсан “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын 1.5-д Хамтарсан баг нь нийгмийн бүхий л орчинд хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг мэргэжлийн сургалтад хамруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмнэлгийн байгууллагын шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээх, шаардагдах бусад үйлчилгээнд холбон зуучилж, үйлчилгээний үр дүнг хянана” хэмээн заасан юм (Монгол Улсын ЗГ, 2017). Энэхүү журамд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахтай холбогдсон хамтарсан багийн гишүүн бүрийн эрх, үүрэг хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.


Хүснэгт 2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахад хамтарсан багийн гишүүдийн үүрэг оролцоо

Гишүүд	Гишүүдийн үүрэг оролцоо
Хамтарсан багийн ахлагч	3.1.2. Хүчирхийллийн эрсдэлтэй мэдээлэл хүлээн авсан сум, баг, хорооны Засаг дарга Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24.1-д заасны дагуу таслан зогсоох ажиллагааг шуурхай авч, холбогдох журмын дагуу насанд хүрсэн хохирогчийн аюулгүй байдлыг, хүүхдийг тусгай хамгаалалтаар тус тус хангаж ажиллана.
Нарийн бичгийн дарга	3.2.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан хүлээн авч, холбогдох маягтын дагуу бүртгэл хөтлөн, энэ тухай Цагдаагийн байгууллага, Хамтарсан багийн ахлагчид мэдээлнэ. 3.2.6. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, аюулын зэргийн үнэлгээ өндөр гарсан тохиолдолд хүчирхийлэгчийг хяналтад авах, тусгаарлах, эсхүл хохирогчийг түр хамгаалах байранд, хүүхдийг асрамжийн газар, садан төрлийн асрамж, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжүүлнэ. 3.2.7. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид орчуулагч, дохионы хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулах шаардлагатай бол нийгмийн ажилтан Хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.
Өрх, сумын эмч болон эмнэлгийн мэргэжилтэн	3.3.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна. 3.3.2. Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, мэргэжлийн дүгнэлт гаргана. 3.3.3. Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, холбон зуучлах, үйлчилгээ дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

	<p>3.3.4. Нийгмийн ажилтантай хамтран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.</p> <p>3.3.6. Хохирогчид гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27, 37 дугаар зүйл, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээг болон шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн дараагийн шатанд холбож, хяналттай ажиллана.</p> <p>3.3.7. Хохирогчийн осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Хамтарсан багийн нийгмийн ажилтанд өгөх ба Нийгмийн ажилтан холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулна.</p>
<p>Сургуулийн нийгмийн ажилтан</p>	<p>3.4.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.</p> <p>3.4.2. Гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахад хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор олон нийт, байгууллага, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажлыг харъяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.</p> <p>3.4.5. Сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч нь Боловсролын хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 26.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2., 6.3.4-т заасан үйлчилгээг үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журмыг хэрэгжүүлж ажиллана.</p>
<p>Халамжийн нийгмийн ажилтан</p>	<p>3.5.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.</p> <p>3.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40.1-д заасны дагуу хохирогчийг нийгмийн халамжийн холбогдох үйлчилгээнд, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.22-т заасны дагуу хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа хүнд асаргааны тэтгэмж олгох үйлчилгээнд хамруулна.</p> <p>3.5.3. Хохирогчийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу холбон зуучлахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалыг мөрдөж ажиллана.</p>
<p>Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан</p>	<p>3.6.4. Хохирогч аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд Хамтарсан багийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.</p> <p>3.6.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийг түүний хүсэл сонирхолд нийцүүлэн дугуйлан, клуб, секц, хотын үзвэр, аялал, хөгжлийн хөтөлбөр зэрэг нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах хөтөлбөрт хамруулна.</p> <p>3.6.7. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид орчуулагч, дохионы хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулах шаардлагатай бол нийгмийн ажилтан Хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.</p> <p>3.6.8. Хамтарсан багийн шийдвэрээр хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тэдний хүсэлтээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулах хүсэлтийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.</p>

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нь Монгол улсын стандарт хэмжилзүйн газраас 2017 онд баталсан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5852-ын хүрээнд явагдана. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгчид болон үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, уг хувилбарт үйлчилгээний хүрээнд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, хамгааллын үйлчилгээ, түүнчлэн төрөл садан хүн, асралт гэр бүл, болон төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнд тавих шаардлагуудыг тусгасан байна. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамруулахдаа нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтнууд энд дурдаж буй ерөнхий болон тусгай шаардлагыг сайтар мэдэж байх учиртай.

Зураг 4. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагууд



Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хүүхдүүдийг хамруулахдаа хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэгдүгээрт тавих ба хүүхдийн өөрийн санаа бодол, оролцоог хангах хэрэгтэй.

1.4

ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Дээр дурдсанчлан, хүүхдийн асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ нь хүүхдийн халамжийн түүхэн хөгжлийн үр дүнд, нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагын улмаас бий болсон. Хүүхдийг төвлөрүүлэн халамжлах байдлаас хувилбарт халамжийн үйлчилгээнд шилжих бодлогын шинэчлэлийн үйл явцыг агуулж буй юм. Түлхүүр ойлголтын хүрээнд энэ үйл явцыг хүүхдийн халамжийн төвлөрлийг сааруулах, институцэд суурилсан асрахуйгаас хүй элгэн, олон нийтэд суурилсан асрахуйд шилжих (deinstitutionalization) тухай болно. Олон улсын байгууллагын эх сурвалжуудад хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хэрхэн шилжиж байгаа талаар зарим сайн жишээнүүдийг авч үзсэн байна (ISS, 2012).

Төвлөрсөн халамж асрамж буюу институцид суурилсан халамжаас шилжих олон улсын сайн туршлагыг НҮБ-ын Хүүхдийн сангийн танилцуулснаар толилуулж байна.

Молдав улс

Молдав улс 2007-2011 оны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд шилжилт хийх шинэчлэлийг хийсэн юм. Шинэчлэл эхэлснээс хойш асрамжийн газарт байгаа хүүхдийн тоо буурсан ба 2006 оны эцэст 11,442 байсан бол 50% -иар буурч 2011 оны эцэст 5723 болсон байна. Хүүхдийг төвлөрсөн асрамжид шилжүүлэх ажлаас урьдчилан сэргийлэх ажлыг илүү амжилттай хийснээр гэр бүлүүд хүүхдүүдээ үргэлжлүүлэн асрахад нь дэмжин туслах ажлыг хэрэгжүүлж 900 гаруй хүүхдийг хүй элгэн олон нийтэд нь эргэн нэгтгэсэн байна. Тэдний дийлэнх (86%) нь биологийн болон өргөжсөн гэр бүлдээ амьдрах болжээ. Цаашид гэр бүлийнхэнтэйгээ хамт амьдрах боломжгүй хүүхдүүдэд зориулсан гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээ нь төвлөрсөн асрамжийн үйлчилгээнээс илүү хувийг эзлэх болсон байна. Засгийн газар эдгээр шинэчлэлийг хэрэгжүүлэхэд баримталсан стратеги нь өргөн хүрээний ТББ-уудтай түншлэлийг бий болгосон ба энэ тус орны хувьд маш чухал, ололт амжилтын үндэс байв. Энэ стратегийн хүрээнд нийгмийн ажилтнуудын үндэсний сүлжээ нэгдэн орсон бөгөөд хүй элгэн [олон нийт], гэр бүлд суурилсан хувилбарт үйлчилгээнүүдэд хамрагдсан хүүхдүүдийн тоо хоёр дахин нэмэгдсэн байна¹.

Гүрж улс

Гүржийн засгийн газар сүүлийн жилүүдэд хүүхэд хамгааллын шинэчлэлийг хийсэн бөгөөд үүний гол нэг тал нь институтэд суурилсан халамжийг эцэс болгох явдал байлаа. Үүний үр дүнд асрамж халамжийн байгууллагууд хаалгаа барьж сангийн хөрөнгө улсын хууль ёсны нийгмийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх; асрамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх; нярай хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх богино хугацааны тусламжийг нэвтрүүлэх; өдөр өнжүүлэх зэрэг урьдчилан сэргийлэх үйлчилгээг бэхжүүлэхэд зарцуулагдсан байна. Хүүхэд асрах тогтолцоонд эцсийн зайлшгүй шалтгаанаар хамрагдахаар зохицуулагдсан. Үүний зэрэгцээ бэлтгэгдсэн улсын нийгмийн ажилтны тоо 1999 онд ердөө 18 байсан бол тогтвортой өсөж 2009 онд 160, 2012 он гэхэд 250 болжээ. Шинэчлэлийн үр дүнд төвлөрсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан хүүхдийн тоо 2500-аас 250 болж буурсан ба нийт хүүхдийн 30 гаруй хувь нь гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн юм. Түүний хүрээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэхэд чиглэсэн сар бүрд 50 долларын тэтгэмжийг бий болгож, хүүхдийн эрүүл мэндийн даатгал, үнэ төлбөргүй сурах бичиг, өдрийн үйлчилгээ зэргийг нэвтрүүлжээ. Гэр бүлдээ эргэн нэгтгэгдэж чадаагүй хүүхдүүдийг жижиг бүлгийн зохион байгуулалттайгаар асарч, хоёр жилийн дотор ийм зохион байгуулалт бүхий асрамжийн хувилбарууд 15-аас 45 болгон нэмэгдүүлж хоёрхон жилийн дотор 400 орчим хүүхэд байрлаж байна².

Малави улс

Малавийн засгийн газар хувилбарт тусламж авах шаардлагатай хүүхдүүдийг төвлөрсөн асрамжаас хараат байдлыг бууруулахыг эрмэлзэж байна. Түүний үр дүнд Засгийн газар өнчин хүүхдийн тоог бууруулж чадсан билээ. Малави улс 2010 онд Хүүхдийн асрамж, хамгаалал ба шударга ёсны хуулийг баталсан ба шинэ хуулийн үзэл баримтлал нь асрамж, хамгаалал, асралт хувилбарын цогц хэлбэрийг бий болгох тухай байжээ. Үүний үр дүнд төвлөрсөн асрамжийн тогтолцоог задалж, гэр бүл, хүй элгэнд түшиглэсэн асрамжийн хамрах хүрээг нэмэгдүүлж, асрамжийн байгууллагад байгаа хүүхдийн тоог бууруулж чадсан юм. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөлтөд өнчин болон эрсдэлд буй хүүхдийн төлөө тогтолцоог бэхжүүлэх, хэрэгжүүлэх хүрээг шинэчилсэн агаад удаан хугацаанд эцэг эхийн халамжаа алдсан дээрх хүүхдүүдийг гэр бүл болон олон нийтэд түшиглэсэн асрамжид хамруулахыг зорьсон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг: Жендэр, Хүүхэд, Олон нийтийн хөгжлийн яам (2010). Өнчин болон бусад эмзэг бүлгийн хүүхдүүд хүүхдүүдэд хяналт тавих хөтөлбөр (OVC) Малави: 2009 оны жилийн тайлан.

1 Дэлгэрэнгүй мэдээллийг: www.unicef.org/moldova/reallives_20084.htm

2 Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс авна уу: www.unicef.org/georgia/OPM_report_edited.pdf

Монгол улсад хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэн нь

2022 оны байдлаар улсын хэмжээнд 31 асрамж халамжийн төвд 1000 гаруй хүүхэд байна. Эдгээр асрамж халамжийн төвийн 41.2% нь төрийн бус байгууллагуудад харьяалагддаг байна (Дүфрэнэ Сан, 2020)

Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй байгаа учраас 2009 оны 12 сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний удирдамж”-ийг баталгаажуулсан юм (UNO 2010). Энэ үүргийн хүрээнд МУЗГ-аас Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүлээн зөвшөөрөгдөх, хөгжүүлэх боломжит хувилбаруудыг бодлогын түвшинд тодорхойлох, хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлэх, холбогдох журам, стандартыг баталж, эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь иргэдийн сайн дураараа бусдад туслах нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн ойлголтыг хөгжүүлэхэд сайн туршлага болж байна. Гэр бүлийн тухай хууль (1999 он), Нийгмийн халамжийн тухай хууль (2012он), 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хууль (2016 он) баталж, улмаар 2017 онд Монгол улсын стандарт Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 шинэчлэн батласан. Ийнхүү сүүлийн жилүүдэд хийгдсэн хууль эрх зүйн шинэчлэл, өрх гэр бүл болон нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт, хандлагад нийцүүлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн зарим хэсэгт 2021 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд, ХНХ-ын сайдын 2021 оны А/209 дугаар тушаалын Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам нь бүтэн өнчин болон эрсдэлт нөхцөлд буй хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээний нөөцийг гэр бүл, төрөл садан, асралт гэр бүлд байлгахад онцгой анхаарал хандуулж, хүүхдэд гэрийн суурь хүмүүжил олгохын зэрэгцээ эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн билээ.

**Мэдлэг шалгах асуултууд**

1. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээг хөгжүүлэхийн учир холбогдлыг хэрхэн тайлбарлах вэ?
2. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах ямар зарчмууд байдаг вэ, тэдгээрийн гол мөн чанарыг товч хэрхэн хэлэх вэ?
3. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээний ямар төрөл хэлбэрүүд байдаг вэ? тус бүрийн онцлог юу байж болох вэ?
4. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах үе шат, оролцогч талуудын үүргүүдээс дурдана уу?
5. Хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудаас аль нэг хэсгийг хэлнэ үү?

ХОЁР

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2.1 Үндсэн ойлголт

2.2 Онолын үндэслэл

2.3 Арга зүй, аргачлал

2.4 Практик хэрэглээ, сайн туршлага

2.1

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Энэ сэдвийн хүрээнд хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах хэрэгцээ шаардлага болон үйлчлүүлэгч хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хэрхэн хийх талаар авч үзэх болно. Хүүхдийг урт хугацаанд гэр бүлээс нь гадуур асрах шаардлага ямар тохиолдолд бий болох вэ? Хүүхэд хамгааллын үйлчилгээний үед нөхцөл байдлын үнэлгээ ямар чиглэлээр хийгдэх вэ? Цаашилбал гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хүүхэд хамгааллын ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийхэд анхаарах ёстой асуудлууд юу байх вэ? зэрэг асуудлуудыг авч үзэх болно.

Өмнөх бүлэгт авч үзсэнчлэн хүүхэд хамгааллын тогтолцооны нэг чухал зарчим бол хэрэв хүүхэд гэр бүлдээ аюулгүй байх баталгаа алдагдвал, хэрэв энэ орчинд эцэг эхчүүд болон бусад асран хамгаалагчид нь аюулгүй байдлыг нь хангаж чадахгүй, эсвэл өөрсдөө алдагдуулах юм уу аюултай байдалд хүргэж буй тохиолдолд түүнийг гэр бүлээс тусгаар байлгах болно. Хүүхдийг гэр бүлээс тусгаар орчинд асрах хувилбарт үйлчилгээ нь зайлшгүй болон зохистой гэсэн тулгуур хоёр зарчимтай байдгийг хэлэлцсэн билээ. Хүчирхийлэлд, тухайлбал гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд нь гэр бүлээс тусгаар орчинд асрамж халамжийн үйлчилгээ авбал зохих гол зорилтот бүлэг юм. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх боломжгүй бол уг хүүхдийг гэр бүлээс гадуур урт хугацааны асрамж халамжид хамруулах, түүний хүрээнд нийгмийн суурь үйлчилгээ болон хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх болно.

Нөхцөл байдлын үнэлгээ гэдэг нь нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлчлүүлэгчтэй холбоо харилцаа тогтоосны дараа эхний шатанд гүйцэтгэх ажил байдаг. Энэ нь нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид тулгарч буй асуудлын шалтгаан, асуудалтай холбоотой үүссэн нөхцөл байдлыг судлан таних үйл явц юм (А.Батхишиг, 2017). Энэ сэдвийн хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний үеийн нөхцөл байдлын үнэлгээнд илүү төвлөрөх бөгөөд энэ үед хамрах хүрээ, үе шат, зорилго, судлагдахуун буюу судалгааны үндсэн асуултууд зэргийг авч үзэх болно.

2.2

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ


Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нь хүүхэд гэр бүлдээ аюулгүй байх боломжгүй тохиолдолд л хэрэгцээтэй бөгөөд ихэвчлэн урт хугацааны туршид хүүхдийг дээрх үйлчилгээнд хамруулах болдог. Өөрөөр хэлбэл, эцэг эхийн хайр халамж, гэр бүлийн орчныг орлох тийм орчныг бий болгоход чиглэж буй юм. Гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулахдаа юуны өмнө нөхцөл

байдлын үнэлгээ болон гэр бүлийн судалгаа хийж, түүний үр дүнд хүүхдийг гэр бүлээс гадуур үйлчилгээнд хамруулах эсэх, ямар хугацаагаар хамруулах шаардлагатай зэрэг асуудлууд тодорхой болно.

Ерөнхийдөө нөхцөл байдлын үнэлгээ нь өнөөдрийн түвшинд үйлчлүүлэгчийн асуудал, хэрэгцээ, нөөц гэсэн гурван үндсэн судлагдахууны хүрээнд үйлчлүүлэгч болон түүний орчны хүмүүсээс мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх үйл явц бөгөөд үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ, интервенц үзүүлэх гол суурь болно. Нийгмийн ажлын түүхэнд хувь хүн болон түүний тойрон хүрээлж буй орчны харилцааны асуудал байнга анхаарлын төвд байж ирсэн билээ. Хүн ба орчны харилцааны асуудал нь нийгмийн ажлын шууд болон шууд бус практикийн аль түвшинд байгаагаас хамаарч онцлогийг агуулж байдаг (Cornell, 2022). Эхнийх нь клиник нийгмийн ажил, кейс нийгмийн ажлын, удаах нь нийгмийн бүтэц, тогтолцооны хүрээний асуудлууд байдаг. Нийгмийн ажлын түүхэнд анх “нөхцөл байдал дахь хүн” гэсэн ойлголт бий болсон бол хожмоо “орчин дахь хүн” хэмээх ойлголт болон өргөжин хөгжиж, юутай ч өнөөдөр үйлчлүүлэгч хувь хүн болон түүний орчин (нийгмийн тогтолцоонууд) хоорондын харилцааг ойлгох, танин мэдэх, практикт баримжаалах нь хамгийн чухал асуудал юм.

Нөхцөл байдлын үнэлгээ гэдэг нь нийгмийн ажлын үйлчилгээ явуулахад шаардлагатай, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийн тухай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа гэж Макс Сипорин тодорхойлсон. Үнэхээр нөхцөл байдлын үнэлгээг үйлчлүүлэгчид тулгарч буй асуудал, орчин нөхцөлийн талаар таньж мэдэх бэсрэг судалгаа, дүн шинжилгээ гэж нэрлэж болно (А.Батхишиг, 2017). Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээндээ үйлчлүүлэгчийн болон түүний орчны талаарх мэдээллийг өөрөөс нь болон орчны хүмүүсээс нь цуглуулах ба ингэхдээ үйлчлүүлэгчийн асуудал, хэрэгцээ, нөөцийг илрүүлэхэд чиглэнэ.

Зураг 5. Орчин дахь хүн хандлага ба нөхцөл байдлын үнэлгээ



Нөхцөл байдлын үнэлгээ мэргэжлийн аль түвшинд, ямар төрлийн үйлчилгээг, ямар зорилтот бүлэгт үзүүлэх гэж байгаагаас хамааран түүний хамрах хүрээ, судлагдахуун, мэдээлэл цуглуулах хийгээд шинжилгээний арга зүй нь өөр өөр байж болно.

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн үед үйлчлүүлэгч хүүхдийн нөхцөл байдалд хийх үнэлгээ нь нийгмийн ажилтан тухайн хүүхдэд тулгарч байгаа асуудлыг танин мэдэх мэргэжлийн ямар онол үзэл баримтлал баримталж, асуудлыг шийдвэрлэх мэргэжлийн ямар аргазүй хандлагад тулгуурлаж байгаагаас шууд хамаарна. Тухайлбал, сэтгэц шинжлэлийн,

нийгмийн экологийн, танин мэдэхүй зан үйлийн, суралцахуйн, ээнэгшин дасахуйн, эрх мэдэл ба зөрчлийн аль онол үзэл баримтлалд суурилж буйгаас хамааран хүчирхийлэл, тухайлбал гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгч хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийх чиг баримжаа бий болно. Түүнчлэн, клиник нийгмийн ажил, хүчирхэг болгох (чадавхжуулах) хандлага, давуу талд тулгуурлах нийгмийн ажил, феминист нийгмийн ажил, дарангуйллын эсрэг нийгмийн ажил, хөгжлийн чиг хандлагатай нийгмийн ажил, бүтцийн нийгмийн ажил гэх мэт аль чиг хандлагад тулгуурлаж буйгаас хамааран дээрх тохиолдолд асуудлыг шийдвэрлэх интервенцийг төлөвлөх болно.

Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн үеийн нийгмийн ажлын онол үзэл баримтлал, аргагүйн хандлагууд

Сэтгэц шинжлэлийн онол нь дараах үзэл санааг агуулна. Үүнд:

- Ойлголт хийгээд интервенцийн суурь болох хувь хүний сэтгэлзүйн үйл ажиллагааг онцлох
- Хувь хүний одоогийн зан үйлийн эхэн үеийн уг сурвалжид анхаарлаа хандуулах
- Хувь хүний зан үйл түүний сэтгэлзүйгээр шийдвэрлэх
- Хүний оюун ухааны бүтэц (ид, эго, супер эго), түүний хөгжил ба үйлдлийг судлах

Бүлэгтэй ажиллах, урт хугацааны асрамж гэх мэт нийгмийн ажлын “сэтгэлзүй нийгмийн” практикт хэрэглэх зэрэг гол үзэл санааг агуулна.

Энэ онолыг хүмүүст бүрэлдэн буй зан үйл хийгээд тэдэнтэй нүүр тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд тэдгээрийн дотоод мэдрэмж, зөрчлийн чухал болохыг онцлон тэмдэглэх замаар практикт хэрэглэнэ (Mary Nash, 2005; Payne, 2014).

Экологийн ба тогтолцооны онол нь нь дараах үзэл санааг агуулна. Үүнд:

- Тогтолцооны онол нь нийгмийн интервенцийг хувь хүний тусламжтай нэгтгэдэг.
- Тогтолцооны онол нь асуудлыг олон хүчин зүйлсийн нөлөөлөлд авч үзэх ба энэ нь нарийн төвөгтэй байдлыг бий болгодог.
- Үйлчлүүлэгч гол тогтолцоо гэж үзвэл түүнийг багтааж буй том тогтолцоонууд (гэр бүл, бүлэг), мөн түүнд багтаж буй дэд тогтолцоонууд (хүүхдийн сэтгэц) байдаг.
- Экологийн тогтолцооны онол нь сэтгэлзүйн болон хувь хүний тэнцвэрт байдалд анхаардаг.
- Тогтолцоонууд нь өөрийн дотоод болон тогтолцоо хоорондын мэдээлэл, үйл ажиллагааны үйл явцаар дамжин өөр хоорондоо харилцдаг. Энэ нь бидэнд хүмүүс гэр бүлд, олон бүлэгт, нийтэд, байгууллагад хэрхэн бие биедээ нөлөөлдгийг сануулна.
- Нийгмийн сүлжээ нь тогтолцооны онолын гол хэрэглэгдэхүүн болно.
- Экологийн ба тогтолцооны онолыг хувь хүмүүсийг тойрон хүрээлж буй хүмүүсийн харилцаа болон гэр бүл, бүлэг, олон нийт, агентлагууд гэх мэт тогтолцоонуудтай холбох үзэх замаар практикт хэрэглэнэ (Mary Nash, 2005; Payne, 2014).

Хямралын онол нь дараах гол үзэл санааг агуулна. Үүнд:

- Урт хугацааны гэхээсээ богино хугацааны асуудалд хариу үзүүлэхэд чиглэдэг.
- Үйлчлүүлэгчийн нэн тэргүүний асуудал, туршлагад анхаарлаа хандуулснаар үйлчлүүлэгчийн өмнө хүлээх хариуцлагыг нэмэгдүүлдэг.
- Асуудлыг шийдвэрлэх ердийн арга зам бүтэлгүйтэх үед хямрал нь хүмүүсийн амьдралд эргэлтийн цэг болдог.

- Хямрал хүмүүсийн амьдралд нөлөөлөх үед тэдэнд хурцадмал болон эмх замбараагүй байдлын мэдрэмж бий болдог.
- Аюултай үйл явдал нь хүмүүс үйл явдлуудыг удирдаж буй тогтвортой байдлыг үгүй хийж хямралыг бий болгодог.
- Өдөөгч хүчин зүйл нь идэвхтэй хямралыг бий болгодог.
- Хямралын онол нь Хувь хүний амьдралд тохиолдож буй айхтар үйл явдлууд болон тэдгээрт үзүүлэх хариу үйлдэл, даван туулах арга замыг судалдаг (Mary Nash, 2005; Payne, 2014).

Энэгшин дасахуйн онол нь дараах гол үзэл санааг агуулна. Үүнд:

- Хүмүүс хооронд сэтгэл хөдлөлийн холбоо тогтоох үйл явц буюу ээнэгшилтэд болон тэрээр хүний зан үйлд нөлөөлж буйд анхаарна.
- Хүүхэд насанд үүсэх ийм холбоо, ялангуяа хамгийн ойрын асрагчтай тогтох холбоо нь хожмын харилцааны хөгжилд, амьдралд нь чухал нөлөөтэй.
- Ээнэгшлийн хэлбэрүүд буюу найдвартай байдал, хоёрдмол байдал, зайлсхийх хөндийрөх, эсэргүүцэх гэсэн төрлүүд бий болдог.
- Ээнэгших буюу сэтгэл хөдлөлийн холбоо сул хөгжсөнөөс зан үйлийн олон гажуудал бий болдог.
- Хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хагацал, уй гашууг арилгах практикт хэрэглэж байна.
- Ээнэгшин дасахуйн онол нь хүмүүс, ялангуяа нялх багачууд болон асран хамгаалагчийн хооронд үүссэн сэтгэл хөдлөлийн холбоо буюу ээнэгшихүйг чухалчлан үздэг (Mary Nash, 2005; Payne, 2014).

Давуу талд тулгуурлахуй хандлага нь дараах гол үзэл санааг агуулна. Үүнд:

- Хувь хүн бүрд өөрийн гэсэн давуу талууд байдаг.
- Хувь хүний асуудлыг оношлоход бус ойлгох, харин түүнийг давуу тал гэсэн өнцгөөр харахыг чухалчилдаг.
- Үйлчлүүлэгч мэргэжилтэн хоёрын харилцаа нь итгэлцэл, сэдэлжилт, болон өдөр тутмын хамтын ажиллагаа, харилцаагаар байгуулагдах зүйл байна.
- Асрамжийн үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын практикт үр дүнтэйг зарим судалгаа харуулж байна.
- Давуу талд тулгуурлахуй хандлага нь хувь хүн, гэр бүлд тэдний ирээдүйд эергээр бүрэлдэх боломжтой давуу талуудыг хайх замаар тэдэнд тулгарсан асуудлыг дахин тооцоолох, давуу талуудын өмнөөс эргэн харахад анхаардаг (Mary Nash, 2005; Payne, 2014).

Хүчирхэг болгох (чадваржуулалт) хандлага нь дараах гол үзэл санааг агуулна. Үүнд:

- Хүчирхэг болгох нь үйлчлүүлэгч амьдралын зорилгод хүрэх, үйлчилгээнд хамрагдах, нийгмийн шударга ёсыг хөгжүүлэх чадвартай болоход анхаардаг.
- Хүчирхэг болгох нь хүмүүс өөрсдийнхөө эрх, үүргийг ойлгох, өөрсдийнхөө амьдралд хяналт тавих чадвартай болоход анхаардаг.
- Хүчирхэг болгох нь сул дорой, эмзэг бүлгийн хүмүүсийг дуу хоолой, оролцоотой байхыг чухалчилдаг.
- Хүч нөлөө хүмүүст зүгээр өгөгддөггүй, харин нийгмийн ажилтнууд хүмүүс түүнийгээ олж авахад нь тусалдаг.

- Хүчирхэг болгох хандлагыг хүмүүсийг өөрсдийн амьдрал болон түүнд гарах өөрчлөлтийн талаар илүү их ойлголттой болгохын тулд тэднийг хүчирхэг болгох туршлага хийгээд хэлхээ холбоог бүтээхэд анхаардаг (Mary Nash, 2005; Payne, 2014).

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг урт хугацаанд гэр бүлээс нь тусгаар орчинд асрамжийн үйлчилгээ үзүүлэхийн тулд нөхцөл байдлын үнэлгээ хийх тухайд зарим нэг зүйлийг тэмдэглэж болно. Юуны өмнө, нийгмийн ажилтан тухайн үйлчлүүлэгчийн талаарх анхны төсөөлөл, анхдагч ажиглалт, баримт сэлтэд тулгуурлан түүнтэй ажиллахад ямар онол үзэл баримтлал илүү чухал, үр өгөөжтэй байх талаар сонголт хийж болно. Үүний тулд заавал нэг онол үзэл баримтлалын хүрээнд сонголт хийх бус, хүчирхийллийн тухайн тохиолдлыг олон талаас нь бүрэн дүүрэн зураглал гаргаж авахын тулд дээрх онолуудаас нэг бус сонголт хийн, нэгдмэл байдлаар авч үзэж болно.

Нөхцөл байдлын үнэлгээний өмнөөс онол үзэл баримтлалыг сонгохын ач холбогдол нь үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх бүхий л интервенцүүдийг тодорхойлох боломжийг бүрдүүлнэ. Дээрх хүснэгтэд харуулсан онол үзэл баримтлал бүхэн нөхцөл байдлын үнэлгээний хүрээнд юуг судлах, судалгааны

ямар асуултуудыг асуух чиг баримжаа болж өгнө. Чухамдаа тэдгээр судлах зүйлс, судалгааны асуултын хүрээнд үйлчлүүлэгч болон түүний ойр хүрээллийн хүмүүсээс мэдээлэл авах боломжтой бөгөөд энэ нь эргээд үйлчлүүлэгч болон түүний орчинд нийгмийн ажлын болон хүүхэд хамгааллын ямар үйлчилгээ буюу интервенцийг хэрэгжүүлэх үндэс болох учиртай.



Шигтгээ 2. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага

4.4 Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат
Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц.

6.3.3.1 Харилцаа холбоо тогтоох /Илрүүлэх
Үйлчлүүлэгч эмзэг байдлын шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлж, эмзэг байдлын шалгуур хангаж байвал үйлчлүүлэгч болон асран хамгаалагчийн зөвшөөрлийг авч үндсэн суурь мэдээллийг баримтжуулна.

Үйлчлүүлэгчийн/кейс бүртгэлийн давхардлаас сэргийлэхийн тулд кейс менежментийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчид тусгай бүртгэлийн дугаар өгнө.

Үйлчлүүлэгчийн/кейсийг бүртгэж, үйлчилгээ эхэлснээс хойш уулзалт бүрд үйл явцын тэмдэглэл хөтөлнө.

Илрүүлэлтийн дараа үйлчлүүлэгчийг тухайн орон нутагт байгаа гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настны байгууллага, эсвэл хариуцсан мэргэжилтэн, ажилтанд холбон зуучилна.

Үйлчлүүлэгчээс ярилцлага авах, бичиг баримт бүрдүүлэх, мэдээллийг нь бусад үйлчилгээ үзүүлэгчтэй хуваалцахдаа үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авч ажиллана.

Эх сурвалж: Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022


2.3

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Ерөнхийдөө, гэр бүлээс тусдаа орчинд хүүхдэд урт хугацааны асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах эсэх нь нөхцөл байдлын үнэлгээ хийснээр тодорхой болно. Хүүхдийн эсрэг зүй бус харьцах байдал болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэл бүхий үед холбоо тогтоох болон илрүүлэх ажиллагаа явагдана. Хүчирхийллийн үед түүнд өртөх эрсдэлтэй хийгээд өртсөн хүүхдүүдийг илрүүлэх, холбоо тогтоох байдал янз бүрийн тохиолдлоор явагдаж болох юм. Иргэдийн болон хохирогчдын зүгээс тусламжийн дуудлага, эсвэл холбогдох мэргэжилтэн ажилтнуудад мэдээлэх, эсвэл нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтнуудын ажиглалтаар, эсвэл илрүүлэх болон бусад судалгааны ажлын хүрээнд нөхцөл байдлыг таамаглах гэх мэт. Өмнөх бүлэгт дурдсанчлан, хүүхэд гэр бүлийн орчноос тусдаа байх шалтгаан нь хүүхдийн аюулгүй байдал хангагдахгүй байх буюу өндөр эрсдэлтэй үед бий болно.

Ийнхүү өндөр эрсдэлд байгаа хүүхдийг илрүүлж, холбоо тогтоосны дараа хүүхдэд урт хугацаагаар гэр бүлийн орчноос тусгаар орчинд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх шаардлагатай үед нийгмийн ажилтан кейс менежерийн хувьд нөхцөл байдлын үнэлгээ хийх болно.

Зураг 6. Кейс менежментийн үе шатууд: НБҮ



Эх сурвалж: CPWG, 2014

Төвлөрсөн урт хугацааны асрамжийн үйлчилгээнд ямар хүүхдүүд хамрагдаж ирсэн тухайд дараах байдлаар зурагласан байна. Төвлөрсөн асрамжийн үйлчилгээнд ямар хүүхдүүд хамрагддаг вэ? гэсэн асуултад дараах байдлаар хариулжээ (Glenn Miles, 2001).

Эдгээр нь:

- 1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд. Европын түүхнээ олон оронд байгууллагад төвлөрсөн асрамжийн үйлчилгээ ихээхэн тархжээ;
- 2) Эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдэгсэд. Хүүхдүүд хэрэв ямар ч эрхзүйн туслалцаа авах боломжгүй, хууль ёсны харгалзан дэмжигч үгүй бол байрлуулж байжээ;
- 3) Зан үйлийн асуудалтай болон нийгмээр зөвшөөрөөгүй зан үйл бүхий хүүхэд. Хар тамхи мансуурах, эсвэл өсвөр насны жирэмсэн охид;
- 4) Гудамжны хүүхэд, эсвэл орон гэргүй өсвөр насны хүүхэд. Эдгээр хүүхдийг гаж үзэгдэл болон зан үйлээс урьдчилан сэргийлж төвлөрсөн асрамж руу илгээдэг;

- 5) Эцэг эх нь зүй бус харилцагч буюу хүчирхийлэгч хүүхэд;
- 6) ДОХ-ын халдвар авсан хүүхэд. Төрсөн эх эсхүл гэр бүл болон олон нийт нь татгалзсан хүүхэд;
- 7) Эцэг эх нь ДОХ болон бусад өвчтэй хүүхэд. Сэтгэцийн эсхүл архаг хууч өвчнөөс болоод хүүхдээ асрах боломжгүй;
- 8) Эцэг эх нь шоронд байгаа хүүхэд;
- 9) Ямар нэг шалтгаанаар сураггүй болсон эцэг эхийн хүүхэд;
- 10) Хаягдсан хүүхэд. Дайн, гамшиг, осол эндэгдэл зэргээс болоод хаягдсан хүүхэд;
- 11) Цэрэг хүүхэд. Дайн тулаан, зөрчилд татагдан орсон, дайчлагдсан, үүний улмаас хаягдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхэд;
- 12) Гэр бүл салалтын улмаас хаягдсан, үл хайхрагдсан хүүхэд. Эцэг эхийн нэг нь тэжээн тэтгэх чадваргүй;
- 13) Гэр бүлийн зүгээс бэрхшээлийг даван туулах чадваргүй улмаас үл хайхрагдсан хүүхэд. Хэт ядуу болон бусад гачигдлаас болоод хүүхдүүд ердийн сургуульгүй асрамжийн байгууллагад хоол болон бусад нийгмийн үйлчилгээ авах нь Өмнөд азид түгээмэл.

Бодит амьдрал дээр олон талт хүчин зүйлээс болж хүүхэд гэр бүлээс тусдаа орчинд асрамж халамжийн үйлчилгээ авах зайлшгүй шаардлага бий болдог болохыг эндээс харж болно. Энэхүү гарын авлагад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг гэр бүлийн орчноос тусгаарлан асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулах асуудлыг онцлон үзэж буй билээ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг юуны өмнө илрүүлэх, түүнтэй эсвэл эцэг эх, асран хамгаалагчтай холбоо тогтоох ажил хийгдэнэ. Дээр дурдсанчлан, янз бүрийн байдлаар илрүүлсэн, холбогдсон байж болох бөгөөд ийм хохирогч хүүхэд гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах зайлшгүй шаардлагатай байж болох юм. Гэвч, эдгээр хүүхдүүд урт хугацааны хувилбарт асрамжийн үйлчилгээнд хамрагдах хүртлээ хэд хэдэн үйл явцыг туулах нь дамжиггүй.



Шигтгээ 3. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага

4.4 Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц.

6.3.3.2 Нөхцөл байдлын үнэлгээ хийх Үйлчлүүлэгч, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар (Эрсдэлийн, аюулгүй байдлын, давуу талын, нөхцөл байдлын үнэлгээ) үнэлгээг хийнэ.

Яаралтай шийдэх хэрэгтэй эрсдэл үйлчлүүлэгчид тулгарч буй үед (жишээ нь хүүхэд хүчирхийлэгчтэй хамт амьдарч байгаа бол) цогц, дэлгэрэнгүй нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний /кейс төлөвлөгөө гаргахаас өмнө яаралтай интервенцийг хамгийн түрүүнд хийнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ нь үйлчлүүлэгч, түүний гэр бүл, найз нөхөд, цэцэрлэг, сургууль, ажлын газар, хөрш, хамаатан садан болон бусад эх сурвалжуудтай хийсэн мэдээлэл дээр үндэслэгдэнэ.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ үнэлгээний маягтыг хөтлөх, генограм, экозураглал, амьдралын түүхийн матриц, нийгмийн дэмжлэгийг үнэлэх зэрэг техникүүдийг ашиглаж, дүгнэлт гаргана.

Нөхцөл байдлын үнэлгээний төгсгөлд үйлчлүүлэгчийн талаарх нэгдсэн дүгнэлт гаргаж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлно.

Эх сурвалж: Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022

Хэрэв хүүхэд залуучууд урт хугацааны асрамжид байгаа бол нөхцөл байдлын үнэлгээ нь байнгын давтамжтай хийгдэх учиртай. Энэ тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээний зорилго дараах зүйлст төвлөрөх болно (GovSA, 2019).

- Хүүхэд, өсвөр үеийнхний одоогийн ба ирээдүйн хэрэгцээг тодорхойлох (асрамжийн дараах асрамж халамж гэх мэт);
- Тэдний үзэл бодол, хүслийг ойлгох
- Хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээг хангах болон тэдний дээд ашиг сонирхолд нийцсэн асрамжийн орчин байгаа эсэхийг үнэлэх;
- Хүүхэд, өсвөр үеийнхнийг (болон асран хамгаалагч) чанартай тусламж үйлчилгээ авах, өөрсдийн чадавхыг бүрэн дүүрэн ашиглах боломжоор хангахад ямар дэмжлэг чухал байгааг тодорхойлох;
- Хүүхэд, өсвөр үеийнхэнд урт хугацааны халамжаас шилжих үед ямар үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх хэрэгцээтэй байгааг үнэлэх;

Нөхцөл байдлын үнэлгээ, голч ухаантай шийдвэр гаргах бүхий л үйл явцын туршид хүүхэд, өсвөр үеийнхэн идэвхтэй оролцох ёстой;

Асрамжийн газрын ажилтнууд болон асаргаа үзүүлж буй хүмүүс нь хүүхэд, өсвөр үеийнхний хэрэгцээг үнэлэх явцад цогц мэдээллийг олж авах ба эргээд хүүхэд, өсвөр үеийнхэн нөхцөл байдлын үнэлгээнд болон шийдвэр гаргах үйл явцад оролцох ёстой. Хүүхэд өсвөр үеийнхний давуу тал, хэрэгцээний талаар ойлголт олж авахын тулд асран хүмүүжүүлэгчидтэй нарийн чанад холбоо харилцаатай байхад анхаарлаа хандуулах ёстой болно. Энэ нь урт хугацааны асрамж халамжид байгаа хүүхэд залуучуудын аюулгүй байдал болон хэрэгцээг мэдэрсэн асрамжийг бий болгоход асрагч нарын оролцоо дэмжлэгийг хангахуйц кейс төлөвлөлт хийхэд тус нэмэр болдог.

Хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл үүсэж буй үеийн цогц үнэлгээ нь эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлын үнэлгээ, давуу талын үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ (асуудал, хэрэгцээ, нөөц) гэх мэт хэд хэдэн чиглэлийн үнэлгээнээс бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын үеийн нөхцөл байдлын үнэлгээ нь үе шатуудаас бүрдэх бөгөөд 1) хүлээн авах, 2) анхны нөхцөл байдлын үнэлгээ буюу мөшгөх судалгаа, 3) гэр бүлийн цогц үнэлгээ, 4) гэр бүлийн амьдралын дэвшлийн (эргэн нэгдэхүйн) үнэлгээ гэж ангилдаг.

Хүснэгт 3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц дахь нөхцөл байдлын үнэлгээний үе шат ба чиглэл³

	Үе шат	Үнэлгээний зорилго	Асуултын чиглэлүүд
1	Хүлээн авах	Хүүхдийн эмзэг байдал болон хүүхэд хамгааллын түүхийн нөхцөл байдлын талаарх өнөөгийн мэдэгдэлд хариу үйлдэл үзүүлэх хамгийн зохист үйл ажиллагааг үүсгэх	Мэдээлэл нь хүүхэдтэй зүй бус харьцах тухай агуулж байна уу? (тийм бол цаашдын үнэлгээ, мөшгөх судалгаа хийх) Хариу үйлчилгээ үзүүлэх шаардлага буюу хэр яаралтай тулгамдсан бэ?
2	Анхдагч нөхцөл байдлын үнэлгээ ба мөшгөх судалгаа	Хүүхэдтэй зүй бусаар харилцсан эсэх, тийм бол үүнээс бий болсон хохирлыг тодорхойлох	Хүүхэдтэй зүй бус харьцсан нь хууль зүйн үндэслэлтэй юу? Хүүхэд зүй бус харьцааны эрсдэлд байна уу? Ямар түвшинд байна вэ?

³ Сөрөг эрх чөлөөний нэг гол үндэслэл нь хувь хүн, гэр бүлийн амьдралд хэн ч хөндлөнгөөс оролцох ёсгүй хэмээн үздэг. Гэвч, хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь төрийн байгууллагын үүрэг бөгөөд энэ тохиолдолд дээрх сөрөг эрхийг хамгийн бага түвшинд зөрчих арга замаар байнга хүүхдийн аюулгүй байдлыг хангах учиртай.

		<p>Хүүхдэд бий болох шууд болон цаашдын аюулгүй байдлыг үнэлэх</p> <p>Хүүхдэд ирээдүйд сэтгэлзүй болон сэтгэцийн хор хөнөөлийн эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох</p> <p>Гэр бүл, хүүхдийн албан ба албан бус дэмжлэгийн эх үүсвэрийг тодорхойлох</p> <p>Хүүхдийн байнгын аюулгүй байдлыг хангах хамгийн тохиромжтой арга хэмжээг тодорхойлох, ирээдүйд учирч болох хор хөнөөлийг бууруулах</p>	<p>Хүүхэд аюулгүй юу? Хэрэв үгүй бол ямар байгууллагын хариу үйлдэл хамгийн бага хөндлөнгөөс үл оролцох³ аргаар хүүхдийн аюулгүй байдлыг хангах вэ?</p> <p>Хэрэв хүүхдийн аюулгүй байдал гэр бүлдээ хангагдахгүй бол гэр бүлээс гадуур ямар төрлийн, түвшний асаргаа хэрэгцээтэй вэ?</p> <p>Гэр бүлд яаралтай тусламжийн хэрэгцээ байна уу?</p> <p>Хүүхдийн эмчилгээний хэрэгцээ болон эрсдэлийг бууруулахын тулд ямар байгууллагын байнгын үйлчилгээг санал болгох ёстой вэ?</p>
3	Гэр бүлийн цогц үнэлгээ (хадгалахуйн)	<p>Хүүхэд гэртээ аюулгүй эсэхийг тодорхойлох</p> <p>Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж асрах эцэг эхийн чадавхыг үнэлэх</p> <p>Гэр бүл, хүүхдийн албан ба албан бус дэмжлэгийн эх үүсвэрийг тодорхойлох</p> <p>Хүүхдийн байнгын аюулгүй байдлыг хангах болон ирээдүйн хор хөнөөлийг бууруулахад шаардлагатай интервецүүдийг танин мэдэх</p>	<p>Гэр бүлийн аюулгүй байдал, бат бөх байдал, сайн сайхан байдалд нөлөөлж буй эрсдэл болон хэрэгцээ юу вэ?</p> <p>Гэр бүлийн аюулгүй байдал, бат бөх байдал, сайн сайхан байдалд муугаар хандах нь ямар үр дагавартай вэ?</p> <p>Тухайн гэр бүл дэх хувь хүний болон хамтын давуу тал юу вэ?</p> <p>Гэр бүлийн гишүүд өөрсдийн нөхцөл байдал, асуудал, болон давуу талыг хэрхэн төсөөлж байна вэ?</p> <p>Зүй бус харилцаанд анхаарлаа хандуулж, бууруулахын тулд, ийм харилцааны эрсдэлийг бууруулах, үгүй хийхийн тулд ямар өөрчлөлтүүд хэрэгтэй вэ?</p> <p>Эцэг эх, асран хамгаалагчид ийм өөрчлөлт хийхэд хэр зэрэг бэлэн бэ?</p> <p>Гэр бүлийн аюулгүй байдал, бат бөх байдал, сайн сайхан байдлыг хангах сэдэл урам зориг тэдэнд бий юу?</p>
4	Гэр бүлийн дэвшлийн (эргэн нэгдэхүйн) үнэлгээ	<p>Хүүхдийг гэр бүлдээ аюулгүйгээр эргэн нэгтгэх үндэслэлтэй шалтгаан буй эсэх, болон эцэг эхийн чадавхыг үнэлэх</p> <p>Гэр бүл болон хүүхдэд хамаарах албан ба албан бус нөөцийг тодорхойлох</p> <p>Хүүхдийн байнгын аюулгүй байдлыг хангах болон ирээдүйн хор хөнөөлийг бууруулахад шаардлагатай интервецүүдийг танин мэдэх</p> <p>Хэрэв эргэн нэгтгэх нь найдвартай гэж үзвэл төлөвлөгөөг гаргах, хүүхдийн хэрэгцээ, хүсэл, эцэг эхийн чадавхыг эргэцүүлэх</p>	<p>Хүүхэд аюулгүй байгаа юу?</p> <p>Хамгаалах хүчин зүйлс, эрсдэл, аюулгүй байдлын хүчин зүйлс өөрчлөгдөж буй нөхцөлд одоогийн эргэн нэгтгэх төлөвлөгөө өөрчлөгдөх, цуцлагдах, шинээр бий болгох асуудлыг баталгаажуулах?</p> <p>Зүй бус харилцааны эрсдэлд хөтөлж байгаа зан үйл болон нөхцөл байдалд хэрэв өөрчлөлт орсон бол ямар?</p> <p>Кейстэй ажиллах зорилтын хүрээнд ямар ахиц дэвшил гарсан бэ?</p>

		Асаргааны орчин хүүхдийн хэрэгцээг хангаж чадах эсэхийг үнэлэх Ямар харилцаа болон зохицуулалтууд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэх талаар болон цаашид хүүхдийн өөрчлөгдөн буй хөгжлийн хэрэгцээг нийцэн хангах талаар үнэлэх Хүүхдийг эргэн нэгтгэх үйл явцад хүүхэд аюулгүй бөгөөд тэдний хэрэгцээ хангагдаж буйг баталгаажуулах	Үйлчилгээнүүд нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдалд сайн үр дагавар авч ирсэн үү?
5	Хувилбарт халамж асрамжид орсон хүүхэд	Хүүхдийн халамжид шилжин буй үе болон одоо хийгээд ирээдүйн хэрэгцээг танин мэдэх Хүүхдийн үзэл бодол болон хүсэл мөрөөдлийг ойлгох Асрамж халамжийн орчин нь хүүхдийн хувь хүний хэрэгцээг хангахад шаардлагатай байгаа болон цаашид дээд ашиг сонирхолд үйлчлэх эсэхийг тодорхойлох Хүүхдийн дээд ашиг сонирхолд ямар зохицуулалт арга хэмжээ нийцэж буйг үнэлэх, тэдгээр нь өөрчлөгдөн буй хөгжлийн хэрэгцээнд хэрхэн нийцэхийг судлах Хүүхэд чанартай асрамж халамж авах, бүрэн дүүрэн боломжийг олж авахын тулд асрагч болон хүүхдэд ямар дэмжлэг хэрэгтэй буйг тодорхойлох	Хүүхдийн аюулгүй байдал хангагдсан үү? Хүүхдийн сэтгэл ханамж, аз жаргал ямар түвшинд бүрэлдсэн бэ? Хүүхэд ирээдүйдээ итгэлтэй байна үү?

Эх сурвалж: GovSA, 2019; Goldman, 2003

Урт хугацааны асрамж халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд, өсвөр үеийнхний амьдралд нөхцөл байдлын үнэлгээ хийх хүрээг зураг 7-д харуулж байна. Юуны өмнө, хүүхэд хамгаалал ба асрамжийн түүх нь тухайн хүүхдийн нялх балчир наснаасаа хамгаалал болон аюулгүй байдал нь ямар байдалтай байж ирсэн, өдгөө ямар байгаа, түүнчлэн, хэний асран хамгаалалд байж ирсэн, одоо байгаа талаарх мэдээлэл юм. Хүүхдийн үзэл бодол бол өөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэхэд оролцох, мөн өөрийн хүсэл зориг, мөрөөдлийг илэрхийлэх тухай юм. Харин хүүхэд, өсвөр үеийнхний амьдралын хүрээ гэдэгт а) соёл ба адилсал, б) гэр бүл болон олон нийтийн хэлхээ холбоо, в) сэтгэл хөдлөлийн үүрэг ба зан үйл, г) хөгжлийн үйл явц ба бэрхшээл, д) биеийн эрүүл мэнд, е) боловсрол ба хөдөлмөр, ё) нийгмийн үйл ажиллагаа, з) өөртөө халамж тавих ба бие даан амьдрах ур чадвар зэргийг багтаан ойлгодог.

Сүүлийн хоёр асуудал нь асрагч, асрамжит халамж үзүүлэгчтэй холбоотой асуудал байна.

Зураг 7. Урт хугацааны асрах үйлчилгээнд байгаа хүүхэд, өсвөр үеийнхний нөхцөл байдлын үнэлгээний хүрээ



Эх сурвалж: GovSA, 2019

Энэ сэдвийн хүрээнд хөндөх дараагийн асуудал бол хүчирхийллийн, тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нөхцөл байдлын шинжилгээ хийхтэй холбогдсон зарим тусгайлсан асуудлууд юм. Өөрөөр хэлбэл, эдгээр хүүхдүүдийн нийгэм-сэтгэлзүйн онцлогийн талаар авч үзэх ба энэ нь нийгмийн ажилтнууд, хүүхэд хамгааллын ажилтнуудын мэдвэл зохих зүйлс юм.

Хүснэгт 4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн онцлог

Хүүхэд өсвөр үеийнхний нийгэм сэтгэлзүйн онцлог. Тэд бол нийгэм сэтгэлзүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, эцэг, эх асран хамгаалагчаас эдийн засаг, бие махбод, бусад нөхцөл байдлын талаар бүрэн хараат, өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг, тийм боломж нь хязгаарлагдмал, өөрийгөө хамгаалах эрхзүйн бүрэн чадамжгүй, нэр төр, алдар хүнд гэдэг үгийн утгыг бүрэн ойлгоогүй үедээ өсөж хөгжиж яваа хүүхдүүд юм.

Тэдний энэ онцлог бэлгийн хүчирхийллийг ойлгох, хариу үйлдэл үзүүлэхэд хэрхэн нөлөөлдөг вэ? Тэд тохиолдсон явдлыг гэмт хэрэг гэж үзэхээс илүү ичгүүртэй явдал гэж ойлгодог. Үнэн зөв ярьснаараа бусдыг хүнд байдалд оруулж байна гэж ойлгосон эсхүл гэр бүлийн нөлөөлөлд автсан байдаг. Гэмт хэргийн улмаас бий болсон хор уршгийг тодорхойлох чадвар тэдэнд хараахан суугаагүй байдаг. Иймээс тэд асуудлыг аль болох мартахыг хүсэж, хэн нэгэнтэй хуваалцах, хэн нэгнээс тусламж авахыг төдийлөн хүсдэггүй.

Тэд ихэнхдээ заналхийлэл, сүрдүүлэг, бие махбодын хүчирхийлэл зэрэгт давхар өртөж байдаг. Насанд хүрээгүй хохирогч нь бие даах чадваргүй, хүчирхийлэгч нь эрх мэдэлтэй, нөлөө бүхий хүн байдгаас ямар нэгэн аюултай зэвсэг хэрэглээгүй байсан ч заналхийлэл болон сүрдүүлэг шууд үйлчилдэг. Заналхийлэл нь ихэвчлэн үйлдлээр бус үг хэлээр илэрдэг. Жишээ нь гэмт этгээд үйлдсэн хэргийнхээ талаар хүнд хэлэхгүй байхыг шаардах, хэлбэл ээж болон ойр дотнын хүмүүст нь муу зүйл болно, өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээс нь хамгийн хайртай хүнийг нь ална гэх мэтээр сүрдүүлж заналхийлдэг. Улмаар ийнхүү сүрдүүлэхийн зэрэгцээ хохирогчийг чимээгүй байлгахын тулд бие махбодод нь халдах, түүний юмуу хайртай хүнийг нь амь насанд заналхийлж эрхшээлдээ байлгадаг. Энэ нь сэтгэл санааны болон бие махбодын асар хөнөөл авч ирдэг.

Зарим хохирогч эргэлзэж, гэмшдэг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн ихэнх хүүхэд түүнд яг юу тохиолдоод байгааг ойлгохгүй эргэлзэж, энэ талаар хүнд хэлэхээс айдаг. Энэ нь зарим шалтгаантай. Хүчирхийлэгч хохирогчдод нууцаа хадгал, зөвхөн бид хоёрын нууц, би чамд дурлачхаад байна, бүх л томчууд ийм зүйл хийдэг гэж хэлдэг ба хахуульдах юм уу айлган сүрдүүлэх замыг сонгодог.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд нийгэм сэтгэлзүйн дараах шинжүүд илэрдэг. А) Хэн нэгэнд итгэх итгэл, хайрлах сэтгэл нь алдагдах. Өөрөө болон гэр бүлийн гишүүдийн хэн нь ч үүнийг зогсоож чадахгүй байгаад уурлаж бухимддаг. Б) Өөрийгөө буруутгаж, ичиж гутрах. Тохиолдсон явдалд өөрийгөө маш ихээр буруутган, ичиж, зовж гутардаг. Энэ байдлаасаа болоод тохиолдсон зүйлээ бусдад хэлэхгүй нуусаар байдаг. В) Өөрийн үнэлэмж, хүндлэл унах. Өөрийгөө буруутган дотоод мэдрэмжээ ойлгохгүй болж, өөрийгөө хүндэлж хайрлахаа болино. Өөрийн үнэ цэнээ алдсан, хэнд ч хэрэггүй болсон гэж үздэг. Г) Өөрийгөө гэмтээх. Өөрийгөө буруутгаж, энэ явдалд оролцсон, зөвшөөрсөн гэж үзэн яддаг. Үүнээс шалтгаалан архи, мансууруулах бодис хэрэглэх, хоол идэх зуршилгүй болох, эсвэл хэт идэх, өөрийгөө гэмтээж шийтгэх тохиолдлууд гардаг. Д) Бэлгийн зан үйлийн эмгэгтэй болох. Олон хохирогчийн бэлгийн амьдралын тухай үзэл бодол, бэлгийн мэдрэмж нь хэвийн бус болдог. Тэд насанд хүрсэн хойноо болзоонд очихоос айж, хүнд итгэхгүй болсон байдаг. Тэд хэн нэгэнд итгэж хайртай болох, бэлгийн ханамж авах зэрэгт хэвийн бус эмгэгтэй болсон байдаг аж. Зарим хохирогч бэлгийн харилцаанд хэт их сонирхолтой, эсвэл дургүй болдог байна.

Эх сурвалж: Г.Ганбаясах, 2019

Нөхцөл байдлын үнэлгээний үед хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн дээрх шинж чанар, онцлог байдлыг сайтар ажиглах, анхааралтай сонсох, нууцлалыг хадгалах талаар тэдний итгэлийг олох, тэдэнд чин сэтгэлээсээ хандах зэрэг асуудлууд чухал байх болно.

2.4

ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Дээр дурдсанчлан, нөхцөл байдлын үнэлгээ бол нийгмийн ажлын ерөнхий практик дахь үндсэн үе шатуудын эхнийх буюу үйлчлүүлэгчтэй харилцаа холбоо тогтоосны дараа хийгддэг зүйл юм. Ерөнхий практикийн хүрээн дэх нөхцөл байдлын үнэлгээний судлагдахуун, чиглэл яригдах нь дамжиггүй билээ. Нөгөө талаас хүүхэд хамгааллын үеийн, цаашилбал урт хугацаанд гэр бүлээс тусгаар орчинд асран хамгаалах үйлчилгээний үеийн нөхцөл байдлын үнэлгээ тусдаа үе шат, аргагүй, аргачлалыг бий болгодог. Олон улсын байгууллагын эх сурвалжуудад хүүхэд хамгааллын үйлчилгээний үед нөхцөл байдлын үнэлгээг хэрхэн гүйцэтгэж байгаа талаар зарим сайн жишээнүүдийг авч үзсэн байна (DSD, 2012). Эдгээр жишээнээс Өмнө Африкийн бүгд найрамдах улсын нэг жишээг дэлгэрэнгүй танилцуулъя.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний удирдамжид тусгаснаар энэ хүрээнд хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийх тогтолцоог хөгжүүлж чадсан байна. Үүнд нөхцөл байдлын үнэлгээ хийх зорилго, зорилт, үнэлгээ хийх арга зүй буюу хандлага, үнэлгээг зохицуулах болон тайлагнах асуудлыг хариуцах ажилтан, үнэлгээний үйл явц ба цаг хугацааны хүрээ, үнэлгээнд хүүхдийг хэрхэн татан оролцуулах, үнэлгээний үйл явцад анхаарах ёсзүйн асуудлууд, үнэлгээний үр дүнг эргэн харах, үнэлгээний маягтыг гар аргаар болон цахимаар бөглөх техник заавар зэргийг агуулдаг байна.

Тус улсад 2005 онд шинэчлэн найруулсан Хүүхдийн тухай хуулиар хувилбарт асрамж халамжид байгаа хүүхэд бүр хувийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх бөгөөд энэ нь тусгай журмын дагуу хийгдсэн нөхцөл байдлын үнэлгээнд суурилсан байх ажээ. Энэ төрлийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд тусгаарлагдах ёсгүй бөгөөд нийгэм соёл, биет, оюун санааны болон сэтгэл хөдлөлийн бүх талын орчноор хангагдаж хүний хөгжлийн онолд суурилсан төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлнэ. Асрамжийн хувилбарт буй хүүхдийн энэхүү хувийн хөгжлийн төлөвлөгөөний суурь нөхцөл байдлын үнэлгээ нь уг хүүхэд асрамжид ирэхээс өмнө хийгдсэн аюулгүй байдлын үнэлгээ болон эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээгээр баяжиж тэдгээртэй уялдаатай хийгддэг байна.

Асрамжийн хувилбарт үйлчилгээний үед хийгдэх нөхцөл байдлын үнэлгээ нь 1) хариуцлага-чанартай үйлчилгээг асрамжийн оролцогч талууд хариуцах, 2) оролцоо-хүүхэд ба түүний асран хамгаалагчид үнэлгээний бүхий л үйл явц, үе шатанд идэвхтэй оролцох, 3) гэр бүл төвт-үйлчилгээ дэмжлэг нь байнгын давтамжтай хийх үнэлгээнд суурилах бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө нь хүүхдийг асран хамгаалах асралт гэр бүлийг хөгжүүлэхэд чиглэх, 4) асрамжийн дараалал-хүүхдийн болон гэр бүлийн нийгэм, сэтгэл хөдлөл, сэтгэц, танин мэдэхүй, болон соёлын хэрэгцээний өөрчлөлтүүд нь бүхий л интервенцийн туршид анхаарах, 5) нэгдмэл-үйлчилгээ нь салбар дундын байх бөгөөд хамтарсан багаар дамжин хүрэх, 6) хүүхэд төвтэй-хүүхдэд хөндлөнгийн дарамт шахалтгүй бусадтай харилцах, сайн мэдээлэлтэй сонголт хийх эрх чөлөөг олгох, 7) хүүхдийн эрх-хүүхдийн эрхийн олон улсын баримт бичиг болон үндэсний бүх хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, 8) хүчирхэг болгох- хүүхэд бүрийн болон тэдний гэр бүлийн бүхий л нөөц нь тэдний нийгмийн дэмжлэгийн сүлжээгээр тэтгэгдэж, тэдний хариуцлагатайгаар сонголт хийх боломж бий болох, 9) байнгын төлөвлөлт- хүүхэд бүр гэр бүлдээ өсөж торних боломжтой байх ёстой бөгөөд энэ боломж үнэхээр гэр бүлдээ аюулгүй байж чадахгүй болсон тохиолдолд хязгаарлагдах зэрэг юм.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ хувь хүний хөгжлийн онол хандлагад суурилах замаар зарим практик шаардлагууд бий болдог. Хувилбарт асрамжид байгаа хүүхдийн хувьд нөхцөл байдлын үнэлгээг олон салбараас бүрдсэн хамтарсан баг гүйцэтгэдэг ба энэ багт мөн асран хүмүүжүүлэгчийг багтаана. Хүүхдийн кейс нээж анхнаас байлцсан тухайн засаг захиргааны нэгжийн нийгмийн ажилтан энэхүү олон салбарын хамтарсан багийн нэг чухал үүрэг бүхий хэсэг байна. Гадаад нийгмийн ажилтан нь хүүхдийг урьдчилан байрлуулах, хамгаалах нөхөн сэргээх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг хариуцах ёстой. Харин гадаад болон дотоод нийгмийн ажилтны аль аль нь хүүхдэд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх, түүний үргэлжлэх хугацааг хариуцна. Нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхэд төвтэй, давуу тал дээр суурилсан, цогц (эрүүл мэнд, нийгмийн зан байдал, боловсрол, соёл) байхын зэрэгцээ хэл яриа, хөгжлийн бэрхшээл, хөгжлийн үе шатанд тохирсон байна. Нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхдийн болон гэр бүлийнх нь оролцоог байж болох их хэмжээнд хангах ба мэдээллийн олон эх сурвалж, мэдээлэл цуглуулах олон аргуудаар хийж гүйцэтгэнэ. Мэдээлэл цуглуулах нэг эх сурвалж эсвэл дан ганц арга нь хязгаарлагдмал, өрөөсгөл эсвэл тэнцвэргүй үзэл бодлыг өгөх магадлалтай. Түүнчлэн, нөхцөл байдлын үнэлгээ нь сайтар бодож, тунгаан хийгдсэн үйл явц (жишээ нь хүүхэд болон түүний гэр бүл) бөгөөд үүгээрээ дамжуулан үйлчлүүлэгчийн өмнө хариуцлага хүлээх ёстой. Эцэст нь нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд хувилбарт халамжид буй хүүхэд бүрд зориулсан өөр өөр төлөвлөгөө (хувь хүний хөгжлийн болон байнгын төлөвлөгөө) боловсруулж, хянан үзэх болно.

Хувилбарт асрамжийн үйлчилгээнд байгаа хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ мэдээлэл авах гол эх сурвалж буюу хүмүүсийг хэлж болох юм. Эдгээр нь үйлчлүүлэгч хүүхэд, биологийн

эцэг/ эх/ асран хамгаалагч, хувилбарт үйлчилгээний асрагч, гадаад нийгмийн ажилтан (хүүхдийн амьдарч байсан орон нутаг), дотоод нийгмийн ажилтан, туслах нийгмийн ажилтан, хүүхдийн асрах ажилтан, багш, эрүүл мэндийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, ажил мэргэжлийн зөвлөх, хяналтын ажилтан, тухайн хүүхдэд учир холбогдол бүхий бусад томчууд болно.

Нөхцөл байдлын үнэлгээний хүрээнд дээрх олон талт эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулах хугацаа нь 4-6 долоо хоног байна. Харин мэдээллийг шинжлэн үнэлгээний үр дүнг болон хувь хүний хөгжлийн төлөвлөгөөг 14 хоногт багтаан тайлагнана.

Нөхцөл байдлын үнэлгээнд хүүхдийн оролцоог хангах нь

Юуны өмнө, хүүхдүүдийг нас, төлөвшлийн түвшинд нь тохируулан боломжийн хэрээр үнэлгээнд оролцуулах ёстой. Нийгмийн ажилтан, асран хамгаалагч, туслах ажилтан, асран хүмүүжүүлэгч болон бусад чухал хүмүүсийн зүгээс хүүхдийг ажиглах нь нөхцөл байдлын үнэлгээний мэдээллийн гол эх сурвалж болдог. Хүүхдийн хамгийн ойр дотнын дээрх хүмүүс хүүхдийн тухай өдөр бүр эсвэл долоо хоног тутмын дэвтэр хөтөлж байх ёстой ба энэ нь үнэлгээнд ашиглагдах хэрэгтэй. Хүүхэд яагаад ийм үнэлгээ хийгдэж байгааг мэдэж байх ёстой бөгөөд түүний дээд ашиг сонирхол хамгийн чухал зүйл болж байгаа гэдэгт итгэх ба хүүхдийн дээд ашиг сонирхлын талаарх өөрсдийнх нь ойлголтыг судлах шаардлагатай юм. Тухайн үйл явцын талаарх мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэхэд чиглүүлэхийн тулд хүүхдийг хөгжүүлэх, түүний зан үйлийн илрэлийг шинжлэхээс илүүтэй хүүхдийн үйл явцын талаарх мэдлэг, ойлголтыг чухалчилна. Хүүхдэд сонголт хийж, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж, хүмүүжүүлж, хүүхдийг өөрөө шийдвэр гаргах чадварыг нь хөгжүүлэхээс гадна хүүхэдтэй үр дүнтэй харилцаа тогтоохыг хичээх нь насанд хүрэгчдийн үүрэг хариуцлага юм. Үнэлгээний явцад насанд хүрэгчид хүүхэдтэй үр дүнтэй харилцаа тогтоох үүрэгтэй бөгөөд хүүхэдтэй харилцаж буй хүн өөрийгөө энгийн бөгөөд ойлгомжтой илэрхийлж, харилцаа холбооны мэддэг хэллэг, ойлголтуудыг ашиглах ёстой. Үнэлгээнд хөгжим, яруу найраг, тоглоом, жүжиг, зураг зурах болон хүүхдэд ээлтэй бусад үйл ажиллагааг ашиглахыг дэмждэг. Шинэ санааны тайлбар нь хүүхдийн нас, ойлголтын түвшинд тохирсон байх ёстой. Хүүхдийн өнгөрсөн үеийн сэтгэлзүйн болон сэтгэл санааны хямрал нь тэдний ойлголтод нөлөөлж болзошгүйг мэддэг байх нь зайлшгүй ба хэрвээ хүүхэд үнэлгээний талаар айдастай байгаа бол эдгээр айдсыг судалж, хүүхдэд дэмжлэг үзүүлэх, санал болгох хэрэгтэй. Эцэст нь хүүхдэд асуулт асуух, мэдээллээ баталгаажуулах олон боломжийг олгож, мэдээлэл, тайлбарыг тодорхой ойлгосон эсэхийг шалгахын тулд хүүхдүүдээс санал хүсэлтийг сонсох нь чухал юм. Хэрэв шаардлагатай бол давтаж, хялбарчилж, өргөжүүлж, тайлбарлах аргаар харилцана.

Нөхцөл байдлын үнэлгээн дэх ёс зүйн асуудлууд

Юуны өмнө, нийгмийн ажилтан зөвхөн хүүхэд болон тэдний асран хамгаалагчид зөвшөөрч байгаа тохиолдолд үнэлгээ хийх ёстой (асран хамгаалагчийг байлцуулах боломжтой тохиолдолд). Ийнхүү зөвшөөрөл авахдаа ил тод байж, хүүхэд, асран хамгаалагчийг хүндэтгэх ёстой бөгөөд зөвшөөрлийг тухайн тохиолдол тус бүрээр авч үзнэ. Хүүхэд зөвшөөрөл өгсөн бол асран хамгаалагчийн зүгээс шийдвэрийг хүчингүй болгох магадлал багатай. Зөвшөөрөл нь албадлагаар баталгаажсан эсвэл зөвшөөрөл хүссэн хүсэлтэд хариу өгөөгүй үед зөвшөөрсөн мэт үзэж болохгүй. Эцэг эхийн зөвшөөрлийг эцэг эхийн хэн нэгээс авч болно. Хэрэв зөрчилдөөн байгаа бол хэний зөвшөөрлийг баталгаажуулах талаар нийгмийн ажилтан сайтар бодож үзэх хэрэгтэй. Үнэлгээтэй холбоотой баримт бичгийн холбогдох хуулбарыг хүүхэд, асран хамгаалагчдад нээлттэй байлгана.

Мөн, хамтарсан багийн хүрээнд хуваалцсан мэдээлэл үнэн зөв, шинэчлэгдсэн, зорилгод шаардлагатай байгаа эсэхийг хянаж үзэх хэрэгтэй. Үүнийг гагцхүү харах шаардлагатай хүмүүстэй хуваалцаж, аюулгүйгээр хуваалцах хэрэгтэй. Үнэлгээний мэдээллийг хуваалцах, хадгалах ажлыг хууль ёсны дагуу хийж, хүүхэд, асран хамгаалагчаас дахин зөвшөөрөл авах ёстой. Зөвшөөрөл олгоогүй бол үүнийг цаашид лавлах зорилгоор тэмдэглэнэ. Хэрэв хүүхэд, асран хамгаалагчийн зүгээс бусадтай хуваалцсан мэдээллээс үнэлгээний хуудсанд оруулахыг хүсэхгүй байгаа бол нийгмийн ажилтан мөн хүслийг хүндэтгэх ёстой. Дээрхээс гадна, нийгмийн ажилтан нь хүүхэд болон бусдад хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдолд нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээллийг нягтлах ёстой. Энэ тохиолдолд нийгмийн ажилтан эдгээр шийдвэрийг үргэлж бүртгэх ёстой. Хэрэв эргэлзэж байвал мэргэжлийн удирдагчаас тусламж хүснэ.

Гэр бүлийн орчин бүрдүүлсэн асрамж, халамжийн үйлчилгээний сайн туршлага

Цөлийн сарнай ТББ-ын халамжийн төвд хүчирхийлэлд өртсөн хүүхэд хэрхэн хамгааллын үйлчилгээ авсныг үзүүлээ.

Үйлчлүүлэгч Х нь манай асрамжинд 2012 онд 9 настайдаа сургууль завсардсан, эцэг эх нь салаад аав дээрээ үлдсэн, амьдралын маш хүнд нөхцөлд амь нас эрсдэх аюултай гэсэн шалтгаанаар ирсэн. Эцэг эхийнхээ салалтад өөрийгөө буруутгадаг, ээжийгээ орхин явсанд үзэн яддаг, сургуульд орох насанд хүрсэн хэдий ч сургуульд ороогүй. Бид охиныг асрамжиндаа авч, аюулгүй байдлыг нь хамгаалж, албан бус сургалтад хамруулан, 5-р ангид орох жилээс нь ЕБС-д шилжүүлэн суралцуулсан.

6-р ангидаа буюу 11 настайдаа өөрийн хүсэлтээр гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн. Энэ үед аав нь архинаас гарсан, жижиг зүйл зарж хоол ундаа залгуулдаг болсон байсан. Сэтгэл зүйн хувьд эцэг эхийнхээ салалтад өөрийгөө буруутгадаг байсныг залруулан ойлгуулсан. Сэтгэлийн мэдрэмжийг хөгжүүлж, сэтгэл доторх ээждээ гомдсон гомдлыг гадагшлуулж чадсанаар ээжийгээ уучилсан. Мөн бусад хүүхдүүдийн адил сурах боломж байгаа гэдгийг ойлгож, ЕБС-д орж суралцаж чадсан ба ирээдүйдээ итгэл хүсэл мөрөөдөлтэйгээр гэртээ буцсан. Хэдийгээр амьдрал нь эрс сайжраагүй ч охин 12-р ангиа завсардалтгүйгээр суралцаж энэ жил төгсөх гэж байна. Тэрээр нийгмийн ажилтан болох хүсэл мөрөөдөлтэй (Дүфрэснэ Готьерын Сан, 2020).

Энэ жишээ нь асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхдэд хамгааллын үйлчилгээнээс гадна нөхөн сэргээх олон төрлийн үйлчилгээг үзүүлдэг болохыг харуулж байна.

? Мэдлэг шалгах асуултууд

1. Ямар тохиолдолд хүүхдийг хувилбарт асрамжийн үйлчилгээнд хамруулах шаардлагатай болох вэ?
2. Хувилбарт асрамжийн үйлчилгээнд баримтлах нийгмийн ажлын онолын хандлагуудаас өөрт хамгийн ойр санагдсан үзэл баримтлалыг сонгон гол онцлогийг хэлнэ үү?
3. Хувилбарт асрамжийн үйлчилгээний үеийн нөхцөл байдлын үнэлгээний ямар төрлүүд, ямар үе шат, түвшин байдаг вэ?
4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн онцлогуудаас дурдана уу?
5. Урт хугацааны асрах үйлчилгээнд байгаа хүүхэд, өсвөр үеийнхний нөхцөл байдлын үнэлгээний хүрээг тоймлон хэлнэ үү?

ГУРАВ

ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ АСРАХ ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

- 3.1 Үндсэн ойлголт
- 3.2 Арга зүй, аргачлал
- 3.3 Практик хэрэглээ, сайн туршлага

3.1

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Энэ сэдвийн хүрээнд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төлөвлөлтийн талаар авч үзэх болно. Үүний тулд юуны өмнө хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлтийн асуудлыг авч үзэх шаардлага бий болж байгаа бөгөөд нийгмийн ажилтнууд, хүүхэд хамгааллын ажилтнууд, ерөөс хүүхэд хамгааллын оролцогч талууд нь түүний онцлог, арга зүй, аргачлалын талаар нарийн ойлголт, мэдлэгтэй болох учиртай. Түүнчлэн, асрамжийн хувилбарт үйлчилгээний үед хүүхэдтэй ажиллах төлөвлөгөө бий болох ба энэ нь хувь хүний хөгжлийн төлөвлөгөө болон хүүхдийг асрах хувилбарт үйлчилгээний үеийн кейс төлөвлөгөө гэсэн төрөл хэлбэрүүдтэй байдаг.

Тиймээс уг сэдвийн хүрээнд хүүхэд хамгааллын төлөвлөгөө, асрамжид хамрагдаж буй хүүхэдтэй ажиллах кейс (менежментийн) төлөвлөгөө, түүнчлэн хүүхдийн хөгжлийн төлөвлөгөө зэргийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх бүтэц ба аргачлал, цаг хугацааны хүрээ зэргийн талаар хэлэлцэх болно. Уг сэдвийг судалснаар хүүхэд хамгааллын төлөвлөгөө болон хүүхэд асрах үйлчилгээний төлөвлөгөө, асрамжийн хувилбарт үйлчилгээний үед хүүхэдтэй ажиллах төлөвлөлтүүд ямар хэлбэртэй байх, тэдгээрийн онцлог шинж чанарын талаар мэдлэг эзэмших юм. Гэр бүлээс тусгаар орчинд асрамж халамжид байгаа хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллах кейс менежментийн үлэмж чухал хэсэг нь кейс төлөвлөлт билээ. Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжлийн хэрэгцээ өөрчлөгдөж шинэ мэдээлэл бий болох үед нөхцөл байдлын үнэлгээнд хэрэгцээний тухай ойлголтыг дахин шинэчлэх, үүний дагуу төлөвлөх хэрэгтэй болдог.

Төлөвлөлт нь ерөнхийдөө нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны (үйлчилгээний) үндсэн үе шат бөгөөд нөхцөл байдлын үнэлгээний дараа хийгддэг зүйл юм. Нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахдаа хүндрэлтэй орчин, асуудалтай зан үйл, эсвэл үйл ажиллагааг өөрчлөх зорилго, зорилтуудыг тодорхойлохоос гадна, үйлчлүүлэгчийн нөхцөл, хандлага, чадвар зэргийг хэрхэн өөрчлөх вэ гэсэн (стратеги төлөвлөлтийн асуудал), мөн өөрчлөгдсөн эсхийг хэмжих (хэмжилт, үнэлгээний) асуудлуудыг анхаардаг. Эдгээр нь төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэг болох зорилго, зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, үр нөлөө ба тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт зэрэгт тусгагдсан байх ёстой. Өөрөөр хэлбэл өөрчлөлт нь хэнд чиглэсэн, тэр өөрчлөлтийн нөлөө, үр шимийг хэн, хэзээ, яаж хүртэх гэдэг асуудлыг төлөвлөлтийн шатанд анхаарч тооцох хэрэгтэй болдог (А.Батхишиг, 2009, хууд. 104).

Нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөнд дараах бүрэлдэхүүн хэсгүүд багтана (А.Батхишиг, 2017). Үүнд:

- 1) Зорилго
- 2) Зорилтууд
- 3) Зорилт бүрд чиглэсэн үйл ажиллагаа буюу үйлчилгээ
- 4) Хүрэх үр дүн
- 5) Арга зам, стратеги (нийгмийн ажилтан ба үйлчлүүлэгчийн хүлээх үүрэг, бусад талуудын оролцоо)
- 6) Үр дүнд хүрэх буюу өөрчлөлт хийх хугацаа
- 7) Үр дүн, өөрчлөлтийг хэрхэн хэмжих тухай тус тус багтаасан байна.

Ерөнхийдөө, хүүхэд хамгааллын үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар эхлээд авч үзэх боломжтой. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт болон хүүхэд асрах хувилбарт

үйлчилгээний үеийн төлөвлөлт зэрэг нь ойлголтын агуулгын хувьд харилцан адилгүй болно. Уг зүй нь хүүхэд хамгааллын үйлчилгээ нь хамгийн өргөн агуулгатай бөгөөд энэ нь ерөөс хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүхий л үйлчилгээ, арга хэмжээг буюу хүүхэд хаана байхаас үл хамааран хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл хүүхэд хамгааллын төлөвлөгөө нь хүүхэд хаана ч аюул эрсдэлгүй байх ёстой бөгөөд үүнийг хоёр чиглэлд ангилж авч үзэх боломжтой. Нэг талаас, аль нэг улс орон хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлдэг бөгөөд үүний хүрээнд нийгмийн эд хэсэг бүрд хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулдаг байхыг шаарддаг. Гэр бүл, сургууль, сүм хийд, ажлын байр, олон нийтийн талбарт хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх болох ба түүний хүрээнд төлөвлөлт хийх тухай асуудал юм. Харин хүүхэд асрах үйлчилгээний төлөвлөлт нь асрах хувилбарт үйлчилгээнүүдийн үед хүүхэдтэй ажиллах төлөвлөлт юм. Нөгөө талаас, ямар нэг хүүхэд эрсдэлд орсон эсвэл орох магадлалтай бол түүнийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө бий болдог. Хүүхэд хамгааллын төлөвлөгөө нь хүүхэд асрахүйн төлөвлөгөөнөөс өргөн хүрээтэй ойлголт бөгөөд эрсдэл бүхий нөхцөл байдалд орсон хүүхэд бүрийн хувьд аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө юм. Харин хүүхэд асрах төлөвлөгөө нь хувилбарт үйлчилгээнд хамрагдсан хүүхэд бүрийн хувьд үзүүлэх үйлчилгээний төлөвлөгөө юм.

Зураг 8. Хүүхэд хамгааллын болон асрахүйн төлөвлөгөө



Нөхцөл байдлын үнэлгээний бүлэгт тодорхойлсончлон хүүхэд хамгааллын үеийн нийгмийн ажлын үйлчилгээ, тухайлбал кейс менежментийн үйлчилгээний төлөвлөлт нь нөхцөл байдлын үнэлгээний үед ямар онол үзэл баримтлал, аргагүйн хандлагыг баримталсанаас ихээхэн хамаарч ялгаатай байж болно. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ ямар үзэл баримтлал, арга зүй хандлагад тулгуурласан, ямар үр дүн гарсан нь эргээд үйлчлүүлэгчтэй ажиллах интервенц, үйлчилгээний төрөл хэлбэрийг төлөвлөх үндэс болно.

Хүснэгт 5. Нийгмийн ажлын онолуудын практик үзэл санаа

	Онолын нэр	Практик үзэл санаа
1	Сэтгэц шинжлэлийн онол	<ul style="list-style-type: none"> – Айдас ба хоёрдмол байдал амьдралын эхэн үед шийдэгдэж чадаагүй асуудлаас үүсдэг. – Ээнэгшил бол орчиндоо аюултай байдлыг мэдэрч буй үедээ хүүхдүүдийн зүгээс аюулгүй байлгаж чадна гэж төсөөлж буй хүмүүстэй ойр байхыг эрмэлзэж буй зан үйл болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл. – Дасан зохицох нь зан үйлийн гадна талын цаадах сэтгэл хөдлөл, хандлагыг талархан хариу үйлдэл үзүүлэх явдал. – Хамгаалалт ба эсэргүүцэл нь амьдралын асуудалтай тулгаран тэмцэх үеийн сэтгэлзүйн нийтлэг бэрхшээл. – Шилжилт ба эсрэг шилжилт нь сэтгэц шинжлэлийн техник шинжтэй нэр томъёо бөгөөд нийгмийн ажилд өнгөрсөн үеийн туршлага өнөөгийн зан үйлийн хэв загварт шилжих утгыг заадаг. – Хүмүүстэй хийх харилцааг үр дүнтэй сэтгэлгээ, өөрийн хяналт зэрэг чадварыг загварчлахад ашиглах боломжтой ба сэтгэлзүйн асуудлыг судлахад үйлчлүүлэгчид нөлөөлөх нөлөөлөл, итгэлийг олж авах хэрэгсэл болгох боломжтой. – Тунгаан ойлгохуй нь зан үйлийн хувьд тохиосон томоохон асуудлыг эргэн эргэн санах, юу болсныг, хэрхэн ийм үйл явдал болсныг, түүний үр дагавар нь сэтгэлзүйн ялгаатай үр дагаварт хүргэж болох байсныг бодох үйл явц юм.

2	Экологийн ба тогтолцооны онол	<ul style="list-style-type: none"> - Тогтолцоонууд нь гэр бүл, бүлгүүдийн хэлхээ холбоо, нөөцөд анхаарлаа төвлөрүүлж, эдгээрийг сайжруулахад тусалдаг. - Амьдралын бүхимдлын хүчин зүйлс нь хүмүүний энергийг тогтолцоо руу бүхимдлын хэлбэрүүдээр ашигладаг. Энэ тогтолцоо нь хувь хүн, гэр бүл, олон нийт байж болно. - Хувь хүн болон нийгмийн орчны дундын дасан зохицох, нийцэх асуудал нь экологийн сэтгэлгээн дэх чухал ойлголт юм. - Нийгмийн сүлжээ ба харилцан туслалцахуйг эхлүүлэх, хөгжүүлэх, хадгалах нь тогтолцооны үзэл санааны хөгжил мөн. - Даван туулах чадвар нь практик зорилт болохын хувьд экологийн сэтгэлгээнээс үүссэн.
3	Хямралын онол	<ul style="list-style-type: none"> - Хямрал нь хоёр чиглэлээр ашиглагддаг. Эхнийх нь нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчтэй ажиллахдаа тэдний амьдралын чухал үйл явдлуудад анхаарлаа төвлөрүүлэх, удаах нь хүмүүсийн амьдралд нийтлэг тохиолддог ч тэдгээрийг даван гарснаар эрийн цээнд хүрдэг тэр даваануудыг илтгэж байдаг. - Түр хугацааны буюу яаралтай тусламжийн интервенцүүдийг (бүтэцжсэн, төлөвлөсөн, шууд интервенцүүд) ашигладаг. - Тодорхой даалгаварт төвлөрсөн интервенцүүд бий болох болов ч, эдгээр нь хүмүүс хямралын интервенцийн үед нийгмийн эерэг харилцаагаа хадгалж үлдэх, сэтгэл ханамжийг олж авахын тулд даван туулах амьдралын сорилтууд юм. - Үйлчлүүлэгчтэй хийх гэрээ болон зөвшил нь тэд энэхүү интервенцэд оролцох, тусламжийн төлөвлөгөөг бүтэцчилэхэд тусалдаг.
4	Ээнэгшин дасахуйн онол	<ul style="list-style-type: none"> - Ээнэгшлийн хүндрэлүүд болох айдас, түгшүүрийг даван туулахад нь, түүнчлэн хуримтлагдсан, мартагдсан, ташаа ойлгогдсон ээнэгшлийн туршлагаа ойлгоход нь туслах болно. - Найдвартай, хоёрдмол, зайлсхийх, зохион байгуулалтгүй зэрэг ээнэгшлийн хэлбэрүүдийн үед үйлчлүүлэгчтэй ажиллах тактикууд бий болно. - Ээнэгшлийн дутмагшлаас үүссэн зан үйлийн гажуудлыг засварлах арга техникүүд бий болно. - Хүүхэд ба асрагчийн харилцааны ээнэгшлийн асуудал нь асрамж халамжийн үйлчилгээний практикт чухал байна.
5	Давуу талд тулгуурлахуй хандлага	<ul style="list-style-type: none"> - Деконструкц нь тухайн нөхцөл байдлын элементүүдийг шинжлээд эдгээр элементүүдийг тухайн нөхцөл байдалд ямар хүч бүтээн бий болгосныг судалдаг. - Дискурс нь тухайн нөхцөл байдлыг оролцогчдын хэл яриа хөөрөлдөөнийг судлах замаар илрүүлдэг. Практик ажилтнууд тухайн нөхцөл байдлын талаарх хүмүүсийн ялгаатай байр суурийг ойлгох боломжтой болгодог. Энэ үйл явц нь нөхцөл байдалд хариу үйлдэл, харилцан дэмжлэг үзүүлэх тогтолцоог илчилдэг - Эсэргүүцэх (үл хамаарах) нь хүмүүс амьдралдаа төсөөлсөн асуудлаа даван туулах амжилт бүхий зан үйлийн бүрдэл юм. - Ядуурал, дарангуйлалд байгаа хүмүүсийн давуу талыг үнэлэх, дэмжих тогтолцоог хөгжүүлээгүй явж ирсэн.
6	Хүчирхэг болгох хандлага (чадваржуулалт)	<ul style="list-style-type: none"> - Саад бэрхшээл болон хаагдмал байдал нь хүмүүс нийгмийн зорилтууддаа хүрэхэд хүндрэл учруулж болно. - Ядуурал, дарангуйлалд нэрвэгдсэн хүмүүст дасан зохицох чадавхыг сайжруулах, дарангуйлалд оруулж буй орчин, бүтцийн асуудлуудыг өөрчлөхийн төлөө ажиллахад нь тусалдаг. - Нийгэм дэх боломж болон нөөцийн тэгш байдлыг бүрдүүлэх шударга нийгмийн төлөөх нийгмийн бодлого ба хөтөлбөрүүдийг дэмждэг. - Хэвийнжүүлэлт нь (normalization) нийгэмд асрамж, халамжийн байгууллагуудад байгаа хүмүүсийн төлөөх орчныг бүтээх зорилготой. - Хүмүүс, ялангуяа гадуурхагдсан, шоовдорлогдсон, хаяг шошго наалгасан хүмүүс өөрсдийн амьдралдаа өөрсдөө хяналт тавих чадвартай болоход нь дэмжлэг үзүүлнэ.

Эх сурвалж: Mary Nash, 2005, Payne, 2014

Тухайн үйлчлүүлэгч хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд дээр дурдсан онолуудын практик утга санаа бүхнийг сайтар эргэцүүлэх, асрах үйлчилгээнд хамрагдах гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн асуудлыг эдгээр онолуудын өнцгөөс судлах шаардлагатай. Улмаар, аль нэг үзэл баримтлал нь илүү түлхүү, эсвэл хэд хэдэн үзэл баримтлал эн тэнцүү ач холбогдолтой байж ч болно, ерөөс амьдрал дээр дан ганц аль нэг үзэл баримтлалаар шийдэх асуудал оршдоггүй учраас холимог онол аргазүйд түшиглэдэг. Ийнхүү кейс төлөвлөлтийг онол аргазүйн үндэстэй эхлүүлэх бөгөөд хүчин төгөлдөр үзэл баримтлалуудын хүрээнд дэвшүүлсэн таамаглалууд батлагдсан тохиолдолд төлөвлөх шатанд үйлчлүүлэгчийн амьдралд нөлөөлөх үндсэн интервенцүүдийг тодорхойлох боломж бүрдэнэ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчноос тусад нь удаан хугацаагаар асрамжийн хувилбарт үйлчилгээнд хамруулахад сэтгэц шинжлэлийн, экологийн болон тогтолцооны, ээнэгшин дасахуйн зэрэг суурь шинжтэй онолуудын учир холбогдол өндөр байх болно. Түүнчлэн, богино хугацааны хямралыг бууруулах интервенц, хүчирхэг болгох буюу чадваржуулах, давуу талд суурилах хандлагын учир холбогдол түүнээс дутуугүй байх нь дамжиггүй.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төлөвлөх үйл ажиллагаа нь хүүхэд бүрийн хувьд кейс нээх байдлаар эхлэх болно. Гадаадын орнуудын туршлагаас харж байхад хүүхэд асрах үйлчилгээний төлөвлөлтийг 1), хувь хүний хөгжлийн төлөвлөгөө (individual development plan), 2) хувь хүний интервенцийн төлөвлөгөө (individual intervention plan) 3), байнгын төлөвлөгөө (permanence plan), 4) кейс төлөвлөгөө (case plan), 5) асрахуйн төлөвлөгөө (care plan) зэргээр нэрлэж байх юм. Эдгээр төлөвлөгөөнүүд нь ерөнхийдөө асрах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлуудыг хамардаг учраас ижил юм.

Хүснэгт 6. Асран халамжлах үйлчилгээний үеийн хүүхэдтэй ажиллах төлөвлөгөөний хэлбэрүүд

	Хэлбэр	Онцлог
1	Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө	Энэ нь хувь хүний хөгжил, төлөвшил, нийгэмшлийн асуудалд илүү анхаарахад чиглэсэн байдаг ба хүүхдийн нялх, балчир, хүүхэд насны эхэн үе, хүүхэд насны дунд үе, өсвөр, идэр залуу гээд хүний амьдралын мөчлөгүүд дагуу төлөвлөлт хийж байдаг.
2	Хувь хүний интервенцийн төлөвлөгөө	Энэ нь хүүхэдтэй ажиллах эрүүл мэнд, боловсрол, сэтгэл хөдлөл, нийгэмшил болон бусад хүрээнд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээнүүдийн хүрээнд цогц төлөвлөлт юм.
3	Байнгын төлөвлөгөө	Насан туршийн амьдралыг зохицуулах, зөвхөн асрамжийн газар болон хувилбарт асрахуйн тухайд биш түүнээс цаашид амьдралыг зохицуулах, удирдах арга ухаан, амьдрах чадвар бий болгох, байнгын эргэх холбоотой ажиллах төлөвлөлт юм.
4	Асрахуйн төлөвлөгөө	Асрамж халамжийн үйлчилгээний гол төлөвлөлт бөгөөд хүүхдийг аюулгүй байлгах, хүүхдийн хэрэгцээг хангах, хүүхдийн хүүхэд, асрагч, асран хамгаалагчтай холбоотой ажиллах,
5	Кейс төлөвлөгөө	Энэ нь нийгмийн ажлын сонгодог нэр томъёо бөгөөд хүүхэд төвт хандлага, тухайн хүүхэдтэй ажиллах кейс менежментийн үеийн ойлголт юм.

Эх сурвалж: Зохиогч боловсруулав.

Хүүхдийг аль нэг хувилбараар асрах нь хувь хүнийг асрах төлөвлөгөөний дагуу буюу түүнийг удирдлага болгоно. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төлөвлөгөө нь хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний бусад бүхий л үйл ажиллагааны нэгэн адил чанарын нийтлэг стандарттай байдаг (SCSA, 2019). Хүүхэд асрахуйн төлөвлөгөө нь дараах чанарын шалгууруудыг хангаж байх учиртай.

Хүснэгт 7. Хүүхэд асрах төлөвлөгөөний чанарын шалгуур ба гүйцэтгэлүүд

	Шалгуур	Гүйцэтгэл
1	Хувь хүнийг асрах төлөвлөгөө нь хүүхэд хувилбарт асаргаанд ирэхээс өмнө боловсруулсан байх ёстой.	<p>Асрахуйн төлөвлөгөөг боловсруулахад хамтарсан багийн хандлагаар хийгдэх ёстой.</p> <p>Асрахуйн төлөвлөгөөг боловсруулахад оролцсон бүхий мэргэжилтнүүд болон насанд хүрэгчид нь хүүхэд төвт хандлагыг баримтлах хэрэгтэй.</p> <p>Хэрэгцээний нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхдийг эрсдэлд оруулахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.</p> <p>Асрах үйлчилгээнд байгаа хүүхдийн зорилго нь асрахуйн төлөвлөгөөнд онцгойлон тусгагдах ёстой.</p> <p>Асрахуйн төлөвлөгөө нь дараах хүрээг хамаарна: Хүүхдийн эрүүл мэндийн хэрэгцээ Боловсролын хөгжлийн хэрэгцээ Сэтгэл хөдлөлийн хэрэгцээ Шашны итгэл үнэмшил, соёлын болон угсаатны байдал Хүүхдийн хэрэгцээ, зорилгыг тусгасан алхмууд ба арга хэмжээнүүд Хүүхдийн мөрөөдөл ба урам зориг Хүүхдийн богино болон урт хугацааны зорилго Хүүхдийг асрахуйн хувилбарт хамруулах шийдвэр</p> <p>Тэдний эцэг эх, ах дүүс, болон бусад чухал насанд хүрэгчидтэй хийх холбоо харилцаа</p>
2	Асрахуйн төлөвлөгөөг тогтвортой хянаж байх хэрэгтэй.	<p>Нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтнууд тодорхой хугацааны давтамжтай байнга зочилж асрамжид байгаа хүүхдийн амьдралд хөндлөнгийн үнэлгээ буюу үзлэг хийнэ</p> <p>Асрамжийн хүүхдүүдийн хэрэгцээ байнга өөрчлөгддөг тул асрах төлөвлөгөөг тусламж үйлчилгээний үзлэгийн үеэр тогтмол шинэчлэх шаардлагатай</p> <p>Тусламж үйлчилгээний өмнөх үзлэгийн үеэр хийгдсэн аливаа өөрчлөлтийн үр нөлөөг үнэлсэн байх ёстой</p> <p>Асрамжийн үзлэгт хамрагдахаас өмнө хүүхдэд тэдэнд үзүүлж буй анхаарал халамжтай холбоотой аливаа зүйлийн талаар өөрийн хүсэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэх хүчирхэг байдал олгож, дэмжлэг үзүүлэх шаардлагатай</p> <p>Хүүхэд өөрсдийн эцэг эх, ах эгч нар болон бусад чухал хүмүүстэй хийх харилцаа холбоотой байх ба үүнийг үнэлэх ёстой</p> <p>Хүүхдэд асаргааны хувилбарын талаар түүний тохиромжтой эсэхийг үнэлж, хянаж байх ёстой</p> <p>Хэрэв энэ нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэж байгаа бол хүүхдийг гэр бүлд нэгтгэх зорилгоор эцэг эхийн нөхцөл байдлыг үнэлэх учиртай</p>
3	Асрахуйн төлөвлөгөөг боловсруулахад хүүхдийн оролцоо	<p>Хүүхэд өөрийн асрахуйн төлөвлөгөөг боловсруулах болон түүнийг хянах уулзалтад өөрийн үүргийн талаар ойлгох чадвартай, хүчирхэг байхын тулд дэмжлэг авах ёстой.</p> <p>Хүүхэд өөрийн асрахуйн төлөвлөгөөг хэлэлцэх явцад томчуудтай нэгэн адил дуу хоолойтой байх ёстой.</p> <p>Хүүхэд уулзалтын гол сэдэв байх бөгөөд түүний тав тух болон хэрэгцээ нь эн тэргүүнд чухалчлагдах болно.</p> <p>Эцэг эхчүүд хүүхдийн асрахуйн төлөвлөгөөг боловсруулахад оролцох ёстой.</p> <p>Хүүхэд ба эцэг эхчүүдэд асрахуйн төлөвлөгөөний хуулбарыг өгнө.</p> <p>Бүхий л мэдээлэл нь насны хувьд тохиромжтой, хүүхдэд хүртээмжтэй байхыг чухалчилсан хэлбэртэй байх ёстой.</p>
4	Хүүхдүүд асрамжийн үйл явцыг орхиж явахад бэлтгэх	<p>Хүүхдүүд идэр залуу насанд шилжин асрамжийн үйл явцыг орхиход бэлтгэгдэх чиглэлд дэмжлэг авах, хүчирхэг болох ёстой.</p> <p>Идэр залуугаас бие даан амьдралд шилжих нь төлөвлөгдсөн, хэрэгжилтэд төвлөрсөн байх хэрэгтэй.</p>

Эх сурвалж: SCSA, 2019

3.2

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Юуны өмнө, нийгмийн аливаа хөтөлбөр, төсөл, интервенцийг сайн төлөвлөхдөө баримтлах ерөнхий аргазүй бол SMART юм. Энэ нь товчилсон хэллэг төлөвлөлтөд тавих нийтлэг шаардлагууд гэж болно. Эдгээр нь 1) Тодорхой байх буюу хийх зүйл нь тодорхой (Specific); 2) Төлөвлөсөн үр дүн, өөрчлөлтийг нь хэмжиж болохуйц (Measurable); 3) Төлөвлөсөн үр дүндээ хүрэх боломжтой буюу өөрчлөлтийг төлөвлөсөн ёсоор хийж болохуйц (Achievable); 4) Төлөвлөж буй ажил нь бодитой (Realistic); 5) Тодорхой цаг хугацаатайгаар төлөвлөх (Time-limited) зэрэг болно. Нийгмийн ажилтан кейс менежер болохын хувьд үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх цогц үйл ажиллагааг төлөвлөхдөө энэ шаардлагыг хангах мэдлэг, үр чадварыг эзэмшсэн байх нь чухал билээ.



Шигтгээ 4. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага: Төлөвлөлтийн шат

4.4 Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат

Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц.

6.3.3 Үйлчилгээг төлөвлөхүй

Үйлчилгээний төлөвлөгөө нь тодорхой, бодитой байх ёстой бөгөөд үйлчлүүлэгч, гэр бүлийн давуу тал дээр суурилсан, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд тулгуурлаж боловсруулагдана.

Үйлчилгээний төлөвлөгөөнд үйлчлүүлэгч, түүний гэр бүлд учирч болзошгүй аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд үзүүлэх үйлчилгээг нарийн тусгана.

Зарим тусгай нөхцөл байдалд нэг гэр бүлийн гишүүн бүрд зориулсан төлөвлөгөө гаргаснаас үйлчлүүлэгч бүрийн онцлог хэрэгцээг тусгасан гэр бүлийн төлөвлөгөө гаргана.

Нийгмийн ажилтан тухайн үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олон нийтийн түвшинд шийдвэрлэх, эрхийг нийгмийн саад бэрхшээлгүй эдлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

Үйлчилгээний төлөвлөгөө нь бодитой, хэрэгжихүйц байх бөгөөд нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчид одоогийн байгаа нөөц боломжийн хүрээнд хийх үйлчилгээнүүдийн талаар дэлгэрэнгүй тусгаж, үйлчилгээний гэрээ байгуулна.

Мэргэжлийн, цогц, чанартай үйлчилгээ үзүүлдэг байгууллагад тухайн кейсийг холбон зуучлах эсвэл шилжүүлнэ.

Нарийн төвөгтэй кейсийн хувьд төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үнэлэхийн тулд хамтарсан багаар ажиллах, мэргэжлийн байгууллагууд хоорондын хамтарсан хурлаар кейс хэлэлцүүлэг хийж, тэмдэглэл хөтөлнө.

Эх сурвалж: Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022


Төлөвлөлтийн шатанд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй хамтран хийх гэж буй өөрчлөлт, хүрэх үр дүнгийнхээ талаар юуг, яаж хийх хэрэгтэй, яагаад хийх хэрэгтэй, хэзээ хийх хэрэгтэй гэдгийг нарийвчлан ярилцаж, ямар үйл ажиллагааг хэн нь хариуцах талаар харилцан тохирдог. Тиймээс, нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөг зарим тохиолдолд үйлчилгээний гэрээ гэж нэрлэдэг (А.Батхишиг, 2009). Өөрөөр хэлбэл нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөгөөг нийгмийн ажилтан бие даан үйлчлүүлэгчийн өмнөөс бодож төлөвлөх нь зохисгүй үйлдэл бөгөөд үйлчлүүлэгчийн өмнөөс асуудлыг нь тодорхойлж, санал бодлыг нь харгалзахгүй үйлчилгээгээ төлөвлөх нь нийгмийн ажлын хэд хэдэн үнэт зүйлсийг зөрчихөд хүргэнэ. Нийгмийн ажлын практикт үйлчлүүлэгч өөрийгөө тодорхойлох, үйлчлүүлэгч өөрийн эрх ашиг, хүсэл сонирхлоо илэрхийлэх, үйлчлүүлэгч өөрийн амьдралтай холбоотой асуудлыг шийдэхэд оролцох эрхтэй зэрэг зарчмыг хүндэтгэн үзэх нь их чухал. Тиймээс үйлчлүүлэгчийн бодол санаа, хүсэл буй өөрчлөлт нь тухайн үйлчлүүлэгч болон бусад хүмүүст хор хохирол, аюул учруулж болзошгүй тохиолдлоос бусад тохиолдолд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийг дэмжин, хамтран ажиллах үүрэгтэй.

Үйлчилгээ үзүүлэхдээ төлөвлөлт хийх гол тулгуур бол хүүхдийн амьдралд хийсэн нөхцөл байдлын үнэлгээний үр дүн юм. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувьд эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлын үнэлгээ, давуу талын үнэлгээ гэсэн үнэлгээний бусад хэлбэрүүдийг цогцоор нь хийх тухай нийгмийн ажлын үйлчилгээний стандартад тодорхойлсон. Тиймээс, хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах, тэдгээрийг гэр бүлээс нь тусгаар орчинд урт хугацаагаар асрахуйн үйлчилгээнд хамруулан ажиллах үйлчилгээний төлөвлөлт олон талын хүчин зүйлсийг тооцсон, арга хэмжээ, интервенц бүхий нэлээд нарийн үйл ажиллагаа болж байна. Ерөнхийдөө кейс төлөвлөлт хийнэ гэдэг нь дараах хэдэн утга санааг агуулж байдаг (Г.Түмэннаст, 2018).

- Төлөвлөлт гэдэг нь хэн хэзээ юуг хэрхэн хийхийг хэлэлцэн гаргана гэсэн үг юм.
- Төлөвлөлт нь кейс менежер, үйлчлүүлэгч болон бусад талуудын хамтран хийх ёстой зүйл.
- Төлөвлөлт гэдэг нь өөрчлөхөөр зорьж буй нарийн төвөгтэй тогтолцоо, хүчин зүйлс, зан үйлийн тухай ярилцана гэсэн үг.
- Төлөвлөлт гэдэг нь хүссэн өөрчлөлтүүд гарсан эсэхийг хэрхэн хэмжих асуудлуудыг ч анхаарна

Хүүхдийг урт хугацаагаар гэр бүлийн орчноос тусгаар орчинд асрах хувилбарт үйлчилгээний үед нийгмийн ажилтан кейс менежерийн хувьд кейс төлөвлөлт хийх болно.

Зураг 9. Кейс менежментийн үндсэн үе шатууд: Кейс төлөвлөлт



Эх сурвалж: CPWG, 2014

Нөхцөл байдлын үнэлгээ дууссанаас хойш хоёр долоо хоногийн дотор кейс төлөвлөгөөг боловсруулах ёстой. Энэхүү төлөвлөгөө нь нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн үйлчлүүлэгч хүүхдийн хувьд тодорхойлсон хэрэгцээг хангахын тулд юу хийж болох, хэн үүнийг хийх, хэзээ хийхийг тодорхойлох ёстой. Түүнчлэн хүүхдийн эрсдэлийн түвшин, хэрэгцээ шаардлагаас хамааран хүүхдийн нөхцөл байдлыг тогтмол хянах төлөвлөгөөг багтаасан байх ёстой. Кейс төлөвлөгөөнд богино (яаралтай) хугацааны, дунд болон урт хугацааны үйл ажиллагаануудыг авч үзэх ёстой. Кейс менежер нь боломжтой бөгөөд тохиромжтой тохиолдолд хүүхдэд төлөвлөгөөний энгийн бичмэл хуулбарыг өгөх ёстой. Хүүхэд хамгааллын эрсдэлийг шийдвэрлэхийн тулд гэр бүлийн хэрэгцээг тодорхойлж, хүүхдийг хамгаалах, асран халамжлах гэр бүлийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн гэр бүл төвтэй хандлагыг баримтлах шаардлагатай. Энэ нь хүүхэд асрах хийгээд халамжлах хувилбарт үйлчилгээний үед ч баримтлах шаардлагатай хандлага бөгөөд хүүхэд гэр бүлийн харилцаа холбоог хүндэтгэн үзнэ (CPWG, 2014).

Кейс төлөвлөгөөг боловсруулахад хүүхэд, гэр бүл бүрэн оролцох ёстой. Зарим тохиолдолд кейс ажилтан хүүхдийн амьдралд чухал ач холбогдолтой бусад хүмүүс болон боломжтой бөгөөд тохиромжтой тохиолдолд бусад үйлчилгээ үзүүлэгч болон холбогдох эрх бүхий байгууллагуудыг оролцуулсан албан ёсны кейс төлөвлөлтийн уулзалтыг зарлан хуралдуулж болно. Хэрэв кейс менежер болох нийгмийн ажилтан кейс төлөвлөлтийн хурлыг зохион байгуулахад хүүхэд, гэр бүлийг хэрхэн утга учиртай оролцуулах талаар бодох хэрэгтэй. Төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд учрах саад бэрхшээл тулгарах, үйлчлүүлэгчийн дотоод гадаад аюул, эрсдэл бий болоход ямар арга хэмжээ авах талаар төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Санамсаргүй хүчин зүйл бүхнийг тооцоолон төлөвлөх нь амьдрал дээр төвөгтэй байдаг. Магадгүй зарим тохиолдолд хуучин кейс төлөвлөлтийг хэрэгжүүлэх гэж зүтгэж байснаас шинэ төлөвлөгөө боловсруулах кейс төлөвлөлтийн хурлыг зохион байгуулах нь хялбар байж болох юм.

Кейс төлөвлөгөөг боловсруулахын тулд тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх хийгээд зарим нэг зарчмыг баримтлах нь зүйтэй билээ. Нийгмийн үйлчилгээний байгууллагын ажилтнуудын дэлхийн холбооноос нийгмийн үйлчилгээний байгууллагын хүрээн дэх кейс менежментийн ерөнхий зарчмуудыг тодорхойлжээ (Florina Balint, 2018). Үүнд, даван туулах чадварыг дээшлүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, хамтын ажиллагаа ба түншлэлийг бий болгох, үйлчлүүлэгчийн давуу талыг хүндэтгэх, дэмжих, соёлын ялгаа ба уламжлалыг хүндэтгэх, хүний эрхэд суурилсан хандлагыг баримтлах, нууцлалыг хадгалах, чанарын баталгааг хангах зэргийг дурдсан байна. Хөгжиж буй орнуудын туршлагаас харахад хүүхэд хамгааллын кейс менежментийн үед дараах ерөнхий зарчмууд бий болдог байна (Makwana, 2015).

Хүснэгт 8. Хүүхэд хамгааллын кейс менежментийн зарчмууд

Зарчмууд	Тайлбар
Хор хөнөөл бүү учруул	Хүүхэд болон гэр бүлийг дэмжих арга хэмжээ, интервенцүүд нь түүнд цаашид хор хөнөөл учруулахгүй байхаар боловсруулах, төлөвлөх болно.
Хүүхдийн дээд ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих	Хүүхдийн дээд ашиг сонирхол нь аливаа шийдвэр гаргах хийгээд хүүхэд болон гэр бүлд үзүүлж буй үйлчилгээний үйл явц, харилцааны үндэс суурь болно.
Эргэх хариуцлагыг ханга	Хэн нэгэн үйлдэлдээ хариуцлагатай байх ба хариуцах болно.
Хүүхдийн хөгжил ба эрхийн тухай мэдлэгт суурил	Нийгэм соёлын нөхцөл байдал дахь хүүхдийн хөгжлийн тухай ойлголт, мэдлэг болон хүүхэд хамгааллын бүх талын эрх дээр суурилсан үнэлгээ хийх ба интервенц төлөвлөнө.
Хүүхдийн үзэл бодлыг сонс, нухацтай авч үз	Хүүхдүүдтэй идэвхтэй зөвлөлдөж, тэдний үзэл бодлыг ойлгож шийдвэр гаргахад чухалчилна.

Соёлын хувьд нийцтэй үйл явц хийгээд үйлчилгээг үзүүл	Олон нийтийн дундах ялгаатай байдлыг хүндэтгэнэ.
Зөвшөөрөгдсөн мэдээлэлд суурил	Зөвшилцөх, чөлөөт сонголт хийх чадамжийг хүндэтгэж, хүмүүс сайн дураараа өгөх зөвшөөрлийг олж авна.
Нууцлалыг хүндэл, мэдэх хэрэгцээнд мэдээлэл хуваалц	Мэдээллийн нууцлалыг хангах ба гагцхүү зайлшгүй шаардлагын улмаас эрх үүрэг бүхий хүмүүст задалж болно. Гэвч, нууцлалаас бусад тохиолдолд мэдээллийг ажлын хэрэгцээнд суурилан хуваалцана.
Ялгаварлан гадуурхлаас ангид ажил	Ялгаатай хүүхдүүд ижил эрх гэсэн зарчмыг гол мөрдлөг болгоно.
Мэргэжлийн хил хязгаар ба сонирхлын зөрчлөөс зайлсхий	Хүүхэд болон гэр бүлийн итгэлийг хүлээж ажиллах ба давуу байдал, эрх мэдэлд суурилсан харилцааг үл хэрэглэнэ.

Кейс төлөвлөгөөг боловсруулахдаа оролцоог хангах зарчим бол кейс менежерүүдийн хувьд чухал бөгөөд анхаарах асуудал юм.

Зураг 10. Кейс төлөвлөхөд оролцоог хангах нь

Кейс төлөвлөгөөг боловсруулах нь оролцогч талуудын хамтаар хийж гүйцэтгэх ёстой зүйл мөн.

Үйлчлүүлэгчийн оролцоо бол бодитой, үр дүнтэй төлөвлөлтийн хамгийн чухал хүчин зүйл юм.

Үйлчлүүлэгчийн тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд оролцогч талуудыг оролцуулах нь зайлшгүй юм.

Үйлчлүүлэгч бол эцсийн үг дүнг өөрөө тодохойлох учиртай.

Үйлчлүүлэгч зорилгод хүрэх арга замуудыг тодорхойлоход өөрөө саналаа хэлэх учиртай.

Үйлчлүүлэгч өөрт бий болох өөрчлөлтийг хэрхэн тодорхойлох вэ гэдэгт амлалт өгөх ёстой.

Кейсийг төлөвлөхөд менежерүүдийн зүгээс 1) Үйлчлүүлэгч, 2) Эцэг эх, асран хамгаалагч, эсвэл хүүхдэд чухал ач холбогдол бүхий бусад насанд хүрэгч, 3) Асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэгч (асрагч, асралт гэр бүл, өргөсөн эцэг эх) болон нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, боловсрол) үзүүлэгчид, 4) Нийгмийн тусгай мэргэжил (сэтгэлзүйч, сэтгэцийн эмч, засалч, нөхөн үржихүйн эмч, хөгжлийн бэрхшээл судлаач, заах арга зүйч багш гм) зэрэг талуудын оролцоог хангах шаардлагатай.

Кейс менежерийн төлөвлөлтийн үед анхаарах дараагийн нэг асуудал бол үйлчилгээний багцыг иж бүрнээр тодорхойлох, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах учиртай. Чухам үүнд л кейс менежментийн мөн чанар болон үйлчилгээг уялдуулан зохицуулах буюу уялдаа холбоог хангах асуудал гарч ирнэ. Үйлчлүүлэгчийг түүнд хэрэгцээ шаардлагатай байгаа үйлчилгээнд нь холбох, тэдгээр үйлчилгээнүүдийг өөр хооронд нь уялдуулан зохицуулах [coordination] замаар үйлчилгээний цогц хийгээд үргэлжлэх боломжийг бүрдүүлэх явдал юм. Хэрэв үйлчлүүлэгч олон төрлийн үйлчилгээг хэд хэдэн агентлагуудаас авч байгаа бол кейс менежерийн үүрэг амин чухал болж ирдэг. Энэ үүргийг хувь хүн, гэр бүлийн хэрэгцээг хангах нийгмийн үйлчилгээний төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх болон түүнд хяналт, үнэлгээ хийх үйл ажиллагаа хэмээн тодорхойлох нь бий.

Кейс менежерийн үүрэг нь хоёр үндсэн загвартай бөгөөд эхнийх нь үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээнүүдийг уялдуулан зохицуулах [coordination] үйл ажиллагаагаар хязгаарлагддаг. Харин удаах нь, зохицуулах чиг үүрэг дээр нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн хамгийн ойрын

зөвлөгч болон засалч [therapist] байх болдог. Зохицуулагчийн үйл ажиллагааны загвар нь хүүхэд хамгааллын салбарт, харин зохицуулагч, зөвлөгч [засалч] загвар нь сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээнд ихээхэн хэрэглэгддэг. Мокслеи [Moxley] кейс менежментийн үйл ажиллагаа нь үйлчлүүлэгчийн түвшин дэх зорилго, үйлчилгээ, болон мэдээллийг уялдуулан зохицуулах, үйлчлүүлэгчийн төлөө [үйлчилгээ үзүүлэгчийн төлөө] хариуцлагыг төвлөрүүлэх, тиймээс тусламжийг нэг мэргэжлийн эсвэл мэргэжилтнүүдийн багийн зүгээс нэгдмэл утгаар харах, үйлчлүүлэгчид үйлчилгээг хүртээмжтэй байлгах зэрэг үндсэн чиг үүргүүдийг тоочсон байдаг (Г.Түмэннаст, 2017). Дээрхээс гадна Кейс менежментийн тогтолцоо нь нийгмийн үйлчилгээний байгууллагын хүрээнд зохицуулах, дэмжих, хянах үнэлэх гэсэн гурван үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Түүнчлэн, кейс төлөвлөгөөг боловсруулахдаа өөр хоёр ойлголтыг байнга санах нь зүйтэй гэжээ (CPWG, 2014). Хос замын төлөвлөлт – үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхийн тулд интервенцийн хос хувилбаруудыг тооцоолон тодорхойлох. Жишээлбэл хичээл хоцролтоос урьдчилан сэргийлэхийн тулд хоёр ба түүнээс дээш өөр арга хэмжээнүүд нэгэн зэрэг хэрэгждэг. Хэрэв үйлчлүүлэгч хүүхэд сургуульд сурдаггүй бол сургуульд оруулах, мөн багш хайх талаар бодож болно. Байнгын төлөвлөлт – үйлчлүүлэгч хүүхдэд зориулсан кейс төлөвлөгөө нь тэдний богино, дунд, урт хугацааны хэрэгцээг хангах ёстой. Удаан ашиглах, урт хугацааны шийдлийг эрэлхийлэх хэрэгтэй. Нийгэм хүмүүнлэгийн тодорхойгүй байдлын нөхцөл байдалд энэ нь хэцүү байж болох ч урт хугацааны төлөвлөлтөд чиглүүлэх нь хүүхдийн ашиг сонирхолд үргэлж нийцдэг.

3.3

ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Дээр дурдсанчлан, төлөвлөлт бол нийгмийн ажлын ерөнхий практикийн үндсэн үе шатуудын нэг бөгөөд үйлчлүүлэгчийн нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд тулгуурлан хийгддэг зүйл юм. Ерөнхий хүүхэд хамгааллын үйлчилгээний үеийн кейс төлөвлөлт болон хүүхдийг урт хугацаанд гэр бүлээс тусгаар орчинд асран хамгаалах үйлчилгээний үеийн төлөвлөлт ялгаатай ойлголт билээ. Олон улсын байгууллагын эх сурвалжуудад хүүхэд хамгааллын үйлчилгээний үеийн болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний төлөвлөлтийн хүрээнд зарим сайн жишээнүүдийг авч үзсэн байна (LSCP, 2022) (FSA, 2009).

Манай гэр бүл нийгэмлэг ТББ

Анх 2003 онд “Манай гэр бүл нийгэмлэг” ТББ үүсгэн байгуулагдэжж. Тус төв нь эрсдэлт нөхцөлд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авч, асран халамжлах үйлчилгээг үзүүлдэг. Хүүхдийн өөрийнх сонирхолд нийцүүлэн төлөвлөлтийг хамтран хийж, тэднийг амьдрах ухаанд сургадаг. Тус төв нь хүүхэд идсэн жимснийхээ үрийг хөрсөнд суулган ургуулах, улмаар өөрийн хэрэгцээг хангах хүнсний ногоог тарих, өөртөө дээл, хувцас хийгээд өмсчихдөг бие даан амьдрах чадвартай, бие бялдар, сэтгэл зүй, эдийн засгийн хувьд хэн нэгнээс хараат бус, сэтгэл төвшин бие хүн болгон төлөвшүүлэхэд анхаардаг байна.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний сайн жишээ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асран хамгаалж, дэмжин туслах үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагуудыг сайн жишээг нэгтгэн Хүүхдийн эрх, хамгаалал ба практик үйл ажиллагаа нэртэй тохимолыг Канадын Дүфрэнсэ Готьерын Сангаас 2020 онд хэвлэн олны хүртээл болгосон. Энд тохимолд орсон хоёр сайн жишээг толилуулж байна.

Жишээ 1: Манай гэр бүлийн гишүүдийн нэг А нь 8 настай ирсэн. Тэрээ зан авирын хувьд зөрүүд гөжүүн, зан ааш тогтворгүй, ууртай ширүүн, шаардлага хүлээж авдаггүй, хэнтэй ч нийтэч биш харьцаатай хүүхэд байв. Түүнтэй харилцаж ойлголцох, ярилцах тун хэцүү, хугацаа ч их зарцуулагдахыг мэдэж байсан. Энэ хүүхэдтэй эерэг зөөлөн, зөв хандлагаар өөрт нь нөлөөлж чадсанаар оюун ухаан, сэтгэн бодох чадвар маш сайн хөгжөөд байгааг анзаарсан. Хүүхэд маань ЕБС амжилттай дүүргэж МСҮТ-д суралцаад, дээд сургуульд үргэлжлүүлэн суралцсан. Одоо Япон улсад гэр бүлийн гишүүний хамтаар суралцаж байна.

Жишээ 2: Манай гэр бүлийн гишүүдийн нэг болох Т нь 8 сартайдаа манай төвд ирсэн. Эцэг нь эрхээ хасуулж ял эдэлж байх хугацаанд эхнэр нь ар гэрийн эргэлтээр тодорхой хугацаанд хамт байхдаа жирэмсэлсэн байдаг. Эх нь төрөх үедээ БЗХӨ байсан ба хүүхэд маань ирэхдээ эхээс урагт халдварласан өвчтэй байсан. Бараг хоёр сарын хугацаанд тасралтгүй эмнэлгийн хяналтанд байлгаж, уйгагүй эмчлүүлсний үр дүнд бид хүүхдээ эдгээж байсан. Одоо тэрээр 17 настай. Сурлага сайтай, ангидаа манлайлагч сурлагатай сурагч болсон.

Эх сурвалж: Дүфрэнэ Готьерын Сан, 2020 он. Хүүхдийн эрх, хамгаалал: Практик Үйл ажиллагаа. Улаанбаатар.

Энэ хоёр жишээ нь асрамж халамжийн төвд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг удаан, тасралтгүй үзүүлж, хүүхдийг тууштай дэмжиж чадвал хэрхэн үр дүнд хүрч болохыг харуулж байна.

Их Британи улс

Их Британи улсын хүүхэд хамгааллын болон түүний аргачлалын журам нь сайн туршлагын нэг болж байгаа бөгөөд уг эрх зүйн баримт бичгийг тогтмол сайжруулж ирсэн байдаг. Хамгийн сүүлд 2022 онд шинэчлэн найруулсан байна.

Хүүхэд хамгааллын төлөвлөгөө

Их хэмжээний хохирол амссан эсвэл өртөх эрсдэлтэй гэж үзсэн хүүхэд бүр хүүхэд хамгааллын төлөвлөгөөтэй байх ёстой бөгөөд үүнийг харилцан зөвшөөрч албажуулж бүртгэсэн байна.

Төлөвлөгөөний нарийвчлалыг хамтарсан баг* (core group) боловсруулна;

Хүүхэд хамгааллын төлөвлөгөөний ерөнхий зорилго нь: хүүхдийн давуу талыг дэмжих, эмзэг байдал, эрсдэлт хүчин зүйлсийг арилгах, хангагдаагүй хэрэгцээг хангахад туслах замаар хүүхдийн аюулгүй байдлыг хангах, цаашид хохирохоос урьдчилан сэргийлэх; хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд, хөгжлийг дэмжих; болон Хүүхдийн ашиг сонирхолд нийцсэн тохиолдолд гэр бүл, өргөжсөн гэр бүлийн гишүүдийг хүүхдийнхээ сайн сайхан байдлыг хамгаалах, дэмжихэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Хэрэв хүүхэд хамгааллын төлөвлөгөө эдгээр зорилтыг биелүүлж чадахгүй бол хүүхэд хамгааллын талаар бага хурлыг эрт зарлан хуралдуулна.

Хүүхэд хамгааллын төлөвлөгөө нь хүүхэд, гэр бүл болон холбогдох бүх мэргэжилтнүүдэд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага буюу асуудлын мөн чанарыг тодорхой зааж өгөх ёстой.

Хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд ямар ажлыг, яагаад, хэзээ, хэн хийх ёстойг тусгасан байх ёстой. Төлөвлөгөөг боловсруулахдаа хэд хэдэн зүйлийг сайтар харгалзах шаардлагатай боодог. Үүнд хүүхдийн үйлчилгээг хэзээ, ямар нөхцөлд хүүхдийн ахлах нийгмийн ажилтан ганцаараа болон

гэр бүлийн бусад гишүүд, асран хамгаалагчидтай хамт үзүүлэх, хүүхдийн хувьд тодорхойлсон хөгжлийн хэрэгцээ болон заслын ямар үйлчилгээ шаардлагатай байгааг тайлбарлах, хүүхдийн сайн сайхан байдлыг хамгаалах, дэмжих зорилготой тодорхой, хүрч болохуйц, хүүхдэд чиглэсэн үр дүнг оруулах, төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд бодитой стратеги, тодорхой арга хэмжээг багтаах, нөхцөл байдал мэдэгдэхүйц өөрчлөгдөж, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай бол дагаж мөрдөх Онцгой байдлын төлөвлөгөөг оруулах, мэргэжлийн хүмүүс болон гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг, тэр дундаа мэргэжлийн хүмүүсийн хүүхэд, гэр бүлийн гишүүдтэй харилцах шинж чанар, давтамжийг тодорхойлох, ахиц дэвшлийг шалгах чиглэлүүд, тэдгээр ахиц дэвшлийг үнэлэх арга хэрэгслийг тодорхойлох; болон хүүхэдтэй тогтмол харьцдаг мэргэжилтнүүдийн (жишээлбэл. эрүүл мэндийн ажилтан, ерөнхий эмч, багш нар, түүнчлэн хүүхэд, гэр бүлд мэргэжлийн болон зорилтот дэмжлэг үзүүлдэг мэргэжилтнүүд) үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгөх хэрэгтэй юм.

Дээрхээс гадна, хүүхэд, эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын төлөвлөгөө гэдэг нь хүүхэд (түүний нас, ойлголтоос хамааран) болон эцэг эх нь хүүхдийн сайн сайхан байдлыг хамгаалах, дэмжих төлөвлөгөөний хүрээнд юуг өөрчлөх шаардлагатай, юуг тэднээс хүлээж байгаа зэргийг тодорхой мэдэж байх ёстой юм. Тэдэнд бий болсон хор уршгийн талаарх нотлох баримт тодорхой байх ёстой бөгөөд үүний улмаас хүүхэд хамгааллын төлөвлөгөө гарган ажиллахад хүргэсэн гэдгийг тайлбарлана. Энэ нь ахлах нийгмийн ажилтан болон холбогдох бусад мэргэжилтнүүдтэй үргэлжлүүлэн ярилцах сэдэв юм. Хүүхэд (түүний нас, ойлголтоос хамааран) болон эцэг эх нь өөрсдийн үүрэг, хариуцлага, түүнчлэн бусдын үүрэг, хариуцлага болон хүүхдэд зориулсан төлөвлөсөн үр дүн зэргийг тодорхой болгохын тулд төлөвлөгөөний хуулбарыг дуртай хэлээрээ бичгээр авах ёстой. Хүүхдийн хуулбарыг хүүхдийн нас, ойлголтод тохирсон байдлаар бичнэ.

Ахлах нийгмийн ажилтны үүрэг

Ахлах нийгмийн ажилтан нь хүүхдийн хүсэл, мэдрэмжийг тогтмол судалж, хүүхэд хамгааллын төлөвлөгөө болон аливаа өөрчлөлт, өөрчлөлтийн талаар байнга мэдээлж байх ёстой.

Ахлах нийгмийн ажилтан дараах зүйлийг хийх ёстой.

- Хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд зочлох давтамжийг хамтарсан багаар хянуулах;
- Хүүхэдтэй тодорхой давтамжаар ганцаарчлан уулзах;
- Төлөвлөгөөг нас, ойлголтод нь тохируулан хүүхдэд тайлбарлаж, төлөвлөгөөгөө хүүхэдтэй зөвшилцөх;
- Төлөвлөгөөнд тохиролцсоны дагуу хүүхдийн унтлагын өрөөг давтамжтай үзэж харах;
- Хүүхдийн хүсэл, мэдрэмж, эцэг эхийн санаа бодлыг харгалзан хүүхэд хамгааллын төлөвлөгөөний дагуу хүүхэд, гэр бүлтэй шууд хамтран ажиллах;
- Хоёр дахь болон дараагийн хамтарсан багийн хурлыг хуралдуулж, удирдан явуулах (багийн эхний хурлыг менежер удирддаг). Нарийн төвөгтэй хэргийг менежер үргэлжлүүлэн удирдана;
- Хамтарсан багийн гишүүд болон хүүхдийн нийгмийн халамжийн менежерийн уулзалтын тэмдэглэлийг бичгээр гаргаж өгөх;
- Хүүхэд хамгааллын тойм төлөвлөгөөг хамтарсан багийн гишүүдтэй хамтран салбар дундын нарийвчилсан төлөвлөгөө болгон боловсруулсныг баталгаажуулах;
- Санал нийлэхгүй байгаа зүйлийг тодорхой тэмдэглэж, бичгээр тэмдэглэлд оруулах;
- Хамгааллын төлөвлөгөөнөөс хүүхдийн хувийн хэрэгт авагдах гэрээг бичгээр үйлдэж, хамтарсан багийн гишүүдэд хүргэх;

Гэр бүлийн түүхийн талаар бүрэн ойлголттой болох бөгөөд үүнд хүүхдийн нийгмийн халамжийн өмнөх туршлага болон одоогийн бүртгэл, тэр дундаа хүүхдийн одоогийн асран хамгаалагч болон өрхийн бусад хүүхдүүдтэй холбоотой бүртгэлийг унших шаардлагатай.

- Нэмэлт мэдээллийг холбогдох бусад агентлаг, орон нутгийн удирдлагуудаас авах;
- Хамтарсан багийн гишүүд болон холбогдох мэдээллээр бусад агентлагуудаас шимтгэл/мэдээлэл авч, хүүхэд, гэр бүлийн үнэлгээг хийж дуусгах;
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг тогтмол хянахад гэр бүлийн гишүүд болон бүх агентлагийн хувь нэмрийг зохицуулах;
- Хүүхдийн одоогийн хувийн хэрэгт гарын үсэг бүхий тэмдэглэл хөтлөх ёстой.

Хариуцлага

Хамтарсан баг нь хүүхэд хамгааллын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Агентлагууд нь хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгааллын төлөвлөгөөний дагуу үүрэг, хариуцлагаа үр дүнтэй хэрэгжүүлэхийг баталгаажуулах ёстой.

Хамтарсан багийн бүх гишүүд дараах зүйлийг хамтран хариуцна. Үүнд, ахлах нийгмийн ажилтанд нөхцөл байдлын үнэлгээ хийхэд туслах мэдээлэл цуглуулах; нөхцөл байдлын үнэлгээг нэгтгэх, дүн шинжилгээ хийхэд оролцох; хүүхэд хамгааллын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, хэн, хэзээ юу хийх ёстойг тодорхойлох; төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, түүний дотор тодорхойлсон нөөцийг бүрдүүлэх үүрэг хариуцлагыг тусгах; хүүхэд хамгааллын нарийвчилсан төлөвлөгөөнд тусгагдсан үр дүнд хүрэх талаар хүүхдийн ахиц дэвшлийг хянах, үнэлэх; ирээдүйн хамгааллын төлөвлөгөө, хүүхдийн хэрэгцээг хангах талаар тодорхой үр дүнд хүрэхийн тулд дараагийн хяналтын уулзалтад зөвлөмж гаргах; хүүхэд хамгааллын төлөвлөгөөний зорилгод хүрэх чиглэлд ямар нэгэн гажуудал гарахгүй байхын тулд хамтарсан багийн хуралдаанд оролцож, ахиц дэвшилд дүн шинжилгээ хийх; хамтарсан баг нь хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд бүх гишүүдийнхээ хүүхэдтэй уулзах, харилцах давтамжийг тусгасан байх ёстой; хүүхдэд хор хөнөөл учруулах эрсдэлд дүн шинжилгээ хийж, бүх мэдээллийг ахлах нийгмийн ажилтан болон хамтарсан багт хүргэх ёстой.

Мөн хамтарсан багийн бүх гишүүд хурлын үр дүнгийн тэмдэглэл хөтлөх үүрэгтэй. Ахлах нийгмийн ажилтан эсвэл бусад холбогдох мэргэжилтэн хүүхэдтэй шууд холбогдоход хүндрэлтэй байвал Хүүхдийн нийгмийн халамжийн менежер/хүүхэд хамгааллын зөвлөх болон хамтарсан багийн бусад гишүүдэд мэдэгдэх ёстой. Үүний үр дүнд хамтарсан багийн гишүүд болон цагдаагийн байгууллагын хооронд тохиролцсон үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, үүнд хяналтын бага хурлыг хуралдуулах асуудлыг авч үзэх шаардлагатай.

Австрали улс (Өмнөд Австрали)

Өмнөд Австрали Асрамжийн хувилбарт үйлчилгээний стандартыг байнга шинэчилж ирсэн бөгөөд сүүлд 2009 онд дахин сайжруулсан байна. Энэ нь ази номхон далайн бүс нутгийн орнуудын эрх зүйн орчны сайн туршлага болж байна. Уг стандартад кейс буюу асрахуйн үйлчилгээний төлөвлөгөөний талаар хэрхэн зохицуулсныг энд авч үзэж байна.

Стандарт 2.5: Кейс ба асрахуйн үйлчилгээний төлөвлөгөө

Асрамжид хамрагдаж буй хүүхэд бүр түүний аюулгүй байдал, тогтвортой байдал, сайн сайхан байдлыг харгалзан үзсэн цогц нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэсэн кейс төлөвлөгөөтэй байх ёстой. (Тэмдэглэл: кейс болон асрахуйн төлөвлөгөө гэсэн нэр томъёог хооронд нь сольж хэрэглэж болох ч төлөвлөгөөний зорилго, чиг үүрэг нь тухайн ажлын байрнаас шалтгаална)

Хүлээгдэж буй үр дүн

Асран халамжилж буй бүх хүүхэд амьдралын бүхий л салбарыг хамарсан кейс төлөвлөгөөтэй байх болно. Кейс төлөвлөгөө нь «хүүхдэд хамгийн түрүүнд анхаарал хандуулах» зарчмыг баримтлах бөгөөд асрах багийн бүх оролцогчдыг хамарна.

Үүрэг, хариуцлага

Гэр бүлийн байгууллага нь асрах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд бүрд зориулан тэдний асран халамжлагчтай хамтран кейс төлөвлөгөөг боловсруулж, үүнийгээ шинэчлэн боловсруулж байх үүрэгтэй. Асрах багийн бүх гишүүд кейс төлөвлөгөөний тодорхой зорилго/даалгаврыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Практик шалгуур

- 2.5.1 Одоогийн кейс төлөвлөгөө нь хүүхдийн бүртгэлд суурилдаг.
- 2.5.2 Асрахуйн/Кейс төлөвлөгөөг 3-6 сар тутамд шинэчилдэг.
- 2.5.3 Гурван үеийн генограмм нь хүүхдийн бүртгэлд суурилдаг. Генограммд авагдсан төрөл садангийн харилцаа нь хүүхэдтэй ямар холбоотой болохыг илэрхийлдэг. Эсвэл эко зураглалын аргаар хамаатан садан, олон нийтийн дэмжлэгийг харуулахад ашиглаж болно.
- 2.5.4 Кейс төлөвлөлтийг “Тохиолдол ба асрамж үйлчилгээний төлөвлөгөөний загвар”, “Асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах гэрээ”, “Амьдралын талбарын үнэлгээ”, “Боловсролын төлөвлөгөө”, “Сэтгэлзүйн үнэлгээ” зэрэг хэрэглэгдэхүүнүүдийг ашиглан хийж болно.
- 2.5.5 Кейс төлөвлөгөө нь хүүхдэд чиглэсэн тодорхой зорилго, үйл ажиллагаа, хугацаатай байдаг. Асрах багийн бүх гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлдог.
- 2.5.6 Асрахуйн хувилбарт үйлчилгээний иж бүрэн гэрээ нь хүүхдийн хувийн хэрэгт байх бөгөөд гурван сар тутамд шинэчлэгддэг.
- 2.5.7 Асрахуйн/Кейс төлөвлөгөө нь хүүхдийн үзэл бодлыг идэвхтэй судалж, харгалзан үздэг. Ийнхүү харгалзан үзсэн талаар бүртгэж, байнга шинэчилдэг.
- 2.5.8 Асрахуйн/Кейс төлөвлөгөө нь төрсөн гэр бүл, хамаатан садан, асран хамгаалагч болон холбогдох үйлчилгээ үзүүлэгчдийн саналыг идэвхтэй судалж, харгалзан үздэг. Ийнхүү харгалзан үзсэн талаар бүртгэж, байнга шинэчилдэг.
- 2.5.9 Кейс төлөвлөгөөнд кейс ажилтан, ахлагч, хүүхэд, гэр бүл, асран хамгаалагч нар гар үсэг зурна. Кейс төлөвлөгөөг асрах багийн бүх гишүүд хүүхдэд тайлбарлаж өгнө.
- 2.5.10 Төлөвлөх үйл явцад оролцож буй бүх талууд Асрахуйн/Кейс төлөвлөгөөний хуулбар болон нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбаруудыг хүлээн авна.
- 2.5.11 Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд тусламж үйлчилгээний төлөвлөлтийн үр нөлөөг дэмжинэ.



Мэдлэг шалгах асуултууд

1. Нийгмийн ажлын үйлчилгээний төлөвлөлтийн үе шатны онцлог, түүний хүрээнд юу багтах вэ?
2. Хүүхэд хамгааллын болон асрах үйлчилгээний төлөвлөлтийн ялгаа юу вэ?, хүүхдийн асрах хувилбарт үйлчилгээний үед асрахуйн төлөвлөгөө ямар онцлогтой вэ?
3. Нийгмийн ажлын онолын үзэл баримтлалуудаас нэгийг сонгон авч, үйлчилгээний төлөвлөлтөд хэрхэн ашиглах талаар өөрийн саналыг хэлнэ үү?
4. Кейс менежментийн үе шатууд ба кейс төлөвлөлтийн талаар товч тайлбарлана уу?
5. Кейс төлөвлөлтийн үед үйлчлүүлэгчийн болон бусад талуудын оролцоог хэрхэн хангах талаар хэлнэ үү?

ДӨРӨВ

ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1 Үндсэн ойлголт

4.2 Арга зүй, аргачлал

4.3 Практик хэрэглээ, сайн туршлага

4.1

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Энэ хэсэгт асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдэд нийгмийн ажлын, тухайлбал кейс менежментийн интервенц үзүүлэх талаар авч үзэх болно. Өмнөх бүлэгт бид кейс төлөвлөлт буюу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдэд зориулсан асран хамгаалах үйлчилгээний төлөвлөлтийг авч үзсэн билээ. Нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээний үе шатуудаас төлөвлөлтийн дараах үе шат бол үйлчилгээ үзүүлэх буюу интервенц юм. Нийгмийн ажлын ямар салбар, үйлчлүүлэгчийн ямар бүлэгт чиглэсэн, мэргэжлийн үйлчилгээний ямар түвшинд, ямар практик аргад (хувь хүн, бүлэг, байгууллага, олон нийт) суурилж байгаагаас хамаараад интервенцүүд харилцан адилгүй хэрэгжинэ. Тиймээс нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ гэж юу болох, түүний хүрээнд шууд болон шууд бус ямар интервенцүүдийг үзүүлж байгаа зэргийн талаар авч үзэх шаардлага бий болж байна.

Түүнчлэн энэ сэдвийн хүрээнд зөвхөн нийгмийн ажлын (кейс менежментийн) үе шат үйлчилгээний (интервенцийн) талаар хөндөөд зогсохгүй, хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар авч үзэх болно. Хүүхдийн хувилбарт халамж асрамжийн үйлчилгээ нь түүнд хамрагдаж буй хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний талаар авч үзэх болно.

Нийгмийн ажлын интервенцүүд бол үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэхийн тулд мэргэжилтний зүгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэж хэлж болно. Интервенц гэдэг нь мэргэжлийн ном зохиолуудад ховорхон тодорхойлогдсон байдаг (Түмэннаст, 2017). Латины “*intervenire*” буюу ямар нэг зүйлийн дундуур нь орох, тасалдуулах гэсэн утгатай үгнээс гаралтай нэр томъёо юм. Кеннардын тодорхойлсноор “интервенц бол нийгмийн харилцааны цөмд нь байдаг бөгөөд хүний зан үйл болон нийгмийн тогтолцооны үлэмж хэсгийг бүрдүүлдэг зүйл” ажээ. Интервенц бол орчин үеийн нийгмийн зохион байгуулалтын салшгүй бүрдэл хэсэг бөгөөд хувь хүн, байгууллага, институц болон үндэсний түвшинд ялгаа бүхий янз бүрийн хөгжлийн үйл ажиллагааны стратегиуд бий болж байдаг. Өөрөөр хэлбэл, тэдгээр түвшинд байгаа ямарваа нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд гаднаас зорилго бүхий, зохион байгуулалттайгаар хийгдэж байгаа үйл ажиллагаа гэж болно. Интервенц гэдэг нь аль нэг хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийтийн амьдралд бий болсон ямар нэг асуудлыг шийдвэрлэх, түүний үр дагавар даамжрахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөндлөнгөөс нөлөөлөх үйл ажиллагаа юм. Өнөөдөр нийгмийн ажил, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл судлал, асрахуй, эмчилгээ зэрэг хүнтэй ажилладаг мэргэжлүүдийн хувьд хамгийн сайн, нотолгоонд суурилсан, хамгийн үр нөлөөтэй интервенцүүдийг хэрэгжүүлэхээр эрмэлзэж байдаг. Үүн лугаа нийгмийн ажилтнууд үйлчлүүлэгчийн шийдвэрлэхэд ийм интервенцүүдийг боловсруулахын төлөө ажиллана.

Ямар төрлийн интервенц үзүүлэх нь нийгмийн ажилтны зүгээс хийсэн нөхцөл байдлын үнэлгээний үр дүнгээс ихээхэн хамаарна. Нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд тулгуурлан үйлчлүүлэгчтэй ажиллах төлөвлөгөөгөө баталдаг тухай өмнөх бүлэг авч үзсэн билээ. Өөрөөр хэлбэл, төлөвлөлт ёсоор ямар интервенцийг үзүүлэх, ямар үе шатанд ямар үр дүнг хүлээх тухай нийгмийн ажилтан нарийвчилсан дүр зургийг бий болгоно. Нийгмийн ажлын интервенц нь дийлэнхдээ нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө байдаг. (Mark W. Fraser, 2009)

Интервенцүүд хувь хүмүүс, гэр бүл, олон нийт, бүлгүүдэд чиглэж болох бөгөөд өөрийн зорилго аргаас хамааран янз бүрийн хэлбэртэй байж болдог. Юуны өмнө интервенцийг нийгмийн ажлын практикт шууд ба шууд бус хэмээн ангилдаг. Нийгмийн ажлын ном бүтээлүүдээс харж байхад, мэргэжлийн үйл ажиллагааг ийнхүү хоёр ангилж авч үзэх хамгийн гол шалгуур нь мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай байгаа үйлчлүүлэгчтэй [хувь хүн, гэр бүл, жижиг бүлэг, олон нийт] шууд тулж ажиллаж байна уу, эсвэл түүнд туслахын тулд бусад хүмүүс, болон нийгмийн тогтолцоонуудтай ажиллаж байна уу гэдэг асуудал юм.

Хүснэгт 9. Нийгмийн ажлын шууд ба шууд бус интервенци (үйлчилгээ)

Шууд практик
Харилцааны хөгжлийг боломжтой болгож буй үйл ажиллагаа
Орчин дахь хүний талаарх ойлголтыг хөгжүүлэх үйл ажиллагаа
Төлөвлөлтийн үйл явцад хийгдэж буй үйл ажиллагаа
Үйлчлүүлэгч боломжит нөөцөө танин мэдэх болон ашиглах явдлыг боломжтой болгох үйл ажиллагаа
Үйлчлүүлэгчийг чадваржуулах (эрх мэдэлжүүлэх) үйл ажиллагаа
Хямралын нөхцөлд хийгдэж байгаа үйл ажиллагаа
Үйлчлүүлэгчийн нийгмийн үүрэг, үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа
Тусламжийн үндэс болсон үйлчлүүлэгчтэй хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Үйлчлүүлэгч болон түүний орчны тогтолцоонуудыг холбох үйл ажиллагаа
Нийгмийн ажлын клиникийн загварыг хэрэглэх үйл ажиллагаа
Үйлчилгээг уялдан зохицуулахад хамаарах үйл ажиллагаа
Шууд бус практик
Нөлөө бүхий хүчнүүдийг [хувь хүн, бүлэг, байгууллага] хамарсан үйл ажиллагаа
Хөтөлбөр боловсруулах ба төлөвлөх үйл ажиллагаа
Орчныг өөрчлөхөд чиглэж буй үйл ажиллагаа
Байгууллагыг өөрчлөх болон түүнд чиглэсэн үйл ажиллагаа
Учир шалтгаанд нөлөөлөх [cause advocacy] үйл ажиллагаа

Эх сурвалж: Yanco, 2004

Нэг талаас, гэр бүлийн хүчирхийллийн, тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдтэй ажиллах, нөгөө талаас, хүүхдийг гэр бүлээс тусдаа орчинд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулахад нийгмийн ажлын шууд болон шууд бус үйлчилгээг үзүүлнэ. Үйлчлүүлэгч болон түүний орчинтой ажиллана, үйлчлүүлэгчийг нийгмийн тогтолцоонуудтай холбох үйл ажиллагаа явуулна.

Кейс төлөвлөлтийн бүлэгт тодорхойлсончлон хүүхэд хамгааллын үеийн нийгмийн ажлын үйлчилгээ, тухайлбал кейс менежментийн үйлчилгээ буюу интервенц нь төлөвлөлтөд ямар онол үзэл баримтлал, аргазүйн хандлагыг баримталсантай ихээхэн сэжмээр холбогдоно. Өөрөөр хэлбэл, төлөвлөлтийн хүрээнд онол үзэл баримтлал, арга зүй хандлагад агуулагдаж буй практик үзэл санаануудад тулгуурлан интервенцүүдийг боловсруулдаг билээ. Нийгмийн ажлын, тухайлбал кейс менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатанд боломжит интервенцүүдийг эцэслэн тодорхойлох боломжтой. Төлөвлөсөн интервенцүүдийг эргэн нягтлах нь тэдгээрийг ямар үйлчилгээнүүдийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтойг заах юм.

Үүнийг жишээ болгон дараах хүснэгтэд өмнөх бүлгүүдэд авч үзсэн онол үзэл баримтлалуудын хүрээнд боломжит интервенцүүдийг дурдах боломжтой. Эдгээр нь нэг талаас, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, даван туулагч хүүхдийн хувьд, нөгөө талаас, асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдтэй ажиллахад дан болон холимог байдлаар хэрэгжүүлэхэд тохиромжтой интервенцүүд юм.

Хүснэгт 10. Нийгмийн ажлын онолууд дахь боломжит интервенцийн санаа

	Онолын нэр	Боломжит интервенцийн санаа
1	Сэтгэц шинжлэлийн онол	<ul style="list-style-type: none"> - Сэтгэц нийгмийн ажил (нөхцөл байдал дахь хүнийг судалж, оношилгоо хийн эмчилгээний хэлбэрүүдийг тодорхойлох) - Функциональ ганцаарчилсан тусламж нь нийгмийн ажлын агентуудын чиг үүргийг онцлон үзсэн ба үйлчлүүлэгч болон мэргэжилтний харилцааны функцийг чухалчилдаг. Үйлчлүүлэгчийн өөрийгөө тодорхойлох чадвар болон ганцаарчилсан тусламжийг бүтэцжүүлж, үйл явц ба өсөлтийг онцлон үздэг. <p>Асуудал шийдвэрлэх кейс ажил нь үйлчлүүлэгчид тулгарч буй сэтгэц нийгмийн асуудлыг судалж, түүнийг даван туулах чадварыг хөгжүүлэхэд анхаардаг.</p> <p>Асрамжийн байгууллага дахь явуулах үйлчилгээ</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөсөн орчны засал (дасан зохицоогүй болон сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй өсвөр насны хүүхдүүдтэй ажиллах) - Талбарын (Milieu) засал нь орчиндоо зан үйлийн тохируулга муутай залуучуудтай ажиллах психодинамик бүлгийн ажил. - Заслын олон нийт нь асрамжийн газар, өдрийн эмнэлэг, дотуур байр зэрэг олон нийтийн сэтгэцийн эрүүл мэндийн орчинд ашиглагддаг.
2	Экологийн ба тогтолцооны онол	<ul style="list-style-type: none"> - Гэр бүлийн засал (бүтцийн засал-гэр бүлийн харилцааны бүтцийг өөрчлөх, стратегийн засал-өдөр тутмын амьдралд бусад гишүүддээ нөлөөлж, гэр бүлийнхээ адилслыг дэмжих, системтэй засал-гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж буй боломжит далд дүрмүүдийг илрүүлэх) - Асрамжийн газрын тогтолцооны ажил- асрахүйн үйлчилгээний явцад тухайн нөхцөл байдалд хүмүүс бие биетэйгээ хэрхэн харилцах, асрах байгууллага гадаад ертөнцтэй хил хязгаар хэрхэн тогтоох, өөрөө тохируулах тогтолцоо хэрхэн хөгжих, харилцааны ямар хэрэгслүүд ашиглагдах, асуудал хүндрэлийг хэрхэн бууруулах зэрэгт анхаардаг. - Харилцан туслалцах тогтолцоог хөгжүүлэх ажил. - Нийгмийн дэмжлэгийн тогтолцоон дахь сүлжээний ажил.
3	Хямралын онол	<ul style="list-style-type: none"> - Түргэн буюу шуурхай тусламжийн үйлчилгээ (нийгмийн ажлын болон бусад нэн шаардлагатай үйлчилгээ) - Хямралын дараах засал, нөхөн сэргээх, хамгаалах үйлчилгээ
4	Энэгшин дасахуйн онол	<ul style="list-style-type: none"> - Энэгшихүйн бэрхшээлтэй хүүхэд, өсвөр үетэй ажиллах арга (суурь давхар нь найдвартай байдал төрүүлэх, дээд давхар нь асрагч нар тэдэнтэй тоглох, хүлээн зөвшөөрөх, сониуч байх, чин сэтгэлээр хандах, дээвэр нь зан үйлийн менежмент хийх)
5	Давуу талд тулгуурлахуй хандлага	<ul style="list-style-type: none"> - Давуу талд суурилсан интервенц (асрах хувилбарт үйлчилгээнд буй, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд) - Боломж, чадавх, чадварын цогц үнэлгээнд суурилсан нөхөн сэргээх, холбон зуучлах үйлчилгээ
6	Хүчирхэг болгох хандлага (чадваржуулалт)	<ul style="list-style-type: none"> - Хүчирхэг болгох/Чадваржуулах үйлчилгээ - Нөлөөллийн мэдлэг, ур чадвар олгох ажил.

Эх сурвалж: Mary Nash, 2005; Payne, 2014


Ерөнхийдөө, нийгмийн ажилтан-кейс менежер нь тулгуурлан буй онолын үзэл баримтлалуудын хүрээнд үйлчлүүлэгчтэй ажиллахад боломжит интервенцүүдийг нэг бүрчлэн эргэцүүлж, тэдгээрийг нийгмийн ажлын болон хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой төрөл хэлбэр, түвшинд буулгасан байх учиртай.

4.2

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Нийгмийнажлын интервенцийн буюу кейс төлөвлөлтийг хэрэгжүүлэх шатанд мэргэжилтнүүдийн хийж гүйцэтгэх ажлыг хоёр чиглэлээр авч үзэх боломжтой. Нэгдүгээрт, нийгмийн ажилтан кейстэй ажиллаж буй мэргэжилтний хэв хувьд (case worker) өөрийн мэргэжлийн үүргүүдийг хэрэгжүүлэх болно. Энд зөвлөгч, сургагч, захиргааны ажилтан, өөрчлөлтийн агент, холбон зуучлах болон бусад мэргэжлийн үүргүүдийг тоочиж болно. Хоёрдугаарт, кейс менежерийн хувьд илүү тусгай үүргүүдийг гүйцэтгэх болно.

Зураг 11. Кейс менежментийн үе шатууд: Кейс төлөвлөгөө хэрэгжүүлэлт



Эх сурвалж: CPWG, 2014

Хэрэгжилт гэдэг нь кейс төлөвлөгөөгөөр тодорхойлсон үйлчилгээг хүргэх, зохион байгуулах үйл явц юм. Кейс төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд гэр бүлийн нөхцөл байдлын өөрчлөлтөд сонор сэрэмжтэй байхыг шаарддаг бөгөөд энэ нь төлөвлөгөөг байнга эргэн харах шаардлагатай гэсэн үг юм. Ийм нөхцөлд тусламж үйлчилгээний баг болон бусад гол хүмүүстэй зөвлөлдсөний үндсэн дээр кейс менежментийн зорилгыг хянаж үзэх шаардлагатай. Кейс төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад анхаарах гол зүйл бол талууд мэдээлэл солилцох явдал юм. Хэрэгжилт нь хүүхэд, түүний гэр бүл, холбогдох байгууллагуудтай тогтмол харилцах, үйлчилгээ үзүүлэх, зорилгодоо хүрэх, нөхцөл байдлын өөрчлөлтийг харгалзан үзэх үйл явцад тулгуурладаг. Бүх оролцогч талууд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцдаа өөрсдийн болон бусдын үүрэг оролцоог ойлгох хэрэгтэй. Тиймээс байнгын харилцаа холбоо, хамтын ажиллагаа, зохицуулалтаар хэрэгжилт сайжирч, байнгын уулзалт, дүгнэлтээр дэмжигддэг.



Шигтгээ 5. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага: Үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх

4.4 Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат

Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц.

Үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх

Үйлчилгээний төлөвлөгөөний үндсэн дээр нийгмийн ажлын үйлчилгээ хэрэгжүүлнэ.

Үйлчилгээний төлөвлөгөөнд дэлгэрэнгүй дурдагдсан үйлчилгээг хүргэхдээ үйлчлүүлэгч, түүний гэр бүл, нийгмийн орчинтой ажиллана.

Үйлчлүүлэгч, гэр бүлийн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, тогтмол гэрээр очих, гэр бүлийн гишүүдтэй уулзах зэрэг үйлчилгээг үзүүлнэ.

Үйлчлүүлэгчийг мэргэжлийн үйлчилгээ, орон нутгийн дэмжлэгийн эх үүсвэртэй холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.

Холбон зуучлах үйлчилгээ бүрд холбон зуучлах маягт бөглөж энэ талаар кейсийн файлд заавал тэмдэглэж, холбон зуучлалын одоогийн нөхцөлийг тэмдэглэнэ.

Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийг холбон зуучилж болох байгууллагуудын жагсаалтыг гаргаж, холбон зуучлах үйлчилгээний зураглалыг байнга шинэчилнэ.

Эх сурвалж: Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022

Нийгмийн үйлчилгээний байгууллагын кейс менежментийн практикт кейс төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл явц нь өөрөө янз бүрийн интервенцүүдийг багтааж байх ба үүнийг шууд болон шууд бус интервенц хэмээн ангилж болох юм (P. Moxley, 1989). Кейс менежерүүд үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн нийгмийн сүлжээг ч, нийгмийн үйлчилгээ үзүүлэгчдийн гүйцэтгэлийг ч өөрчлөхөд чиглэсэн интервенцүүдэд оролцож байдаг. Шууд интервенц нь кейс менежер гол төлөв үйлчлүүлэгчдийн зүгээс үйлчилгээг үнэлэх, хэрэглэх үр чадвар болон чадавхыг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байх үед хэрэгждэг. Тухайлбал энэ нь 1) үйлчлүүлэгчийг өөрийгөө илэрхийлэх болон харилцааны үр чадварт сургах, 2) үйлчлүүлэгч өөрийгөө өмгөөлөн хамгаалах үр чадварт сургах, 3) хямралын үед тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг байдлаар хэрэгждэг. Нийгмийн үйлчилгээний хүрээн дэх кейс менежментийн үйлчилгээний гол чиг үүрэг нь үйлчлүүлэгч тусламжгүй амьдрах чадварт суралцах бөгөөд энэ үед үйлчлүүлэгчийн өөрийн чиг баримжааг дэмжиж ийм чадвар олж авах хүртэл кейс менежер хэрэгжүүлэгч, сургагч, хамтын ажиллагааг зааварлагч, боловсруулагч, мэдээллийн мэргэжилтэн, дэмжигч гээд олон дүрийг хэрэгжүүлдэг байна.

Харин шууд бус интервенц нь үйлчлүүлэгчийн өмнөөс нийгмийн тогтолцоо, хүмүүсийн зан үйл хийгээд гүйцэтгэлийг өөрчлөх үйл явцад оролцдог. Ийм маягийн интервенцүүд нь 1) үйлчлүүлэгчийг нийгмийн үйлчилгээ үзүүлэгчидтэй холбох, 2) нийгмийн үйлчилгээг холбон зуучлах, 3) үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангахын тулд нийгмийн үйлчилгээнд нөлөөлөх, 4) нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, үзүүлэх зэргийг хамарч байна. Ерөнхийдөө кейс менежментийн тогтолцоо бол үйлчлүүлэгчийн өөрийнх нь үр чадваруудыг хөгжүүлэхийн зэрэгцээ, түүний орчинд дахь тусламж дэмжлэгийн тогтолцоог дэмжиж байдаг билээ.

“Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага”-д үйлчилгээг хүргэх үе шатанд нэг талаас, “үйлчлүүлэгч, түүний гэр бүл, нийгмийн орчинтой нь ажиллана”, нөгөө талаас “үйлчлүүлэгчийг мэргэжлийн үйлчилгээ, орон нутгийн дэмжлэгийн эх үүсвэртэй холбон зуучлах үйлчилгээнд хамруулна” хэмээн тодорхойлсон бөгөөд энэ нь кейс менежментийн үед шууд болон шууд бус интервенц байдлаар хэрэгжинэ. Кейс төлөвлөлтийн бүлэгт авч үзсэнчлэн, кейс менежерүүд үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээнүүдийг уялдуулан зохицуулагч, түүнчлэн үйлчлүүлэгчид хамгийн ойрын мэргэжилтэн буюу зөвлөгч, засалчийн дүрүүдийг хэрэгжүүлдэг. Мөн кейс менежментийн тогтолцоо нь нийгмийн үйлчилгээний байгууллагын хүрээнд зохицуулах, дэмжих, хянах үнэлэх гэсэн гурван үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байна.

Зураг 12. Кейс менежментийн тогтолцооны чиг үүрэг ба менежерийн дүрүүд



Эх сурвалж: P. Moxley, 1989

Кейс менежментийн суурь бөгөөд гол чиг үүрэг болох үйлчилгээ ба дэмжлэгийг уялдуулах зохицуулахын тухайд үйлчилгээний нэгдмэл цогц байдлыг хангах, үйлчилгээ, дэмжлэгийн тасралтгүй байдлыг хангах гэсэн хоёр утга санааг агуулж байдаг. Үйлчилгээний нэгдмэл цогц байдлыг хангах гэдэг нь үйлчлүүлэгчийн асуудал, хэрэгцээг бүрэн шийдвэрлэх боломжтой байхыг илэрхийлж байгаа бол тасралтгүй байдал гэдэг нь үйлчилгээ, дэмжлэгийн уялдаа, залгамж чанар хангагдаж байгаа эсэхийг илэрхийлж байгаа билээ.

Кейс менежментийн дэмжих чиг үүрэг бол үйлчлүүлэгчийг дэмжих, үйлчилгээ үзүүлэгчийг дэмжих гэсэн хоёр чиглэлээр хэрэгжих ба үйлчлүүлэгчийг дэмжих нь түүний сэтгэл зүйн байдлыг эерэг байлгах, итгэл найдвар төрүүлэх, үр дүн өөрчлөлтийн талаар ярилцах, бусад мэргэжилтнүүдэд үйлчлүүлэгчийн санаа бодлыг илэрхийлэхэд туслах гэх мэт үйл ажиллагаануудыг хэлнэ. Харин мэргэжилтнүүдийн үйлчилгээг дэмжих гэдэг нь үйлчлүүлэгчийн талаар мэдээллээр хангах, түүний санал бодол, хүсэлтийг уламжлах, эцсийн үр дүнг мэргэжилтнүүдэд сайтар ойлгуулах зэргээр илэрнэ.

Кейс менежер үйлчилгээний бүхий л явцад үйлчлүүлэгчтэй хамгийн гол бас ойрын мэргэжилтэн байх бөгөөд нийгмийн ажлын мэргэжлийн үүргүүд болох зөвлөгч, засалчийн байр сууринаас асуудалд хандаж, үйлчлүүлэгчид тулгарсан сэтгэлзүй нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, үйлчлүүлэгчийн нийгэм сэтгэлзүйн сайн сайхан байдлыг дэмждэг. Түүнчлэн, үйлчлүүлэгчийн өмнөөс орчны болон тойрон хүрээлж буй тогтолцооны бүхий л талын дэмжлэгийг хөгжүүлж, ашиглаж байдаг.



Шигтгээ 6. Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Дөрөв. Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ

- 4.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хаана үзүүлж байгаагаас үл хамаарч, хүүхэд болон гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх, төгсгөх гэсэн үе шатуудаар хүргэнэ.
- 4.2. Хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй ганцаарчлан ажиллах, гэр бүл болон хүүхдийн бүлэгтэй ажиллах, байгууллага, олон нийттэй ажиллах зэрэг нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйгээр хүргэх, бусад мэргэжилтэн, албан хаагчийн үйлчилгээтэй уялдуулан зохицуулах үүргийг нийгмийн ажилтан-кейс менежер хариуцна.
- 4.4. Энэ журмын 2.7-д заасан Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, эрх бүхий байгууллага нь энэ журмын 4.2-т заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох дүрэм, журмыг баримтална.
- 4.5.1 энэ журмын 4.5-д заасан үйлчилгээг үзүүлэх Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв, асрамж, халамжийн төв, асралт гэр бүл нь холбогдох дүрэм, журам, стандартын дагуу үйлчилгээг үзүүлнэ.
- 4.5.2. Гэр бүлийн орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээ хүргэж буй эрх бүхий байгууллага нь өөрсдөө үзүүлэх боломжгүй хамгаалах, нөхөн сэргээх мэргэжлийн үйлчилгээг энэ журмын 2.7-д заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагад холбон зуучилж, үйлчилгээний явц, үр дүнд хяналт тавина.
- 4.5.3 энэ журмын 3.3-т заасны дагуу хүүхэд, гэр бүлийн кейс хариуцсан нийгмийн ажилтан-кейс менежер нь холбон зуучилсан үйлчилгээг өөрсдийн үзүүлж буй үйлчилгээтэй уялдуулан зохицуулж, хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөөний дагуу кейсийг хааж, төгсгөх хүртэлх үйлчилгээг хүргэж, үйлчилгээний тухай бүхий л мэдээллийг хүүхэд, гэр бүлтэй ажилласан кейс файлд цаасан хэлбэрээр хадгалж, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ

Эх сурвалж: ХНХЯ, 2021. Хүүхэд хамгааллын үйлчилгээний журам

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд урт хугацаанд асрахуйн хувилбарт үйлчилгээнд хамруулснаар кейс ажил эхэлдэг. Кейс төлөвлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд хоёр чиглэлээр зохицуулах ажил хийдэг. Эхнийх нь, нийгмийн бодлогын хүрээнд бий болдог нийгмийн үйлчилгээний сүлжээний орчинд, удаах нь, нийгмийн тусламж дэмжлэгийн сүлжээний орчинд зохицуулалт хийдэг.

Зураг 13. Кейс менежментийн орчин ба шүүд үйлчилгээний дэмжлэгийн хэлбэрүүд



Эдийн засгийн нөхөн сэргээлт

- Эмзэг гэр бүлд зориулсан хөтөлбөр
- Залуусын амьжиргааны боломж



Ус, ариун цэвэр

- Цэвэр ус
- Аюулгүй жорлон
- Ариун цэврийн хэрэглэл



Эрүүл мэнд

- Эрүүл мэндийн үйлчилгээ
- ЖСХ-ийн даван туулагчид эмнэлгийн үйлчилгээ
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд



Байр

- Найдвартай байдал
- Орон гэр
- Дэд бүтэц



Хүүхэд хамгаалал

- Сэтгэлзүйн дэмжлэг
- Эцэг эх байх ур чадвар ба ангилал
- Түр зуурын тусламж/Хувилбарт үйлчилгээ
- Гэр бүл эргэн нэгтгэх үйлчилгээ
- Хүүхдийн шударга ёс



Боловсрол

- Сургуульд хамрагдалт (хичээл/ хичээлийн дараа клуб)
- Сургуулийн өртөг ба зохицуулалт



Хүнс, тэжээл

- Хүнс тэжээлийн дэмжлэг
- Хуваарилалт



ЖСХ

- Даван туулагчид зориулсан үйлчилгээ
- Зөвлөгөө/Засал
- Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг

Эх сурвалж: CPWG, 2014

“Хүүхэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх” журмын 2.7-д “Хүүхэд хамгааллын үйлчилгээг төрийн байгууллага, Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага холбогдох журмын дагуу үзүүлнэ” хэмээн заасан байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчноос нь тусдаа орчинд буюу асрах хувилбарт үйлчилгээнд хамруулан хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх болно.

Кейс ажилтан нь үйлчлүүлэгч хүүхдийн өмнөөс оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, кейс зохицуулалт болон кейс хэлэлцүүлгийг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Кейсийн зохицуулалт (case coordination) харилцаа холбоо, мэдээлэл солилцох, хамтран ажиллах асуудлыг багтаадаг бөгөөд оролцогч байгууллага, агентлагуудын ажилчид хүүхэдтэй байнга ажиллаж, кейсийг удирдан зохицуулах юм. Зохицуулалт нь хохирогч хүүхдэд үйлчилгээг шууд хүртээмжтэй байлгах, түүнийг авахад учирч буй бэрхшээлийг бууруулах, холбоо тогтоох, үйл явцын тэмдэглэлд авагдсан бусад үйл ажиллагааг хамаарна. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээнүүдэд хамруулах нь кейс ажилтны үүрэг билээ.

Харин кейс хэлэлцүүлэг нь (case conference) кейс зохицуулалтаас ялгаатай бөгөөд энэ нь илүү албан ёсны, төлөвлөгдсөн, бүтэцчилэгдсэн үйл ажиллагаа юм. Кейс хэлэлцүүлэг нь ихэвчлэн салбар дундын бөгөөд дотоод гадаад үйлчилгээ үзүүлэгч талуудыг хамарсан боломжтой бол гэр бүл, болон хохирогч хүүхдэд чухал бусад насанд хүрэгчдийг хамран хийгддэг. Кейс ажилтан буюу менежерүүд нь хүүхдийн хэрэгцээ тодорхой цаг хугацаанд, зүй ёсоор хангагдахгүй байгаа нөхцөлд зохион байгуулдаг. Түүнчлэн үйлчлүүлэгч хүүхдийн байр суурь, нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг тодруулах, хүүхдийн амьдралд шаардлагатай үйлчилгээ болон дэмжлэгийг нэг бүрчлэн ярилцах зорилгоор холбогдох хүмүүсийг цуглуулж буй хэрэг мөн. Энэ нь дараах зүйлст чиглэдэг. 1) Зорилгод хүрэх ахиц дэвшил болон бэрхшээл зэргийг эргэн харах, 2) Оролцогч талуудын үүрэг хариуцлагын зураглал хийх, 3) Зөрчлийг шийдвэрлэх, шийдлийн стратеги боловсруулах, 4) Үйлчилгээний төлөвлөгөөг тохируулах зэрэг болно. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамд хамгаалах, нөхөн сэргээх түвшний үйлчилгээг хэрхэн хүргэх талаар тусгайлан тодорхойлж өгсөн билээ. Нийгмийн ажилтан-кейс менежер нь



Шигтгээ 7. Асрамжийн хувилбарт үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын үйлчилгээ

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагад тусгаснаар хувилбарт үйлчилгээний хүрээнд хүүхэд хамгааллын дараах үйлчилгээг үзүүлнэ.

- Хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдлаас урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах цогц үйлчилгээг үзүүлнэ.
- Хүүхэдтэй харилцаа холбоо тогтоож, нөхцөл байдлын үнэлгээ хийн, хувийн хэрэг нээж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээнд суурилан шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, төлөвлөгөөг боловсруулна.
- Хүүхдэд төлөвлөгөөний дагуу бусад мэргэжилтнүүд (эмч, сэтгэлзүйч, багш)-тэй хамтран үйлчилгээ үзүүлнэ.
- Хүүхдэд шаардлагатай тохиолдолд мэргэшсэн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлана.
- Хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ бүрт явцын болон үр дүнгийн үнэлгээ хийж, үйлчилгээг хаах, шаардлагатай тохиолдолд үйлчилгээг үргэлжлүүлнэ.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн удирдлагаар хангагдан, зөвлөгөө, удирдамж авч ажиллана.
- Хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, бусад төрлийн үйлчилгээнд шилжүүлэхдээ хувийн хэргийг архивлаж, хуулбарыг хүлээн авагч байгууллагын хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

Эх сурвалж: С.Тунгалагтамир, Н. Баярмаа, Ж. Шийлэгнүрэв бусад., 2017

мэргэжлийн микро-хувь хүн, гэр бүл, бүлэгтэй ажиллах, мезо-байгууллагын түвшинд үйлчилгээг зохицуулах, макро-олон нийттэй ажиллах, бодлого хөтөлбөрийг сайжруулах, нөлөөллийн ажил хийх зэрэг бүхий л түвшний арга зүйг ашиглан хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх болно. Түүнчлэн, өөрийн зүгээс үзүүлэх нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг бусад байгууллага, мэргэжилтний үйлчилгээтэй уялдуулан зохицуулах хэрэгтэй болно. Гэр бүлийн орчноос тусад нь хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг мэргэжлийн байгууллагад холбон зуучлах замаар хүргэх чухал юм.

Кейс ажилтны зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дараах шууд интервенцүүдийг хүргэх боломжтой. Юуны өмнө, хямралын үеийн интервенцүүдийг дурдах боломжтой. Үүнд, 1) Үйлчлүүлэгч хүүхдэд илэрч буй хямралын шинж тэмдгүүдийг тодорхойлох, 2) Хямралд хөтөлж буй хөнөөлт үйл явдлын гол хүчин зүйлсийг илрүүлэх, 3) Хямралын түвшин, үр дагаврыг тодорхойлох, 4) Заслын шаардлагатай арга хэмжээ, техникүүдийг тодорхойлох, 5) Үйлчлүүлэгчид бий болсон сэтгэлзүйн асуудлуудыг (бухимдал, айдас, түгшүүр) хөнгөвчлөх, 6) Үйлчлүүлэгчийн одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн даван туулах чадварыг хөгжүүлэх, туслах зэрэг юм. Кейс ажилтны зүгээс давын өмнө шуурхай үзүүлэх үйлчилгээ бол хямралын интервенц бөгөөд хүүхдүүд хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэл хэмээх хор хөнөөлт үзэгдлийн үр дагаврыг удаан хугацаанд тэсвэрлэх чадваргүй байж болох тул энэ нь анхдагч бөгөөд шийдвэрлэх тусламж, дэмжлэг билээ.

Мөн дээр онолын хувьд авч үзсэн сэтгэц шинжлэлийн онол ба нийгмийн ажилд хамаарах интервенцүүд чухал байж болно. Сэтгэц нийгмийн шууд оролцооны хувьд жишээлбэл 1) Даван туулагч хүүхдэд хүчирхийллийг ойлгох хийгээд бэлгийн хүчирхийлэл болон түүний дараа бий болох нийтлэг хариу үйлдлийн талаар мэдээлэл, боловсрол олгох зорилгоор ганцаарчилсан уулзалт хийх, 2) Бэлгийн хүчирхийллийн улмаас гэр бүлийн хүрээнд бий болж буй нарийн тодорхой асуудлуудыг (эцэг эх, асран хамгаалагчийн хувьд хүүхдэдээ туслахын тулд нэмэлт мэдээлэл шаардлагатай гм) хэлэлцэх зорилгоор гэр бүлтэй уулзалт хийх, 3) Бэлгийн хүчирхийллийн дараа хүүхдэд бий болж буй бухимдал, түгшүүрийг бууруулах арга замыг хуваалцах, 4) Бусад энэ төрлийн интервенцүүдийг хэрэгжүүлэх болно (Erikson, 2012).

4.3

ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Хүүхэд хамгааллын болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүрээнд кейс төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаар сайн туршлагууд бий болсон байна (LSCP, 2022).

Их Британи улс

Интервенц

Хүүхэд, гэр бүлд шаардлагатай өөрчлөлтөд хүрэх хамгийн сайн боломжийг олгох үйлчилгээ үзүүлэх нь чухал юм. Хэрэв хүүхдийг эцэг эх нь аюулгүйгээр асран халамжилж чадахгүй бол гэр бүлтэй нь ажиллаж байх хооронд хүүхэд өөр газар байрлах шаардлагатай болдог. Хүүхэд хаана амьдарч байгаагаас үл хамааран интервенц нь дараах зүйлийг онцгойлон авч үзэх ёстой. Үүнд хүүхдийн хөгжлийн хэрэгцээ; хүүхэд өөрт нь юу тохиолдсон тухай ойлголт; эцэг эх/хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй харилцаа, хүүхдийн хэрэгцээг хангах эцэг эхийн чадвар; гэр бүлийн

харилцаа; болон гэр бүлийн нийгэм, хүрээлэн буй орчны нөхцөл байдалд гарч болзошгүй өөрчлөлтүүд орно.

Интервенцүүд нь хоорондоо холбоотой хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байж болно. Эдгээр нь хүүхдийг аюулгүй болгох арга хэмжээ; хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа; хүүхдийг хамгаалах, түүний сайн сайхан байдлыг дэмжихэд эцэг эхэд туслах үйл ажиллагаа; хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх эмчилгээ ба засал; болон хүчирхийлэл үйлдэгчтэй ажиллах зэргийг дурдаж болох юм. Ерөнхийдөө хүүхэд, гэр бүлтэй хамтран ажиллаж, эрсдэлийн түвшинг бууруулах чиглэлээр хийсэн хүчин чармайлтыг хууль ёсны аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Хүүхэд хамгааллын төлөвлөгөөг нотлох баримт болгон ашиглаж болно.

Гишүүнчлэл

Хамтарсан багийн гишүүнчлэлийг хүүхэд хамгааллын анхан шатны багийн хурлаар тодорхойлсон байна. Энэ хуралдаанд дараах хүмүүс оролцоно. Үүнд:

Ахлах нийгмийн ажилтан/ нэгдүгээр шатны менежер. Эдгээр мэргэжлийн хүмүүсийн аль нь хамтарсан багийг даргалах/ удирдах нь тухайн хэргийн кейсийн төвөгтэй байдлаас хамаарна;

- Шаардлагатай бол хүүхэд;
- Эцэг эх, гэр бүлийн холбогдох гишүүд;
- Хүүхэд ба / эсвэл эцэг эхтэй холбоотой мэргэжлийн хүмүүс;
- Гэр бүлтэй шууд харьцах асран хамгаалагч эсвэл асрамжийн ажилтнууд.

Хамтарсан баг нь эцэг эх, өргөжсөн гэр бүлийн гишүүд, харилцах, хамтрахад хангалттай нас, мэдлэг ойлголттой болсон хүүхдүүдтэй ажиллах чухал форум юм. Хамтарсан багийн ажилд гэр бүлийн гишүүдийн хооронд ашиг сонирхлын зөрчил гарсан тохиолдолд хүүхдийн эрх ашгийг ямагт тэргүүнд тавих ёстой.

Гэр бүлд чиглэсэн халамжийн хувилбарт үйлчилгээний үйл ажиллагааны туршлага

Манай Гэр Бүл нийгэмлэг ТББ аюулгүй, тайван орчинд хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт нийцүүлж хүүхдийн ур чадварыг хөгжүүлэх, амьдрах ухаанд сургах, нийгэмшүүлэх цогц үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхийг чухалчилдаг. Үүний тулд:

- I. Халамжийн төвд ирж буй хүүхдийн амьдралын түүхийг судлан бүртгэх.
- II. Хүүхэд бүрт кейсийн хавтас нээж он сар өдөр дэс дарааллаар нь хөтөлж нууцлалыг хадгалах
- III. Хүүхдийг нярай үеэс нь эхлэн бие даан амьдрах, гэр бүлд нь нэгтгэхийг зорьдог.

Тус төвд амьдарч буй хүүхэд бүрт хувийг хэрэг нээж, түүнийгэе нарийг нягт нямбай хөтөлдөг. Хүүхдийн хувийн хэрэгт дараах материалыг бүрдүүлдэг. Үүнд:

1. Хүүхдийн талаарх ерөнхий мэдээлэл, цээж зурагтай товч анкет
2. Хүүхдийн өсөлт хөгжлийн бүртгэл
3. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсний бүртгэл
4. Эрүүл мэндийн үзлэгийн тэмдэглэл, эрүүл мэндийн карт
5. Хүүхдэд болон ар гэрийнхэнд нь туслан дэмжиж гаргасан шийдвэрүүд
6. Бичиг баримт /төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн дэвтэр, боловсролын гэрчилгээ, сурагчийн хувийн хэрэг, иргэний үнэмлэх г.м/
7. Төрийн банк, Хөдөлмөр халамжийн газартай хийсэн гэрээ
8. Нийгмийн ажлын эко зураглал, нөхцөл байдлын үнэлгээ, холбон зуучлах үйлчилгээ, хүүхдийн эцэг эх, гэр бүлийнх нь танилцуулга зэрэг багтдаг тухай Дүфрэнэ Готьерын

Сангийн 2020 хэвлэсэн Хүүхдийн эрх, хамгаалал: Практик үйл ажиллагаа номонд дурдсан.

**Мэдлэг шалгах асуултууд**

1. Нийгмийн ажлын интервенц буюу үйлчилгээ үзүүлэх үе шатны онцлогыг хэлнэ үү?
2. Нийгмийн ажлын онолын үзэл баримтлалаас нэгийг сонгон авч үйлчилгээ болон интервенц түүнд хэрхэн суурилах, тухайн онол ямар ямар боломжит интервенцийг санал болгодог талаар дурдана уу?
3. Асрамжийн хувилбарт үйлчилгээний үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээнүүдийг холбогдох эрх зүйн баримт болох нийтлэг шаардлагад хэрхэн тодорхойлсон бэ?
4. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүрээнд кейс менежерийн үзүүлэх шууд болон шууд бус интервенцүүд юу юу байж болох вэ?
5. Кейс менежмент үйлчилгээний үед үйлчлүүлэгчид, ялангуяа хүчирхийлэлд өртсөн хүүхдэд ямар дэмжлэг, туслалцааг үзүүлж болохыг хэлнэ үү?

ТАВ

ХАЛАМЖИЙН ХУВИЛБАРТ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ БУЙ ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ НЬ

5.1 Үндсэн ойлголт

5.2 Арга зүй, аргачлал

5.3 Практик хэрэглээ, сайн туршлага

5.1

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Энэ сэдвийн хүрээнд юуны өмнө, нийгмийн ажлын үйлчилгээний үндсэн үе шат болсон үйлчилгээг үнэлэх талаар авч үзэх болно. Энэ нь нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлсний дараа үйлчлүүлэгчид бий болсон өөрчлөлтүүдийг дүгнэн цэгнэх үйл ажиллагаа юм. Түүнчлэн, үйлчилгээний явцад тасралтгүй үнэлэх цэгнэх ажил хийгдэх бөгөөд мэргэжилтэн нөхцөл байдлыг хяналтдаа байлгах, үйлчилгээ болон интервенцийг залж сайжруулах, хүсээгүй үр дагавар, эрсдэлийг бууруулах боломжийг олгоно.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь нийгмийн ажлын бие даасан салбар болон хөгжсөний хувьд энэ салбар дахь хяналт шинжилгээ, үнэлгээ нь онцлог бүхий хүрээ, шалгуур үзүүлэлт, мэдээлэл цуглуулах, шинжлэх арга зүй, тайлагнах үйл явц гэх мэт өөрийн гэсэн тогтолцоог хөгжүүлсэн юм. Түүнчлэн, хяналт шинжилгээ, үнэлгээ нь хүүхэд хамгааллын кейс менежментийн салшгүй бүрдэл хэсэг билээ.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлээс тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний хувьд үйлчилгээг хянах, үнэлэх ажил маш чухал юм. Кейс төлөвлөлт хэрхэн хэрэгжиж байна, тавьсан зорилго хэр биелэгдэж байна, хүссэн үр дүн бий болж буй эсэх гэх мэт асуултуудад хариулах ба энэ нь кейстэй ажиллах эхний үе шат буюу нөхцөл байдлын үнэлгээнээс ахиц дэвшил, үр нөлөөг цаашид хэрхэн хянаж, үнэлж цэгнэх талаар ажилтан болон үйлчлүүлэгч талууд зөвшилцдөг.

Нийгмийн ажилтан үйлчилгээ үзүүлсний дараа түүний хүрээнд тавьсан зорилго, зорилтуудыг шийдвэрлэж чадсан эсэхийг эргэн харах зайлшгүй шаардлагатай. 1973 онд Фишер “Нийгмийн ажил үр нөлөөтэй байна уу?” гэсэн асуултаар мэргэжлийн хариуцлагын асуудлыг дэвшүүлсэн бөгөөд улмаар судлаачид, практик ажилтнууд болон бодлого боловсруулагчдын дунд хэлэлцүүлэг өрнөх болжээ. 1986 онд Америкийн “Нийгмийн ажлын боловсролын зөвлөл”-өөс мэргэжилтнүүдэд тавих шинэ магадлан итгэмжлэх шаардлагад “бүх нийгмийн ажилтнууд өөрийн үнэлгээ хийх чадвартай байх ёстой” гэсэн зүйлийг нэмсэн бол 1980 онд Америкийн профессор Брайр [Scott Briar] зөвхөн клиник нийгмийн салбар төдийгүй макро практикт ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд ч өөрийн үйлчилгээг үнэлэх хэрэгтэй хэмээсэн байна. Тэрээр нийгмийн ажилтан бол “практик ажилтан ба судлаач” байх ёстой гээд энэ мэргэжилтнүүд ажлын байран дээрээ үнэлгээ судалгааны зорилгоор дараах зүйлсийг хэрэгжүүлдэг байхыг заасан байна (Evens, 1990). Үүнд:

- Хамгийн үр дүнтэй нь мэдэгдсэн аргууд болон техникүүдийг хэрэглэх;
- Өөрийн практик үйл ажиллагааг тогтвортой бөгөөд нарийн нягт үнэлэх;
- Мэдээллийг шалгах, тайлан боловсруулахдаа дээрх аргуудын үр дүнтэй талуудыг ашиглах;
- Найдвартай биш, туршигдаагүй арга хэрэгслүүдийг зөвхөн маш сайн хяналтан доор хэрэглэх, түүнчлэн үйлчлүүлэгчийн эрхийг зөрчихгүй байхад анхаарах;

Үнэлгээ судалгааны үр дүнг бусдад хуваалцах зэрэг багтана.

Нийгмийн ажилтан үзүүлсэн үйлчилгээнийхээ үр нөлөөний талаар эргэж тайлагнах [accountability] үүрэгтэй. Нийгмийн ажилтан өөрийн ажил үйлчилгээгээ хэнд ямар учраас тайлагнах ёстой вэ? гэсэн асуулт дэвшүүлж болох юм. Юуны өмнө, энэ мэргэжлийг эрхэлж буй хүмүүс үйлчлүүлэгчийн өмнө тайлагнах ёстой. Хоёрдугаарт, нийгмийн ажилтан мэргэжлийнхээ өмнө тайлагнах ёстой билээ. Гуравдугаарт, нийгмийн ажилтан өөрийн үйлчилгээг ажиллаж буй байгууллагынхаа өмнө тайлагнах ёстой болно.

Хүснэгт 11. Хяналт- шинжилгээ ба үнэлгээ

Хяналт-шинжилгээ	Үнэлгээ
<ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний зорилго, зорилтыг нягтлах • Үйл ажиллагаа болон тэдгээрийн нөөцийг зорилготой уялдуулах • Зорилгуудыг шалгуур үзүүлэлтээр илэрхийлэх, зорилтот түвшинг тодорхойлох • Эдгээр үзүүлэлтийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулах, хүрсэн үр дүнг зорилтот түвшинтэй харьцуулах • Удирдлагад явцын талаар мэдээлж, хүндрэлийн талаар анхааруулах 	<ul style="list-style-type: none"> • Хүлээгдэж байсан үр дүнд хүрэв үү, хүрч чадаагүй бол яагаад гэдэгт дүн шинжилгээ хийх • Хүлээж байснаас гадуур эерэг болон сөрөг үр дагаврууд бий болсон эсэх • Хэрэгжилтийн үйл явцыг бүхэлд нь хянаж, нягтлах • Үйлчилгээ, арга хэмжээнүүд уялдаа холбоотой, цогц байж чадсан эсэх • Үйлчлүүлэгчийн амьдралын чанар, сайн сайхан байдалд урт хугацаанд тогтвортой байх эсэх


Эх сурвалж: Жоди Золл Кусек, 2004

5.2

АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Кейс менежер нь үйлчлүүлэгчийн буюу кейс төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийхэд оролцдог (P. Moxley, 1989). Тэдгээр нь 1) үйлчлүүлэгчийн байр суурь, 2) төлөвлөсөн нийгмийн үйлчилгээний хэрэгжилт, 3) нийгмийн сүлжээний гишүүдийн хамрагдалт гэсэн чиглэлээр хяналт-шинжилгээний ажил явуулдаг. Хяналт-шинжилгээний ажлаар дамжуулан кейс менежерүүд үйлчлүүлэгчийн буюу кейс үйлчилгээний төлөвлөгөөний аль хэсэг хэрхэн амжилттай хэрэгжив, аль хэсэг нь бүтэлгүйтсэн талаар нарийвчилсан дүгнэлт гаргах учиртай. Түүнчлэн, кейс менежерүүд үйлчлүүлэгчийн төлөөх кейс төлөвлөгөөний хүрээнд үзүүлсэн үйлчилгээний үр нөлөөг үнэлдэг. Тэд тоон болон чанарын арга зүйг ашиглан хэрэгжилт бүхэлдээ ямар байсан, үйлчлүүлэгч ямар үр шим хүртсэн талаар судалж, тайлагнадаг. Үнэлгээний хамгийн гол асуулт нь кейс төлөвлөгөө үр дүнтэй байж чадсан эсэх юм. Цаашилбал үнэлгээний асуултууд нь 1) Нийгмийн сүлжээний гишүүд нь үйлчлүүлэгчийн нийгмийн дэмжлэгийн тогтолцоо, түүний чадавхыг хэр зэрэг хөгжүүлсэн, 2) нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид нь ийм маягийн үйлчлүүлэгчтэй ажиллах чадавхаа хэр зэрэг сайжруулсан зэрэг байж болно.

Зураг 14. Кейс менежментийн үе шатууд: Хяналт, үнэлгээ



Кейс менежментийн хяналт шинжилгээ нь үйлчлүүлэгчтэй ажиллахдаа дэвшүүлсэн зорилго, зорилт хэрхэн шийдвэрлэгдэж буйг эргэн нягтлах байнгын үйл ажиллагаа юм (Erikson, 2012). Кейс ажилтан нь бүр анхнаас нөхцөл байдлын үнэлгээ болон кейс төлөвлөлтийн явцаас хүүхэд болон асран хамгаалагчтай кейсийн явцыг хянах хугацаа, механизмыг тохиролцсон байх ёстой. Хяналт шинжилгээ хийх уулзалт бүрийг хүүхдийн тав тухыг хангасан, тэдний нууцлалыг хамгаалах боломжтой газарт хийнэ. Ийнхүү кейс ажлын явцад дараа дараагийн уулзалт бүрийн цаг хугацаа, огноо, байршил нь хүүхдийн хувь хүний хэрэгцээнд суурилсан байх ёстой. Кейс мониторингийн гол зорилго нь үйлчлүүлэгч хүүхэд шаардлагатай үйлчилгээг хүлээн авсан эсэх, хүүхдийн нөхцөл байдал сайжирч байгаа эсэхийг эргэн нягтлах явдал юм. Үйлчлүүлэгч хүүхэд болон кейс ажилтан эхний уулзалтаас хойш авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар хэлэлцэж, хүүхдийн урт хугацааны хэрэгцээ, асрамж халамжийн талаар ярилцана. Түүнчлэн, кейс ажилтнууд хүүхдийн одоогийн аюулгүй байдлын байдлыг дахин үнэлэх боломжтой. Кейс ажилтан шаардлагатай бол хууль ёсны хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг дахин дахин авч үзэж болно.

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага ёсоор мэргэжилтэн үйлчилгээг үнэлэхдээ үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж болон мэргэжлийн удирдлага, хамтран ажилладаг мэргэжилтнүүдийн санал бодлыг тодорхойлох замаар үнэлэх талаар тусгасан байна.

Кейс менежер нь үйлчилгээ, арга хэмжээний хэрэгжилт хэр үр дүнтэй байсныг тодорхойлох зорилго тавьж, дүн шинжилгээ хийнэ. Юуны өмнө хяналт-шинжилгээ хийхэд анхаарах бөгөөд кейс менежер үүнд мэдээлэл өгч чадах хүмүүстэй холбогдож үйлчилгээ, хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулж, үйлчлүүлэгчид тулгарсан асуудал, хэрэгцээ хэрхэн шийдвэрлэгдэж буй, нөхцөл байдал ямар байгаа эсэхийг шалгана. Кейс менежер нь үйлчлүүлэгчтэй амьдарч буй газар нь (асрамжийн газар, асралт гэр бүл, төрөл садан гм) зочилж, эсвэл нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлдэг газар хяналт хийх уулзалтаа зохион байгуулж болно. Үйл ажиллагааны төлөвлөгөөг ямар хэмжээгээр өөрчлөх шаардлагатайг кейс менежер тодорхойлж болно. Хэрэв тийм шаардлага үүсвэл төлөвлөлтийн үе шат руугаа буцан эргэн нягтлах хэрэгтэй. Хэрэв үйлчилгээний шинэ арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бол кейс менежер энэхүү шинэ стратеги нь асуудлыг шийдсэн эсэхийг шалгахын тулд нэмэлт хяналт хийх болно. Кейс менежментийн сүүлийн үе шат бол үйлчилгээний үйл явцын талаарх санал хүсэлтийг цуглуулж, үйлчилгээний гол шалгууруудын дагуу дүн шинжилгээ хийх явдал юм.

Харин үнэлгээ нь үйлчлүүлэгч, ажилтнууд, оролцогч талуудад кейс менежментийн тогтолцоо ба үйлчилгээний талаар санал бодлоо илэрхийлэх боломж юм. Кейс менежер нь эцсийн

дүнд бүхий л үйлчилгээ, үйл явцын үр нөлөөний талаар дүн шинжилгээ хийх болно. Үнэлгээ нь эргээд дараа дараагийн кейс менежментийн үйл явц, алхмуудыг сайжруулдаг. Ийнхүү аль нэг хүүхдийн кейс төлөвлөгөөний үр дүнг үнэлэх нь ирээдүйн кейс ажлуудын үр дүнг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулна. Хэрэв шинэ кейс нь өмнөхтэй төстэй байвал кейс менежер амжилтгүй болсон стратегиудыг хэрэгжүүлэхээс зайлсхийж, үр дүнтэй аргууд дээр анхаарлаа төвлөрүүлж болно.

Хүүхэд хамгааллын кейс менежментийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд ямар эх сурвалжууд чухал байх талаар авч үзэх нь чухал юм. Нийгмийн ажлын үйлчилгээний бүхий л үе шатанд мэргэжилтний зүгээс үйл явцыг тэмдэглэх асуудал онцгой чухал зүйл бөгөөд энэ нь кейс ажлын хяналт, үнэлгээнд чухал эх сурвалж юм. Анхны уулзалтаас эхлээд хийгдэх ёстой энэ зүйл нь мэдээж хэрэг нийгмийн ажлын практикийн үндсэн үе шатуудад, тухайлбал нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөх, интервенц, үнэлгээ хийх зэрэгт аль алинд маш чухал хэрэгцээтэй зүйл юм. Нийгмийн ажилтны тэмдэглэл нь болж өнгөрсөн харилцан үйлдэл, нийгмийн ажилтан болон үйлчлүүлэгчийн харилцан яриа, мэргэжилтний мэдрэмж, төсөөлөл, эргэцүүлэл, тайлбарлалыг багтаадаг. Нийгмийн ажлын үнэлгээнд маш чухал техникийн нэг нь мэргэжилтний энэхүү тэмдэглэлийг гэж үздэг. Мэргэжилтний хийх тэмдэглэлийг зорилго, арга маягаар нь үйл явцын тэмдэглэл, дуу хураагуур болон дүрс бичлэгийн тэмдэглэл, хураангуй тэмдэглэл, асуудалд чиглэсэн тэмдэглэл гэх зэргээр ялгаж авч үздэг. (Yanca, 2004) Дуу болон дүрс бичлэг хийх [taping] нь нийгмийн ажлын практикт өргөн хэрэглэгддэг техник мөн. Энэ нь нийгмийн ажилтан өөрийн үйлчлүүлэгчтэй хийж буй харилцан үйлдэл, өөрийн ажил үйлчилгээний талаар эргэн харах боломжийг олгодог. Түүнчлэн, үйлчлүүлэгчийн хувьд ч зан үйл болон харилцан үйлдлийн байдлаа үнэлж цэгнэх утгаар юу болж өнгөрснийг харах боломжтой болдог. Дуу болон дүрс бичлэг нь мэргэжлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэхээс гадна, үнэлгээний хамгийн чухал эх сурвалж болдог.

Үүнийг хэрэглэхдээ нийгмийн ажилтан ёсзүйн асуудлыг анхаарах хэрэгтэй болдог.



Шигтгээ 8. Нийгмийн ажлын үйлчилгээн тавигдах нийтлэг шаардлага: Үйлчилгээг үнэлэх

4.4 Нийгмийн ажлын үйлчилгээний үе шат
Нийгмийн ажилтны үйлчлүүлэгчтэй (хувь хүн, гэр бүл, бүлэг, олон нийттэй) ажиллах үйл ажиллагааны чиглэл, арга зүйг тодорхойлж, харилцаа холбоо тогтоох, нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээг төлөвлөх, үйлчилгээг хүргэх, үйлчилгээг үнэлэх, хаах үе шат бүхий үйл явц.

6.3.3.4 Үйлчилгээг үнэлэх

Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид хүргэсэн үйлчилгээг явцын, эцсийн үнэлгээгээр үнэлсэн байна.

Нийгмийн ажилтан үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтууд биелэгдсэн байдал, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг үнэлнэ.

Үйлчилгээг үнэлэхэд үйлчлүүлэгч, түүний гэр бүлийг оролцуулна.

Нийгмийн ажилтан нь үзүүлж буй үйлчилгээнийхээ талаар үйлчлүүлэгчийн санал бодол, үнэлгээг авч цаашдын үйлчилгээ, үйл ажиллагаандаа тусгана.

Нийгмийн ажилтан нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах, ахлах нийгмийн ажилтан-мэргэжлийн удирдагч болон хамтран ажилладаг мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсох замаар өөрийн үйлчилгээний үйл явц, үр дүн, үр нөлөөг үнэлнэ.

Нийгмийн ажилтан нь үйлчилгээнийхээ үйл явц, үр дүн, үр нөлөөнд хийсэн үнэлгээг өөрийн болон байгууллагын үйлчилгээг сайжруулахад ашиглана.

Эх сурвалж: Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа, 2022.



Шигтгээ 9. Хяналт шинжилгээ, үнэлгээ

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам**Хяналт шинжилгээ, үнэлгээ**

7.1. Энэ журмын 2.7-д заасан Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага нь улирал, хагас, бүтэн жилийн хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлангаа харьяа дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, сумын мэргэжилтэнд өгч, сумын мэргэжилтэн, дүүргийн хэлтэс нь аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад харьяа орон нутгийн анхан шатны тайланг нэгтгэн хүргүүлж, дээд шатны байгууллагаас үнэлгээ, дүгнэлт, зөвлөгөө, чиглэл авна.

7.2. Хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын үйлчилгээнд харьяа хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгнө.

7.3. Байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс, нэгж, мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн чиглэлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан биелүүлэх, тайлагнах үүрэгтэй.

7.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын үйлчилгээний үр дүнг үнэлэх, сайжруулах зорилгоор энэ журмын 2.7-д заасан байгууллагын үйл ажиллагаанд батлагдсан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ

Эх сурвалж: ХНХЯ, 2021. Хүүхэд хамгааллын үйлчилгээний журам

Хураангуй тэмдэглэл [summary record] нийгмийн үйлчилгээний тодорхой үе шатуудад хийгддэг бөгөөд байгууллагыг чухал мэдээллээр хангах зорилго бүхий тэмдэглэл юм. Нийгмийн ажилтны зүгээс хийж бүхий л үйлчилгээний талаар товч бөгөөд энгийн байдлаар бичигдэх ба ингэхдээ нийгмийн ажилтны ажил үйлчилгээ, гүйцэтгэл гэхээс илүүтэй тухайн үйлчлүүлэгчийн хувьд юу болоод өнгөрөв гэдэгт чиглэдэг. Орчин үеийн практикт хэрэглэгдэх болсон тэмдэглэлийн хэлбэр бол асуудалд баримжаалсан тэмдэглэл [problem-oriented record] юм. Энэ нь нийгмийн үйлчилгээний ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээний салбарт ихээхэн хэрэглэгдэх болсон тул зөвхөн нийгмийн ажлын хэрэглээнд байдаг зүйл биш юм. Салбар дундын шинжтэй хэрэглээнд байдгаараа давуу талтай ажээ. Асуудалд баримжаалсан тэмдэглэл дөрвөн үндсэн хэсгээс бүрдэх, нэгдүгээрт, үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл, хоёрдугаарт, үйлчлүүлэгчийн асуудлын талаарх мэргэжилтний анхны санал мэдүүлэг, гуравдугаарт, зорилго, зорилтууд, эцэст нь, ямар ажил үйлчилгээг үзүүлсэн талаарх мэдээлэл зэргээс бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын кейс менежментийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийгмийн судалгааны тодорхой аргуудыг хэрэглэх

бөгөөд тоон болон чанарын аргуудыг ямар хэлбэрийн үнэлгээг, хэн хийж байгаагаас хамааран сонгон ашигладаг байна. Нийгмийн ажлын үнэлгээнд судлах зүйлсийн олон талт байдлаас хамаараад мэдээлэл цуглуулах хэд хэдэн аргуудыг түгээмэл хэрэглэдэг байна. (Yanca, 2004) Хамгийн нийтлэг хэрэглэдэг арга бол ярилцлагын арга [interview], тэр дундаа бүтэцчилэгдсэн ярилцлагын арга юм.

Нийгмийн ажлын практикт хоёр төрлийн ярилцлагын арга байх ба эхнийх нь интервенцийн зорилгоор ярилцлага хийх [interventive interview], удаах нь, үнэлгээний зорилгоор ярилцлага хийх [evaluative interview] болно. Мэдээж сүүлийн ярилцлагын хэлбэрээр нийгмийн ажлын үйлчилгээний үнэлгээнд хэрэгцээтэй мэдээллийг олж авдаг. Үнэлгээнд ярилцлагын бүтэц, ярилцагчийн зүгээс асуух асуултууд, дэс дарааллыг тогтоож өгсөн байдаг. Ярилцлагын арга нь ярилцагчаас тодорхой үр чадваруудыг шаарддаг. Нийгмийн ажлын үйлчилгээний үнэлгээнд хэрэглэгдэх бас нэгэн чухал арга бол асуулгын арга [questionnaire] болно. Энэ нь ихэвчлэн, үйлчилгээ авсан хүмүүсийн төлөөллөөс тэдгээрийн сэтгэл ханамж, үйлчилгээнд өгөх үнэлгээ ямар байгааг тодорхойлоход чиглэдэг. Маш энгийн бөгөөд хаалттай асуултуудаас бүрдсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн болон үнэлгээний анкет гол хэрэглэгдэхүүн болдог. Энэхүү

аргын үед үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон үнэлгээг чухам ямар шалгуур үзүүлэлтээр тодорхойлох, тэдгээрийг хэрхэн хэмжих хэмжилтийг сонгох асуудал үлэмж чухал байх болно. Улс орнуудын туршлагад нийгмийн ажлын үйлчилгээний сэтгэл ханамжийг үнэлгээний маш сайнаас маш хангалтгүй хүртэлх хэмжилтүүдээр тодорхойлж байх нь нийтлэг юм. Нийгмийн ажлын үнэлгээнд шаардлагатай мэдээллийг цуглуулах дараагийн арга бол ажиглалт [observation] болно. Ажиглалтын аргын давуу талууд болох үнэлэх гэж буй зүйлсийг бодит байдал дээр хэрхэн оршиж байсан болон байгааг шууд харах боломжийг олгох төдийгүй, үнэлэгч өөрийн нүдээр олж харсан зүйлсийг өөрөө шууд тэмдэглэн буулгах нөхцөл бүрддэг. Тиймээс ажиглалт нийгмийн ажлын үнэлгээний үндсэн аргуудын нэг байсаар байх болно. Нийгмийн ажилтнууд болон бусад үнэлгээчид талбарт өөрсдийн биеэр зочлон, нийгмийн ажлын практик амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа талаар ажиглаад зогсохгүй, түлхүүр мэдээлэгчидтэй уулзан бүх талын мэдээллийг авах боломжтой.

Кейс менежментийн үйлчилгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нийгмийн ажилтан өөрөө хийж байгаа мэргэжилтний өөрийн үнэлгээ болох ба тухайн ажилтны байгууллагаас хийж буй бол дотоодын хяналт, үнэлгээ болно. Түүнчлэн, нийгмийн ажлын эсвэл хүүхэд хамгааллын хөндлөнгийн байгууллага, шинжээчдээс хийж буй гаднын үнэлгээ байж болно. Хүүхэд хамгааллын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх зохицуулалтыг тухайн улсын хүүхэд хамгааллын хууль тогтоомж, холбогдох дүрэм журмуудад зохицуулсан байдаг.

5.3

ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ, САЙН ТУРШЛАГА

Энд хүүхэд асрах үйлчилгээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хүрээнд зарим улс орны туршлагыг хүргэж байна (ISS, 2012).

Израиль улс

Хүүхдэд зориулсан асрамжийн үйлчилгээний чанарын баталгааг хангах RAF (Зохицуулалт, үнэлгээ, хяналт) санаачилгыг Нийгмийн харилцааны яамнаас хэрэгжүүлсэн байна. Энэ нь тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах гол зорилготой байна. Энэ нь дотоод чанарын баталгаажуулалтын аргатай хөндлөнгийн хяналтын элементийг хослуулдаг. Тухайн байгууллага нь тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зохицуулалт, хяналт шалгалтын хувьд объектив, системтэй, нэгдмэл аргыг ашигладаг. Тэнд амьдарч буй хүүхдүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор 6-18 насны 5000 залуучуудад үйлчилдэг 85 асрах байгууллагын орчинд хэрэгжүүлсэн. RAF нь «мөшгих» (tracer) аргыг ашигладаг бөгөөд энэ аргийн хүрээнд нарийн тодорхойлсон асуудал, нөхцөл байдлын хэмжүүр нь тухайн асрамжийн орчинд амьдарч буй хүүхдүүдийн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэхэд чиглэдэг. Сургуулийн доогуур амжилт, түрэмгийлэл, сэтгэл гутрал, түгшүүр зэрэг хувь хүний сэтгэлзүйн асуудлаас гадна байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хянахад зориулагдсан цогц индексүүд байдаг. Эдгээр индексүүд нь ерөнхий шинж чанартай байдаг ба жишээлбэл, аюулгүй байдал, боловсон хүчин, хоол тэжээл зэрэг орно. Үнэлгээний хүмүүс мэдээллийг хувийн болон байгууллагын түвшинд цуглуулдаг бөгөөд үйлчлүүлэгчийг мэдээллийн гол эх сурвалж болгон ашиглахыг чухалчилдаг. Ингэхдээ ажилтнуудын ярилцлага, баримт бичиг, ажиглалт зэрэг аргыг хэрэглэдэг. Хяналтын үйл явц нь үндсэн үе шатуудтай. RAF-аас авсан мэдээлэл нь хүүхэд бүрийн асаргаа, үйлчилгээний бүтэц зохион байгуулалт, төлөвлөгөөний үндэс болдог бөгөөд үр дүнд нь тусламж үйлчилгээний

чанар, хүүхдийн сайн сайхан байдал сайжирч байгааг нотолж байна. Түүнээс гадна RAF-ийн үр нөлөөнд ажлын журам, шийдвэр гаргах үйл явц, боловсон хүчний ур чадвар сайжирч байгааг харуулсан байна⁴.

Мексик улс

Мексик улс асрамжийн хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдийн сайн сайхан байдал, хамгааллын үйлчилгээг сайжруулах үүднээс Хүүхдийн асаргаанд хяналт тавих хөтөлбөр хэрэгжүүлжээ. Мехико хот дахь хувийн асрамжийн газраас хэд хэдэн хүүхэд алга болсон явдал нь шийдвэр гаргагчдын бодол санаанд гол нөлөө үзүүлсэн байна. Орон нутгийн Хүний эрхийн комиссоос асрамжийн хувилбарт үйлчилгээнд байгаа хүүхдүүдийн нөхцөл байдалд хяналт тавих асуудлыг эрх баригчид илүү анхаарал хандуулах, зохион байгуулах, түүнчлэн хувилбарт тусламж үйлчилгээний бүртгэл, хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгохыг уриалсан зөвлөмж гаргасан юм. Үүний үр дүнд Мехико хотын орон нутгийн засаг захиргаа хөтөлбөр боловсруулжээ. Хүүхэд хамгааллын асуудалд бүх оролцогч талуудыг төвийн болон орон нутгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг үүрэг хариуцлага бүхий л байгууллагуудыг хүүхэд хамгааллын тэр дундаа асрамжийн үйлчилгээнд хяналт тавихад татан оролцуулсан. Энэхүү санаачилга нь хүүхдийн асрах үйлчилгээ үзүүлж буй байгууллага, хүмүүсийн үйл ажиллагаа нь шаардлагатай стандартуудыг мөрдөж, тэдгээрийн үйл ажиллагаанд гарсан аливаа зөрчлийг тодорхойлж, эдгээр газар үзүүлж буй тусламж үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүргэн явуулж байгаа эсэхийг шалгах зорилготой юм. Өнөөдрийг хүртэл хөтөлбөр нь тусламж үйлчилгээний бүхий л үйл явцыг хянаж үнэлж байгаа бөгөөд үр дүнд нь хүүхэд асрах үйлчилгээ бүх талаар сайжирсан байна. Энэхүү хяналт үнэлгээний тогтолцооны мэдээллийг ашиглан хувилбарт асрамжийн тусламж үйлчилгээний хүрээнд хийх боломжит сайжруулалтыг санал болгож, хүүхдийн асрамжийн газарт хяналт тавих механизмыг хууль эрх зүйн хувьд хүлээн зөвшөөрч, тогтвортой байлгах хууль тогтоомжийг боловсруулахаар төлөвлөж байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангийн техникийн туслалцаатайгаар мэргэжлийн багаж хэрэгсэл, техникийн стандартуудыг боловсруулж байна⁵.

Колумб улс

Орон нутгийн «Kidsave Colombia» ТББ-аас Колумбын засгийн газартай хамтран боловсруулсан Гайхамшигт учрал хэмээх төсөл нь шаардлагатай тохиолдолд хүүхэд, залуучуудад асралт гэр бүлд амьдрах боломжийг олгох зорилготой юм. Уг хөтөлбөрийг 2006 оноос хойш 27 сарын хугацаанд боловсруулсан бөгөөд 2008 оноос хүүхдүүдийг хамруулж эхэлсэн. Төрсөн эцэг эхтэйгээ хамт амьдардаг ч хүүхдүүд хүчирхийлэл, хайхрамжгүй байдал, хайр халамж дутмаг орчинд байсан бөгөөд олон хүүхэд, өсвөр үеийнхэн донтох асуудалтай байсан. Ерөнхийдөө хүүхэд залуучуудын дийлэнх нь амьдралынхаа гуравны нэгийг асрамжийн тогтолцоонд өнгөрөөсөн байна. Төсөл нь 1) сургалт, чадавхыг бэхжүүлэх; 2) харилцан үйлчлэл, харилцааг сайжруулахад хүүхэд болон асран хамгаалагч гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх; 3) хүүхдүүдийн талаар улс төрийн удирдагчид болон шийдвэр гаргагчдын хандлагад нөлөөлөх мэдлэгийг дээшлүүлэх. гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байв. Хүүхэд асрах үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахын тулд хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог нэвтрүүлсэн байна. Ийнхүү хөндлөнгийн үнэлгээ нь үйлчилгээний байнгын сайжруулалтыг хийх боломжийг олгож иржээ. Хөндлөнгийн үнэлгээний дүнгээр хүүхэд, залууст нийгмийн ур чадвар төлөвшиж, нийгмийн сүлжээгээ хөгжүүлэхэд нь хувь нэмэр оруулсан нь харагдсан байна. Түүнчлэн, хүүхэд, залуучууд асран хүмүүжүүлэгч гэр бүлийн хүрээнд насанд хүрэгчид болон хүүхдүүдэд эерэг харилцаатай байх замаар гэр бүлийн интеграцлалыг бэхжүүлжээ. Асрамжийн гэр бүлүүдийн санал хүсэлт ч маш эерэг байсан бөгөөд хөтөлбөр тэдний хүлээлтээс давсан байна.

4 Дэлгэрэнгүй мэдээллийг www.books.google.co.uk/books?isbn=0195314085 -ээс харна уу.

5 Дэлгэрэнгүй мэдээллийг www.cd hdf.org.mx/images/pdfs/recomendaciones/2009/R200904.pdf and portaldic10.cd hdf.org.mx/index.php?id=sere0409 линкээс харна уу.

Монгол улс

Дүфрэнэ Готьерын Сангийн 2020 онд хэвлэсэн Хүүхдийн эрх, хамгаалал: Практик Үйл ажиллагаа номонд Миний гэр бүл гишүүн нийгэмлэгийн дараах сайн туршлагыг нийтэлсэн байна.

Асрамж, халамжийн газар өсөж буй хүүхдийг өөртөө хариуцлагатай, зөв төлөвшилтэй бие хүн болгон өсгөж хүмүүжүүлэхийн тулд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь хүүхдийн эрх, тэдний үзэл бодол, хэрэгцээг хүндэтгэсэн, бие даан амьдрах ухаанд сургахад нь чин сэтгэлээсээ туслах хүсэл эрмэлзлэлтэй баг хамт олныг бүрдүүлэхээс эхлэх хэрэгтэй. Үүнийг бий болгож чадсан гэсэн итгэл үнэмшилтэй болвол Та, багийнхаа хамтаар гэр бүлд чиглэсэн асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээг хүргэх боломжтой болно. Үйлчилгээг хүргэхдээ дараах асуудлыг анхаарах нь чухал:

1. Хүүхдийн асрамж халамжийн үйл ажиллагаа эрхлэх гэж байгаа бол хүүхдийн сайн сайхан байдалд хүлээсэн үүрэг, хариуцлагаа байгууллага, иргэн, гэр бүл бүр хариуцлагатай биелүүлэх үүднээс Хүүхэд хамгааллын хуульд нийцүүлэн тухайн байгууллага “Хүүхэд хамгаалах бодлого, багшийн болон нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм”-ийг мөрдөн ажиллах шаардлагатай.
2. Асрамж халамжийн төвийн багш, ажилтан бүрт хүүхдийн хамгаалал, гэр бүл түшиглэсэн хүүхэд асрах үйлчилгээний талаар мэдлэг олгож, хүүхдийг үл хайхрах хандахаас урьдчилан сэргийлэх нь чухал.
3. Хүүхдийн аль нэг сул талыг харж ялгаварлан гадуурхахгүй байх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж сэтгэл зүйн хувьд гэмтэлтэй байгаа, өөрийгөө илэрхийлэх чадвар сул хүүхдэд илүү анхаарал хандуулах.
4. Сургуулийн болон амьдарч буй орчных нь үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс хамгаалах.

Эх сурвалж: Дүфрэнэ Готьерын Сан, 2020 он. Хүүхдийн эрх, хамгаалал: Практик Үйл ажиллагаа. 23-р тал. Улаанбаатар.

“Миний гэр бүлийн гишүүн нийгэмлэг” байгууллагаас хүүхдийн асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд гэр бүлийн ээлтэй орчинг бүрдүүлснээр хүүхдийг хөгжүүлж, сэтгэл зүйн төлөвшилтэй, эрүүл мэнд, нийгэмшихүйн чадварт сургах бүрэн боломжтойг нотлосон өөрсдийн үйл ажиллагааны практик, туршлагыг ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн байгууллагуудтай хуваалцсан.

? Мэдлэг шалгах асуултууд

1. Нийгмийн ажлын интервенц, үйлчилгээг үнэлэх үе шатны онцлогийн учир холбогдлын талаар тайлбарлана уу?
2. Кейс менежментийн үйлчилгээнд хяналт шинжилгээ, үнэлгээний учир холбогдлын талаар дурдана уу?
3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журамт хяналт шинжилгээ, үнэлгээний зохион байгуулалтыг хэрхэн тусгаж зохицуулсан бэ?
4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх кейс менежментийн үйлчилгээг үнэлэхэд мэдээллийн эх сурвалжуудаас ямар төрлийн мэдээлэл цуглуулах вэ?
5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх кейс менежментийн үйлчилгээг үнэлэхэд мэдээлэл цуглуулах аргууд юу юу байж болох вэ?


НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

- Батхишиг, А. (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх. In А. Батхишиг, М. Нямдорж, О. Мягмар, Хүүхэд хамгааллын үйлчилгээ (pp. 100-106). УБ: Хөх судар принтинг.
- Батхишиг, А. (2017). Нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх нь. In Г.Түмэннаст, Нийгмийн ажил. Улаанбаатар: МУИС Пресс.
- Батхишиг, А. (2017). Нөхцөл байдлын үнэлгээ. In Г.Түмэннаст, Нийгмийн ажил. Улаанбаатар: МУИС Пресс.
- Батхишиг, А. Нямдорж. М., Н.Баярмаа, А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа. (2022). Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS6949:2021. Улаанбаатар: СХЗГ.
- Батхишиг, А. Өлзийтунгалаг. Х. (2008). Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь. УБ: Бит пресс, ХХК
- Баярмаа, Н. А.Батхишиг, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Д.Амараа. (2022). Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага, MNS6949:2021. Улаанбаатар: СХЗГ.
- Ганбаясгах, Г. Я. М. (2019). Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Дүфрэнэ Готьерын Сан, 2020 он. Хүүхдийн эрх, хамгаалал: Практик Үйл ажиллагаа. Улаанбаатар.
- Жоди Золл Кусек, Р. С. (2004). Үр дүнд суурилсан ХШҮ-ний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам. ДБ Вашингтон хот: ОУСБХ-ийн Банк, Дэлхийн банк.
- Тунгалагтамир, С. Н.Баярмаа, Ж.Шийлэгпүрэв, Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Г.Саранхүү, Г.Ойнбаяр. (2017). Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, MNS 5852:2017. Улаанбаатар: СХЗГ.
- Түмэннаст, Г. (2017). Нийгмийн ажлын интервенц. In Г.Түмэннаст, Нийгмийн ажил. Улаанбаатар: МУИС Пресс.
- Түмэннаст, Г. И. М. (2018). Ажил зуучлал ба хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн кейс менежмент, ГОУХАН. Улаанбаатар: Сод Дресс.
- Түмэннаст, Г. (2017). Нийгмийн ажлын мэргэжлийн үүргүүд. In Г.Түмэннаст, Нийгмийн ажил. Улаанбаатар: МУИС Пресс.
- Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам, НХЯ, ХЗЯ, СЯ, Улаанбаатар 2021
- ХНХЯ. (2017) Холбон зуучлах үйлчилгээний журам. Улаанбаатар.
- ХНХЯ. (2021) Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам. Улаанбаатар. ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ
- ХНХЯ. (2021). Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам. Улаанбаатар: ХНХЯ.

Гадаад хэл дээрх эх сурвалж

- Buia, A. (2012). Alternative forms of care for children without adequate family support: sharing good practices and positive experiences. The proceedings of the ChildONEurope Seminar on out-of-home children. Florence: Istituto degli Innocenti
- Cornell, K. L. (2022, 03 29). History, Theory, and New Directions for Social Work Practice <https://www.semanticscholar.org>. Retrieved from www.semanticscholar.org/paper/Person-In-Situation%3A-History%2C-Theory%2C-and-New-for-Cornell/702d7e68aee638d24882f5e5c47491cb71d1a681
- CPWG. (2014). Inter-Agency Guidelines for Case Management Child Protection. The Role of Case Management in the Protection of Children. Washington DC: CPWG.
- CPWG. (2014). Inter-Agency Guidelines for Case Management Child Protection. The Role of Case Management in the Protection of Children. Washington DC: CPWG.
- DSD. (2012). Assessment tool for children in alternative care, South Africa. Cape Town: UNICEF.
- Erikson, A. (2012). Caring for Child Survivors of Sexual Abuse. Guidelines for health and psychosocial service providers in humanitarian settings. New York: UNICEF.
- Evens, C. A. (1990). Evaluating Your Practice. New York: Springer.
- Florina Balint. (2018). Core Concepts and Principles of Effective Case Management: Approaches for the Social Service Workforce. Cape Town: GSSWA.
- FSA. (2009). Standards of Alternative Care in South Australia. Adelaide: Adelaide.
- Glenn Miles, P. S. (2001). Children in Residential Care and Alternatives. Phnom Penh: Tearfund.
- GovSA. (2019). Assessment Framework to Stakeholders. Sydney: Department for Child Protection.
- ISS. (2012). Moving Toward: Implementing the Guidelines for the Alternative Care of Children. Glasgow: CELCIS.
- LSCP. (2022, 04 01). London Safeguarding Children Procedures and Practice Guidance. Retrieved from <https://www.londonsafeguardingchildrenprocedures.co.uk>: <https://www.londonsafeguardingchildrenprocedures.co.uk>
- Makwanya, M. (2015). National Case Management System for the Welfare and Protection of Children in Zimbabwe, Ministry of Public Service, Labour and Social Welfare of Zimbabwe and UNICEF. Harare: MPSSLW.
- Mark W. Fraser, J. M. (2009). Intervention Research. Developing Social Programs. Oxford University Press.
- Mary Nash, R. M. (2005). Social Work Theories in Action. London: Jessica Kingsley Publishers.
- Moxley, D. (1989). The Practice of Case Management. California: Sage Publications.
- Moxley, P. D. (1989). The Practice of Case Management. California: Sage Publications.
- Nigel Cantwell, J. D. (2012). MOVING FORWARD: Implementing the 'Guidelines for the Alternative Care of Children. Glasgow: Celcis.
- Payne, M. (2014). Modern Social Work Theory. London: Palgrave Macmillan.
- SCSA. (2019). Office-based Services for Children in Alternative Care. Malta. Santa Venera: Public Consultation.
- UNO. (2010). Guidelines for the Alternative Care of Children. A Tool for Reviewing the United Nations Framework with Children. Washington: Fice Youth.
- Yanca, L. C. (2004). Social Work Practice. Generalist Approach. New York: Pearson.



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN
🌐 HairaarUlgerley